# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

# 2007 – 2015




Заанхошуу, 2007



Нээлттэй Нийгэм Форум

Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага

Бодлого судлалын төв

Ихтамир сум

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форум болон Бодлого Судлалын Төвийн дэмжлэгтэйгээр Архангай аймгийн Ихтамир сумын төр захиргаанаас сумынхаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн төлөөлөлтэй хамтран оролцооны зарчмаар энэхүү стратегийг боловсруулав. Нээлттэй Нийгэм Хүрээлэн, «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага», Нээлттэй Нийгэм Форум энэхүү стратегийн агуулга, мэдээллийн баталгаажилт, чанарын талаар хариуцлага хүлээхгүй.

DDC
338.9'517
Э-17

ISBN 978-99929-0-377-5

Хянан тохиолдуулсан: Б.Мөнхсоёл, Ё.Доржбат, З.Ичинхорлоо, В.Дагвийхорол, Б.Эрдэнэбаатар

Эхийг бэлтгэсэн: М.Амгалан
Хавтасны дизайнер: Ц.Одончимэг

Хэвлэсэн газар: «ADMON», Монгол

© Зохиогчийн эрхийг Архангай аймгийн Ихтамир сумын ЗДТГ эзэмшинэ.

# Гарчиг

Өмнөтгөл . . . . . v
Товчилсон үг. . . . . vi
Өмнөх үг . . . . . vii
Оршил . . . . . ix

**Бүлэг 1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн нийтлэг асуудлууд. . . . . 1**

1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол . . . . . 1
1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл. . . . . 3
1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн агуулга, мөн чанар . . . . . 5

**Бүлэг 2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах үйл ажиллагаа . . . . . 7**

2.1. Үндсэн зарчим, арга зүйн асуудлууд . . . . . 7
2.2. Зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ. . . . . 9
2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл . . . . . 13
2.4. Бизнесийн орчны судалгаа . . . . . 14
2.5. СВОТ шинжилгээ . . . . . 15
2.6. Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл . . . . . 16
2.7. Хүлээгдэж буй үр дүн . . . . . 18
2.8. Стратегийг хэрэгжүүлэх . . . . . 19

**Бүлэг 3. Ихтамир сумын танилцуулга . . . . . 21**

3.1. Сум байгуулагдсан түүх. . . . . 21
3.2. Нутгийн удирдлагын бүтэц. . . . . 22
3.3. Газарзүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг . . . . . 23
3.4. Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи . . . . . 25

**Бүлэг 4. Сумын эдийн засгийн тойм: одоо ба хэтийн төлөв . . . . . 28**

4.1. Нийтлэг асуудлууд . . . . . 28
4.2. Төсвийн санхүүжилт, зарцуулалт . . . . . 29
4.3. Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл . . . . . 29
4.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд . . . . . 30

4.5. Зах зээл, маркетинг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 34
4.6. Төрийн ба нийгмийн үйлчилгээ . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 35
4.7. Дэд бүтэц. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 36
4.8. Гадаад харилцаа, хандивлагчдын төсөл хөтөлбөр . . . . . . . . . . . . . . . . . 37

**Бүлэг 5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги . . . . . . . . . . . . 39**

5.1. Бизнесийн орчны судалгааны дүн . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 39
5.2. СВОТ шинжилгээний дүн . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 43
5.3. СВОТ шинжилгээний хослолын матриц. . . . . . . . . . . . . . . . . . . . . . 46
5.4. «Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл» матриц . . . . . . . . . . . . . 47
5.5. Төсөл хэрэгжүүлэлтийн матриц . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 50
5.6. Төслийн эрэмбийн матриц . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 55
5.7. Бизнесийн хөгжлийг дэмжих стратегийн чиглэлүүд . . . . . . . . . . . . . . . 57
5.8. Төслийн товч танилцуулга . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 60

# Өмнөтгөл

Монгол шиг шилжилтийн эдийн засагтай орнуудын хөгжлийн тэргүүлэх зорилгуудын тоонд шинээр төрөн гарч буй хувийн хэвшлийнхэнд зориулж бизнес эрхлэх тааламжтай орчин бүрдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд (ОНЭЗХ) зориулсан нэгдмэл, олон талт төлөвлөгөөг өөрсдийн санаачилгаар боловсруулах явдал ордог.

Сүүлийн жил гаруй хугацаанд Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Нээлттэй Нийгэм Форумаас Монгол улсын 4 суманд орон нутгийн ард иргэдийн цаашдын хөгжлийн хэрэгцээгээ илүү сайн төлөвлөж, удирдах чадавхийг бэхжүүлэх ажлыг санаачилан хэрэгжүүлж байна. Энэхүү «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь» (DELTA) хэмээх төслийг өмнө нь ННХ, Дэлхийн Банкнаас Зүүн Европт хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн хэрэгжүүлсэн юм. Үүний үндсэн санаа нь орон нутгийн хүн амын томоохон бүлгүүд, түүний дотор төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн хамтран хөгжлийн таатай нөхцөл, боломжуудыг шинжлэх, алсын хараа, зорилго, зорилтуудаа тодорхойлох, улмаар тэдгээрт хүрэхэд чиглэсэн тодорхой, ач холбогдол бүхий төсөл, алхмуудыг боловсруулж гаргахад оршиж байсан юм.

Таны өмнө байгаа стратегийн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус төслөөс гарч буй хамгийн анхны биет үр дүнгүүд юм. Харин сумын түвшинд бий болоод байгаа хөгжлийн шинэ түншлэлүүд, тухайн сумдын «бизнес эрхэлж» байгаа шинэ арга барил буюу илүү олныг хамарсан, оролцоот хэлбэр нь нүдэнд тэр бүр ил харагдахгүй үр дүнгүүд юм. Цаашид энэхүү төлөвлөлтийн арга зүйг бусад янз бүрийн шийдвэр гаргах үйл явцад хэрэглэх боломжтой, хэрэглэх ч ёстой юм.

Энэ завшааныг тохиолдуулан Архангай аймгийн Ихтамир сумын ард иргэд, Бодлого судлалын төвийнхөн болон энэхүү стратегийг амжилттай боловсруулахад хувь нэмрээ оруулсан бусад бүх мэргэжилтнүүдэд талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал

Скотт Абрамс
Будапештийн ННХ-ийн Орон нутгийн захиргаа, төрийн албаны шинэчлэлийн санаачилгын Орлогч захирал

# Товчилсон үг

| | |
|---|---|
| ОХАТОНЭХ | Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх |
| ОНЭЗХС | Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |
| ДЕЛТА | «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх» төслийн англи нэрийн эхний үсгийн хураангуй |
| СЭЗХС | Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурал |
| ИТХТ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ННФ | Нээлттэй Нийгэм Форум |
| ОНУТҮШС | Орон Нутгийн Удирдлага, Төрийн Үйлчилгээг Шинэчлэх Санаачлага |
| БСТ | Бодлого Судлалын Төв |
| ННХ | Нээлттэй Нийгэм хүрээлэн |
| ОУБ | Олон улсын байгууллага |



# Өмнөх үг

Дунд хугацааны ирээдүйд манай сум нийгэм-эдийн засгийн хөгжлийн ямар түвшинд хүрэх чадавхитайг бодитойгоор урьдчилан төсөөлөх, үүний тулд өнөөгийн байдлаа сайтар ойлгохын зэрэгцээ дараачийн он жилүүдэд бид хаа хүрч чадах, хаа хүрсэн байхаа үндэслэлтэй тодорхойлох шаардлага бидний өмнө байнга тулгарсаар ирсэн билээ. Энэхүү чухал цаг үед «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх» хөтөлбөрийн хүрээнд Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Нээлттэй Нийгэм Форумаас хэрэгжүүлсэн «Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах – ДЕЛТА» төсөлд хамрагдахаар сонгогдсон нь манай сумын хувьд цаг үеэ олсон нэн завшаантай үйл явдал болсон юм. Дээрхи байгууллагуудаас санхүү, техник ажиллагааны дэмжлэг үзүүлэн, арга зүйн удирдамжаар байнга хангаж ажилласны үр дүнд Ихтамир сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратегийг боловсруулллаа.

Дунд хугацааны хөгжлийн ирээдүйд хүрэхийн тулд зайлшгүй авч хэрэгжүүлэх стратегийн чанартай үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн тогтвортой түншлэл, оролцогчдын хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлан зөв тодорхойлох, хэрэгжүүлэх явдал сумын олон нийтийн төсөөлж буй цорын ганц арга зам мөн гэдгийг бид баттай ойлголоо. ДЕЛТА төслийг хэрэгжүүлсэн явдал үйл ажиллагааны төлөвлөлтийн өмнөх арга барилаас салж, орон нутгийнхны оролцоо, чин эрмэлзэлд тулгуурласан шинэлэг хэлбэрийг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэх том сургууль болсныг онцлон тэмдэглэмээр байна. Зөвшилцөл, хэлэлцүүлэг, хамтын шийдвэр, нээлттэй ярилцлага зэрэг оролцоог хангах арга хэлбэрийг төсөл хэрэгжүүлэхэд өргөн ашиглав. Төслийн үндсэн багаас гадна стратеги боловсруулах үйл явцыг хамтын удирдлагаар хангах, шийдвэр гаргах ба олон нийтийн оролцоог өргөжүүлэх гэсэн хоёр чухал үүргийг стратеги боловсруулах процессийн явцад байгуулж ажиллуулсан Төлөвлөлтийн комисс, ажлын хэсэг зэрэг сумын эдийн засгийн хөгжлийн асуудлыг хариуцах шинэ бүтцээр дамжуулан бүх шатанд хэрэгжүүллээ.

Манай сумын иргэд, олон нийтийн хамтын хүчин чармайлтын шууд үр дүн, хамтын хөдөлмөрийн бүтээгдэхүүн болох стратеги нь бизнесийн орчныг

сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх 38 төсөл, бизнесийн хөгжлийг дэмжих 24 чиглэлийг багтаасан албан ёсны баримт бичиг юм. Манай сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулахад өөрсдийн хүч хөдөлмөрөө сэтгэл харамгүй зориулж, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажилласан ННХ, ННФ, БСТ ба тэдгээрийн ажилтнуудад сумынхныхаа чин сэтгэлийн талархлыг энэ ялдамд өргөн дэвшүүлж байна.

Манай сумын иргэд, байгууллагууд стратегиэс ихээхэн зүйлийг хүсэн хүлээж байгаа нь дотоод ба гадаад нөөц боломж, давуу талаа улам дайчлан эдүгээ оршин буй болон төсөөлөн буй алсын хараандаа хүрэх замд тохиолдож болзошгүй сул тал, саад бэрхшээлийг амжилттай даван туулахын төлөө шаргуу ажиллах ёстойг бидэнд тодорхой ойлгуулж байна. Хүсэн хүлээж буй бүхнийг бодит ажил хэрэг, үр дүн болгож хараахан чадахгүй нь мэдээж. Гэхдээ нөөц бололцоо, чадавхиа зангидан ашиглаж, өөрсдөөс хамаарах бүхнийг хийхийн төлөө тууштай ажиллах болно гэдгээ төрөлх нутаг усныхаа хөгжил цэцэглэлт, бизнесийн орчныг төгөлдөржүүлэн сайжруулахад зохих дэмжлэг үзүүлж ирсэн, дэмжин туслахыг чин сэтгэлээс хүсэн сонирхож буй сумынхандаа болон түншүүд, дэмжигчиддээ батлан илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги нь манай сумынхны бүтээл, бидний өмч билээ. Үзэл баримталын энэ  хүрээнд  авч үзвэл, эдийн засгийн өсөлт бий болгож тогтворжуулах, ЖДҮ-ийг хөгжүүлэх, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, байгаль орчноо хамгаалах, иргэдийнхээ амьжиргааны чанарыг дээшлүүлэх зэрэг хөгжлийн зангилаа асуудлыг амжилттай шийдвэрлэх, сум орны цаашдын хөгжил дэвшлийн баттай эхлэл болсон бизнес орчныг сайжруулах нэн тэргүүний асуудлуудыг тодорхойлж өгснөөрөө стратеги маань онцлогтой боллоо. Домогт Тайхар чулуугаараа алдаршсан манай сумын эдийн засгийн хөгжлийн шинэ стратеги амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэх итгэл, баталгаа чухамдаа эндээс урган гарч байгаа юм.

Хөдөө орон нутагт, түүний дотор манай суманд үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийн хөгжил сулавтар явж ирсний үндсэн шалтгааны нэг нь улсын төсөв хүрэлцээгүй, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаа явдал мөн. Түр хугацааны, амиа аргаацаах төдий зүйлээр хөөцөлдөх нь хөгжил авчрахгүй, эдийн засгийн өсөлтийг хангаж тогтворжуулж чадахгүй гэдэг нь аль хэдийнээ тодорхой болсон асуудал.

Манай сумын төр захиргааны байгууллага, иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, сумын эдийн засаг-нийгмийн хөгжил цэцэглэлтийн тусын тулд бодитой дэмжлэг үзүүлэх чиглэлээр хандивлагчид, хөрөнгө оруулагчид, санхүүгийн ба иргэний нийгмийн байгууллага, иргэд, байгууллагуудын зүгээс гаргах аливаа зөв санаачлага, үйл ажиллагааг бидний зүгээс ямагт халуунаар талархан хүлээн авч дэмжих, хамтарч ажиллах чин эрмэлзэл дүүрэн байгаагаа энэ ялдамд илэрхийлж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэртүгэй.

Архангай аймгийн Ихтамир сумын засаг дарга З.Ичинхорлоо

# Оршил

Монгол улсыг бүхэлд нь хамарсан эдийн засаг-нийгмийн шинэчлэлтийн хүрээнд тус сумын хөгжлийн хүрсэн түвшинг хадгалах, цаашид ахиулах, үр ашгийг нь иргэддээ жигд хүртээхэд сумын төр, захиргааны байгууллага, бизнес эрхлэгчид түлхүү анхаарах явдал хойшлуулшгүй зорилт болж байна. Ирээдүйд хөгжил өргөжин тэлэх суурь болох шинэ зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх асуудал хөгжлийн шинэ зорилготой холбогдон сумынхны өмнө чухлаар тавигдах боллоо.

Зах зээлд шилжих шилжилтийн явцад болон түүний дараах жилүүдэд сумын эдийн засгийн хөгжил, бизнесийн бүтэц, чадавхид олон чухал дэвшил, өөрчлөлтүүд бий болсон бөгөөд энэ үйл явц одоо ч үргэлжилсээр байна. Зах зээлд шилжихээс өмнө төрийн ба хоршооллын өмчийн том аж ахуйнууд үйлдвэрлэл, үйлчилгээнд давамгайлж байсан бол эдүгээ хувийн өмчид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл энэхүү байр суурийг эзэлсэн явдал эдийн засаг, бизнесийн хөгжлийн асуудлыг шинэлэг арга барилаар авч үзэх бодит шаардлагыг бий болгож байгаа хүчин зүйл юм.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг сумын түвшинд хангахад туслалцаа дэмжлэг авах, санхүүжилтийн эх үүсвэр олохын тулд хандивлагчид, хөрөнгө оруулагчдыг татах дорвитой арга хэмжээ хэрэгжүүлж, амьд ажил өрнүүлэх цаг үе ирээд байна. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг орон нутгийн бизнес орчныг сайжруулах чиглэлд улам гүнзгийрүүлэх хэрэгтэй байна.

Сумын төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудаас дүрэм журам, зохицуулалт гаргахдаа сумынхаа эдийн засгийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн тулд бизнес эрхлэгчдээс идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хангах, тэдэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх явдлыг эн тэргүүнд тавьдаг байх зүй ёсны шаардлага төдийгүй шинэ хандлага, шинэ арга барилын үндсийн үндэс болох учиртай.

Сумынхаа бизнесийг идэвхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, хүн амын амьдралын чанарыг тасралтгүй сайжруулахад орон нутгийн бизнесийн өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх шинэ үзэл баримтлал, шинэлэг арга замаар хандах нэн төвөгтэй үүрэг хариуцлагыг орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид өөртөө хүлээх шаардлагатай боллоо.

Ийм нөхцөлд одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг тогтворжуулан чадавхижуулах, шинээр бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг татах харьцангуй таатай нөхцлийг бүрдүүлэх явдлыг сумын захиргаа стратегийн зорилтын хэмжээнд тавьж ажиллах ёстой юм. Цаад агуулгаараа, энэ нь нөөц боломжоо орон нутгийнхаа хөгжлийн төлөө зохистой ашиглах, хэрэглэгчдийн эрэлт таашаалд

нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг зах зээлд гаргах тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдээ оновчтой тодорхойлох, энэ дагуу дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийг иж бүрнээр боловсруулахад сумынхан өөрсдөө ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн үг. Сумын эдийн засгаа амжилттай хөгжүүлж, тогтворжуулах асуудалд ийн хандваас бүх боломж, нөөцөө хамгийн ухаалгаар үр өгөөжтэй ашиглах арга замаа олж сая чадна.

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги (ЭЗХ)-ийн зорилго, зорилт, төслүүдийнхээ харилцан уялдааг сайтар хангах асуудлыг олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үндсэн дээр гүйцэтгэх, түншүүд, оролцогчдын чадавхи, чин эрмэлзлийг тусгасан байх зарчмыг стратеги боловсруулах явцад барьж ажиллав. Ийнхүү нийтээр чармайн ажиллаж замаар сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах ажлаа амжилттай дуусгалаа. Эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд сумынхны бүх бүлэг, давхарга өөрийн оролцоо, хувь нэмрээ оруулах боломжийг энэ стратеги бүрдүүлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.



# БҮЛЭГ 1

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН НИЙТЛЭГ АСУУДЛУУД

## 1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол

Юуны өмнө, сумын эдийн засгийн хөгжлийн иж бүрэн стратегитэй болсон явдал ДЕЛТА төслөөс тус суманд үзүүлсэн бодитой дэмжлэгийн шууд үр дүн мөн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумын удирдлага, бизнес эрхлэгчид, иргэд орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлаар «ямар ч түвшинд хүнтэй нүүр улайхгүй тулж ярих, хэлцэх» нэн чухал боломжоор хангагдлаа хэмээн стратегийнхээ ач холбогдлыг зангидан томъёолж байна. Сумынхны хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлийг тусгасан «Эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги» нь хөгжлийн асуудлаар өргөн хүрээтэй түншлэл, хоршилт, хамтын ажиллагааг өрнүүлэх хэтийн удирдамж болохоос гадна сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн явц, өрнөлийг үнэлэх, дэвшигдэн буй

шинэ зорилго, зорилтыг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлон шийдвэрлэж байх шаардлагад төгс нийцсэн баримт бичиг болж чадсан юм.

Сумын хөгжлийн ирээдүйн чиг баримжаатай холбоотой үзэл баримтлалын ба стратегийн чиглэлүүдийг тодорхойлох, шинэчлэн томъёолох хэрэгцээ шаардлага цоо шинээр гарч ирээгүй, ДЕЛТА төслөөс өмнө ч гэсэн яригддаг байсан билээ. Хамгийн гол нь сумын төр, захиргааны ба орон нутагт төрийн үйлчилгээ эрхлэх байгууллагуудын хувьд олон жилийн өмнөөс тулгамдсаар ирсэн энэ асуудлыг зохистой шийдвэрлэж хараахан чадаагүй явж ирсэнд хэргийн учир оршиж байгаа юм. Энэ талаас нь авч үзвэл, ДЕЛТА төслийг манай суманд хэрэгжүүлсэн нь цаг үеэ олсон чухал үйл явдал болсон билээ.

Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах, орон нутгийн бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах орчинг бүрдүүлэх, орон нутгийн бизнесийг дэмжихэд сумын удирдлагын зүгээс тавьж буй хүчин чармайлтыг оновчтой чиглүүлэх асуудал бодитой тулгарахын цагт үр өгөөжтэй, хэрэгжих боломжтой стратегийг хэтийн баримжаатай боловсруулах арга зүйн ба мэргэжлийн дэмжлэг, мэдээлэл дутагддаг, тэр чинээгээр сумын хөгжил удаашрахад хүрдэг байсан юм.

Орон нутгийн эдийн засгийг зах зээлд нийцүүлэн салбарлуулан өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг зохистой өөрчлөх талаар сумын төр, захиргааны зүгээс зохих хүчин чармайлт тавьж ирсэн билээ. Хамгийн гол нь бүтээлч түншлэл, өргөн хамтын ажиллагааны хүрээнд сумын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зохистой механизм бий болгох, зах зээлийн зөв гольдролд оруулахад тэдгээр арга хэмжээ төдийлэн үр бүтээлтэй болж чадаагүй юм.

Эдүгээ суманд байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес тэр бүр санасан хэмжээгээр өргөжин тэлэхгүй, шинээр бизнес эрхлэх санаачлага оролдлого бүхэн ажил хэрэг болж хараахан чадахгүй байгаа нь бизнесийн өсөлтийг дэмжих санхүүгийн найдвартай эх үүсвэр дутмаг байгаатай холбоотой. Түүнээс гадна бизнес эрхлэх орчин нь бизнесийн чадавхийг дээшлүүлэхэд тэр бүр тааламжтай бус байгаа явдал зохих сөрөг нөлөөтэй гэж дүгнэж болно.

Ер нь сумын төр, захиргаа нь эдийн засгийн хөгжил, бизнесийн дэвшлийг идэвхгүй ажиглагч юм уу хөндлөнгөөс шууд оролцогч биш, харин эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх гол нөхцөл болох бизнесийг хөгжүүлэхэд эрхзүйн зохицуулалт, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлдэг, үйл ажиллагаандаа хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэхийг бүх талаар эрмэлздэг, өөрөө санаачилдаг, олон нийтийг манлайлан чиглүүлдэг түнш байхыг туйлаас эрхэмлэх цаг ирээд байна.

Сумын төр, захиргаа нь янз бүрийн сонирхол бүхий бизнесийн ба иргэний нийгмийн бүлгүүдийг хөгжлийн асуудал дээр зохион байгуулж төвлөрүүлэх, хамтран ажиллах арга хэлбэрээр тэднийг дэмжих бүрэн чадавхитай байгууллага мөн болохыг стратеги боловсруулах явцад хуримтлуулсан туршлага маань харууллаа. Олон улсын байгууллагаас үзүүлсэн дэмжлэгийн ачаар орон нутагтаа бизнесийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулахад шинэ механизмаа тодорхойлж авлаа, шинээр сэтгэх, ажиллах нэн таатай нөхцөл бүрдлээ.

ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхэд оролцсон хандивлагч ба хэрэгжүүлэгч байгууллагууд, төслийг гүйцэтгэгчид бидний хамтын чармайлтаар бүтсэн эдийн засгийн хөгжлийн стратеги маань манай сумын эдийн засаг, бизнес цэцэглэн хөгжих баталгаа болж чадсан гэдэгт гүнээ итгэж байна.

## 1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл

Сумынхнаа олон нийтийн чин эрмэлзэлд тулгуурлан тэдний идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр анх удаа боловсруулсан сумын ЭЗХ-ийн стратеги нь орон нутгийн эдийн засаг ба бизнесийн хөгжлийг дэмжих орчинг боловсронгуй болгох талаар тулгамдаж буй болон ирээдүйн чиг хандлагатай холбоотой нэн тэргүүний асуудлыг оролцооны зарчимд тулгуурлан тодорхойлох хамгийн дөхөмтэй, хэрэгжих боломжтой арга замыг эрэлхийлсэн хамтын хүчин зүтгэлийн үр дүн билээ. Тэргүүлэх ач холбогдолтой хэмээн хамтаараа тодорхойлсон зорилгоо амжилттай хэрэгжүүлснээр стратегийн үр шимийг олон нийтэд хүртээх, олон нийтийн зүгээс зүй зохистой хүртэх суурь нөхцлийг бүрдүүлж чадах юм.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төрийн үйлчилгээг сумын төр, захиргаанаас хэрэгжүүлж буй арга зам, хэлбэр нь эргээд эдийн засгийн дотоод боломж, давуу байдал, гадаад таатай нөхцлийг аль болох өгөөжтэй ашиглах, бизнесийг тогтоон барих, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр явуулах үйл ажиллагааны чанар, үр дүнд шууд болон дам нөлөө үзүүлдэг, тэр чинээгээр орон нутгийн эдийн засаг, бизнест зайлшгүй харгалзах хүчин зүйл юм.

Бизнес эрхлэгчид, байгууллага, иргэдэд тэгш үйлчлэх зохистой орчинг бүрдүүлэх явдал төр, захиргааны үндсэн зорилго мөн. Үнэн чанартаа аливаа бизнесийн хүрээ, түүний хэмжээ далайц бол бизнеийн орчныг бизнестэй холбодог хүчин зүйл хараахан биш. Энэ ч учраас сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах явцад өмчлөл, зохион байгуулалтын хэлбэр, хэмжээгээр нь ялгаварлахүйгээр үйлдвэрлэл,

үйлчилгээ явуулж буй иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах нийтлэг зарчмыг сумын төр, захиргаанаас баримталсан болно.

Орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сумын эдийн засгийн хөгжилд таагүй нөлөөлж байгаа, нөлөөлж болзошгүй орчны болон бусад хүчин зүйлсийг залруулах, зөөлрүүлэх, саад бэрхшээл, эрсдэлийг багасгах, даван туулах арга замыг агуулгын болоод хэлбэрийн хувьд оновчтой сонгоход стратегийн үндсэн баримжаа чиглэсэн болно. Стратегийн гол томъёолол, бүтцийг эцэслэн боловсруулахаас өмнө явуулсан бизнес орчны судалгаа болон СВОТ шинжилгээ нь эдийн засаг, бизнесийн хөгжлийн одоогийн байдал, хүрсэн түвшинг тодруулах, хэтийн чиглэл хандлагын талаар сумынхны үнэлэмж, төсөөллийг харуулсан суурь мэдээлэл бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Сумын төр, захиргаа болон олон нийтийн хамтын хүчин чармайлтын бодит үр дүн, эдийн засгийн хөгжлийн илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө иргэд, бизнесийнхэн, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, ирээдүйн тухай санал төсөөллийг төлөөлж байгаа гэдэг үндэслэлээр бидний боловсруулсан дунд хугацааны стратегийн агуулгыг нь тодорхойлох боломжтой.

Сумынхаа орчмын бүс нутгийн хүний ба байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн төлөв байдал, соёл, түүхийн өв сан зэрэг чухал ач холбогдол бүхий хэд хэдэн хүчин зүйлсийг стратеги боловсруулахад харгалзан үзсэн болно. Эцэст нь, манай сумын харьцангүй давуу талууд, олон нийтийн идэвх зүтгэл, чин эрмэлзэлтэй холбоотой аливаа боломж бүхнийг стратегид тусгахыг эрмэлзлээ.

«Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай» хуулийн 8 дугаар зүйлийн 1-д «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ...нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж...», «Сум, дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй», мөн хуулийн 18.1.2-ийн «а»-д «нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;» хэмээн заасан нь сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах эрх зүйн үндэслэл болж өглөө.

Хувийн хэвшлийнхнээс ихээхэн идэвх чармайлт, санаачлага гаргаж сумын төр захиргаатай хамтран ажиллаагүйсэн бол стратеги боловсруулах тухай бодохын ч хэрэггүй байсныг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Стратеги боловсруулах үйл ажиллагаа нь өөрөө сумынхны дунд зохих хүлээлт бий болгосон төдийгүй хүлээлтээ амжилттай, бодит үр өгөөжтэй ажил хэрэг болгох, стратегийг үр дүнтэй

хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын талаар энэ ажилд оролцсон, хувь нэмрээ оруулсан хүмүүс нийтлэг ойлгоцтой боллоо.

Бүтээлч хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр жимс болсон стратеги маань амжилттай хэрэгжинэ гэдэгт сумын төр, захиргааны байгууллага, иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд бүрэн итгэж байна. Стратегид тусгасан төсөл, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээ үр дүнтэй хэрэгжүүлэх замаар алсын хараа, зорилго, зорилтдоо хүрэхэд байгаа нөөц боломжоо туйлын зохистой хуваарилан ашиглах болон чадавхи, давуу талаа хариуцлагатай зохицуулах асуудал олон нийтэд үр өгөөжийг хүртээх боломжийг хангах талаасаа нэн чухал гэдгийг цохон тэмдэглэж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2007 оны долоодугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Ихтамир сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацаа (2007-2015)-ны стратегийг хэлэлцэн сумын хөгжлийн дунд хугацааны хөгжлийн чиг баримжаа, ялангуяа бизнес хөгжих орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган сайжруулах алсын харааг оновчтой томъёолж, энэ хүрээнд стратегийн зорилго, зорилтууд, төслүүдийг зөв тодорхойлж чадсан гэж үзээд санал нэгтэй сайшаан баталсан болно.



## 1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн мөн чанар, агуулга

Бизнесийн орчинг цаашид улам сайжруулж, боловсронгуй болгоход олон нийтийн оролцоо, хүчин чармайлтыг дэмжин идэвхжүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хандивлагчид, хөрөнгө оруулагчдаас дэмжлэг туслалцаа үзүүлж болох гол чиглэлүүдийг оролцооны зарчмаар тогтоосон явдал стратегийн үндсэн агуулгыг тодорхойлж байна. Орон нутагтаа бизнес хөгжүүлэх орчныг сайжруулахад тулгамдаж буй цаг үеийн ба хэтийн шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаархи олон нийтийн мэдлэг, хандлага дээр тулгуурлан стратегийг боловсруулсан нь түүний мөн чанарыг илэрхийлнэ.

Арга зүйн хувьд орон нутгийн эдийн засгийн хөгжлийг төлөвлөхөд баримталж байгаа сүүлийн үеийн үзэл баримтлал, онол-практикийн үндсэн асуудлуудыг стратеги боловсруулах ажиллагааны бүх шатанд харгалзсан болно.

Ихтамир  сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн гол зарчмыг товчлон тодорхойлбол:

- Дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг хангах асуудлыг сумын төр, захиргаа, иргэд, бизнесийн ба олон нийтийн байгууллагатай бүх түвшинд холбох замаар эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг чанаржуулах,
- Бизнесийг өргөжүүлэх, салбарлуулан хөгжүүлэх, шинээр бизнес эхлэхэд бизнесийн орчноор дамжуулан сумын төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгтэй холбоотой төслүүдийг оролцогчдын туршлага мэдлэг, санал төсөөлөл дээр үндэслэн тодорхойлох,
- Орон нутгийн бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нэгтгэх замаар хөгжлийн алсын хараа, нийтлэг зорилгоо стратегийн хэлбэрээр тодорхойлох жишээг сумын олон нийтэд бодитойгоор харуулах,
- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн дэвшлийг хангах, өсөлт бий болгох, олон нийтийн бүтээлч оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэхэд оролцогчдыг хөтлөх хэрэглүүр болох талаас нь стратеги төлөвлөлтийг таниулан ойлгуулах,
- Санхүүгийн ба техникийн дэмжлэг үзүүлдэг хандивлагчид, хөрөнгө оруулагчдад хандах, нөлөөлөх арга хэрэглүүр болгон ашиглах үндэслэл, боломжтой нь холбон стратегийг хүлээн авах нийтлэг хандлага ойлголтыг олон нийтийн дунд бэхжүүлэх,
- Хамтач уур амьсгалыг бэхжүүлж, нээлттэй, ажил хэрэгч байдлыг хангах, эдийн засаг, бизнесээ цэцэглүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй орчинг бүрдүүлэх зэрэг болно.



# БҮЛЭГ 2

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1. Үндсэн зарчим, арга зүйн асуудлууд

Олон нийтийн идэвхтэй, чин эрмэлзэлт оролцоог хөхүүлэн дэмжих янз бүрийн арга хэрэгслийг ашиглах боломжийг хангах үндэслэлээр сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ зорилгоор бий болгосон албан ёсны бүтцийн хүрээнд болон нээлттэй хэлэлцүүлэг, зөвшилцөл зэрэг бусад арга хэмжээгээр дамжуулан олон нийтийг энэхүү үйл ажилллагаанд бүтээлчээр оролцуулж чадсан юм. Олон нийтийн саналын үндсэн дээр сумын эдийн засаг, бизнесийн хөгжил, тогтвортой өсөлтийг хангах нийтлэг ба гол гогцоо асуудлаа хамтын оюун ухаанаар тодорхойлох зарчмыг хангахад стратеги боловсруулах үйл ажиллагааг бүхэлд нь чиглүүлэв.

***А. Үндсэн зарчим.*** Ихтамир сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулахад баримталсан гол зарчмууд:

- Эдийн засгийн өсөлт, бизнесийн хөгжлийг нийгмийн амьдрал, байгаль орчин, иргэдийн амьжиргааны чанарын тулгамдсан асуудлуудтай холбох, зөв тэнцвэржүүлэх,
- Орон нутгийн бизнесийн хөгжил, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулахад сумын төр, захиргааны байгууллагаас гүйцэтгэх үүргийг тодорхой болгох,
- Эдийн засгийн ололт, бий болсон өсөлтийг тогтворжуулахад төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Стратеги төлөвлөлтийг олон нийтийг хамарсан бүтээлч үйл ажиллагааны хэлбэрээр сумын түвшинд зохион байгуулж зангидах,
- Одоо байгаа бизнесийг дэмжих, орон нутагтаа тогтоон барих асуудлыг шинэ бизнес бий болгохтой эн тэнцүү авч үзэх,
- Гадаад эх үүсвэр, хүчин зүйлд дулдуйдахыг эрмэлзэхээс илүү дотоод нөөц боломжоо энэ чиглэлд дайчлахад анхаарах,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сумын эдийн засгийн хөгжлийн асуудлаар бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэрэглүүр болгон ашиглах,

***Б. Арга зүйн асуудлууд.*** Сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулах ажлыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөрөөс Дэлхийн Банктай хамтран боловсруулж Албани, Косово зэрэг орны хэд хэдэн хотын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэж баталгаажсан арга зүйгээр гүйцэтгэлээ. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах үйл ажиллагааг процессийн хувьд зөв зохион байгуулахад нэн зохимжтой, эмх цэгцтэйгээс гадна бизнесийн хөгжлийн орчинг бодлого, зорилготой сайжруулахад чиглэгдсэн алсын хараа, зорилго, зорилт, түүнчлэн төслүүдийг дунд хугацааны баримжаатайгаар олон нийтийн дунд харилцан ойлголцолд тулгуурлан боловсруулахад тохиромжтой хэмээн энэхүү арга зүйг сонгосон болно.

Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг стратеги боловсруулах арга зүйн хүрээнд хамтруулан хэрэгжүүллээ. Юуны өмнө бизнес хөгжихөд ахиц өөрчлөлт авчрах тэнцвэржсэн орчин бүрдүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгоход сумынхны хүчин чармайлт, байгаа нөөц боломжийг уялдуулан зохицуулах асуудал стратеги боловсруулах арга зүйн үндэслэл болсон юм.

## 2.2. Зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ

Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын зарчим нь сумын ЗДТГ, төслийн үндсэн багаас гадна олон нийт, оролцогчдыг стратеги боловсруулах үйл ажиллагаанд түншлэлийн журмаар, зохион байгуулалттайгаар шууд оролцуулах боломжийг хангахад чиглэгдсэн болно.

Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээтэй холбогдсон арга хэмжээг хариуцсан бие даасан төлөөллийн бүтцийг сумын ИТХ юм уу Засаг даргын шийдвэрээр томилж ажиллуулах замаар иргэдийн оролцоог үндсэнд нь хангалаа.

***Төлөвлөлтийн Комисс***

Төлөвлөлтийн комиссыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны нэгдүгээр сар 9-ний өдрийн хуралдааны тогтоолоор томилон ажиллуулсан билээ. Засаг даргаар ахлуулсан тус комисс стратеги боловсруулах ажлыг зохицуулалт, удирдамжаар

СЭЗХ–ийн стратеги боловсруулахад оролцсон төлөөллийн бүтэц



хангах, ажлын явц, стратегийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад гол үүрэг гүйцэтгэсэн юм. Сумын эдийн засаг-бизнесийн хөгжлийн асуудлаар зөвшилцөх, шийдвэр гаргахад оролцох мэдлэг туршлага, чин хүсэл зэргээр нь хүмүүсийг сонгож, төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүнд оруулсан болно.

Сумын засаг дарга болон ИТХ-ын дарга, сумын үндсэн багийн гишүүдээс гадна комиссын удирдлагын дор байгуулагдсан ажлын хэсэг тус бүрээс 2-3 хүнийг бүрэлдэхүүнд нь оруулж энэ комиссыг байгуулсан юм.

Төлөвлөлтийн комисс нь стратеги боловсруулах үйл ажиллагааг зохицуулахаас гадна төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхтэй, чин эрмэлзэлтэй оролцоог хангах, тэдний дунд өргөн хүрээтэй ярилцлага, зөвшилцлийг олон хэлбэрээр зохион байгуулах, өрнүүлэхэд анхаарч ирлээ. Энэ комисс стратегийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт үнэлгээгээр хангах, шаардлагатай засвар өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн шийдвэр гаргах чиглэлээр ДЕЛТА төсөл дууссаны дараа үргэлжүүлэн ажиллах юм.

**Төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүн:**

1. **З.Ичинхорлоо**
   Сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч
2. **В.Дагвийхорол**
   Өндөр уулын бүсийн эрдэм шинжилгээний салбарын захирал, доктор
3. **М.Одонтуяа**
   Төрийн сангийн төлөөлөгч
4. **И.Оюунцэцэг**
   Бизнес эрхлэгч
5. **Ө.Нямцэрэн**
   Өдөр настан
6. **А.Дарамбазар**
   «Ногоон алт» төслийн сумын зохицуулагч
7. **Н.Осорбазар**
   Байгаль орчны байцаагч



8. **В.Мухлааш**
   ЗДТГ-ын дарга
9. **Ч.Алтанцэцэг**
   «Могой Толгой» хувийн мал эмнэлгийн эрхлэгч
10. **Б.Оюунгэрэл**
    Ахлах сургуулийн захирал

***Төслийн үндсэн баг***

СЭЗХ-ийн стратеги боловсруулах энэ бүтцийн цөм болж ажилласан төслийн үндсэн баг нь СЭЗХ-ийн стратеги боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, засвар өөрчлөлт оруулах үндэслэл санал боловсруулах асуудлыг хариуцан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах болно. Төслийн үндсэн баг нь төсөл хэрэгжүүлэгч ба гүйцэтгэгч байгууллагууд, түншүүд болон эдийн засгийн хөгжлийн асуудлыг сонирхон оролцох хүсэлтэй иргэд, байгууллагуудтай хамтран ажиллахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болно. Төслийн үндсэн багийг Засаг даргын захирамжаар дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллууллаа.



1. **З.Ичинхорлоо**
   Төслийн үндсэн багийн ахлагч,
   Засаг даргын орлогч
2. **В.Дагвийхорол**
   ӨУБЭШХ-ийн захирал, доктор
3. **М.Одонтуяа**
   Төрийн сангийн төлөөлөгч
4. **И.Оюунчимэг**
   Бизнесийн төлөөлөгч
5. **Б.Түвшинтунгалаг**
   Бизнес хөгжлийн албаны менежер

Ня-бо, эдийн засагч, багш, худалдааны мэргэжилтэн, малзүйч зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг төслийн үндсэн багт оруулсан нь стратегийг иж бүрэн боловсруулахад чухал ач холбогдолтой болов.

***Ажлын хэсэг***

Сумын хөгжлийн стратеги боловсруулахад зөвлөх үүрэгтэй ажлын 4 хэсэг байгуулж төлөвлөлтийн комиссын шууд удирдлагын дор ажиллуулав. Ажлын хэсэг бүр янз бүрийн төлөөллийг оролцуулсан 10-аас дээш гишүүнтэй, дотроо сумын ИТХ-аас 2-оос доошгүй хүнийг ажлын хэсэг бүрт заавал оруулах зарчим баримтлав. Төслийн үндсэн багийн нэг гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллав. Ажлын хэсэг байгуулсан гол зорилго нь олон нийтийн оролцоог төлөөллийн журмаар хангах боломжийг өргөжүүлэх явдал байлаа. Ийнхүү ажлын хэсгүүд олон нийтийг ДЕЛТА төслийн суман дахь баг, бүтцүүдтэй холбох үүргийг чухлаар гүйцэтгэж ирлээ.

**Төрийн удирдлагын ажлын хэсэг:**

1. **З.Ичинхорлоо**
   Сумын Засаг дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгч.
2. **Ж.Дашзэвэг**
   ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
3. **Н.Сэмжидпэрэнлий**
   Эрдэнэтолгой багийн Засаг дарга
4. **Т.Ганболд**
   Борт багийн Засаг дарга

5. **Ц.Сэнгээ**
   Хөхнуур багийн Засаг дарга
6. **Д.Тэгшжаргал**
   ЗДТГ-ын байгаль хамгаалагч
7. **Ч.Тэгшжаргал**
   Бугат багийн Засаг дарга
8. **Б.Батнасан**
   Хан-Өндөр багийн засаг дарга
9. **В.Мухлааш**
   ЗДТГ-ын газрын дарга
10. **Н.Зоригтбаатар**
   Бугат багийн ИНХ-ын дарга
11. **О.Алтантариа**
   ЗДТГ-ын ня-бо
12. **Д.Нямжаргал**
   Багийн засаг дарга



**Бизнесийн төлөөллийн ажлын хэсэг:**

1. **И.Оюунцэцэг**
   Бизнес эрхлэгч
2. **Д.Ядамдорж**
   Патент эзэмшигч
3. **М.Должинсүрэн**
   Жижиг бизнес эрхлэгч
4. **М.Лхамрагчаа**
   НИК-ийн салбарын эрхлэгч
5. **Д.Рэнцэнжүгдэр**
   Бизнес эрхлэгч
6. **С.Амаржаргал**
   Бизнес эрхлэгч
7. **И.Дэлгэрсайхан**
   Эрчим хүчний салбарын эрхлэгч
8. **С.Долгормаа**
   Бизнес эрхлэгч
9. **Д.Төрбат**
   МЦХК-ийн салбарын эрхлэгч



10. **Н.Мөнх-Эрдэнэ**
   Хас банкны төлөөлөгч
11. **Д.Лонжидсүрэн**
   Мал эмнэлгийн хоршооны эзэн
12. **Г.Лхагвасүрэн**
   «Шинэ-Өргөө» ХХК-ийн захирал
13. **Б.Лхагвасүрэн**
   «Ар Чандага» хоршоо

**Төсөвт байгууллагын ажлын хэсэг:**

1. **В.Дагвийхорол**
   ӨУБЭШС-ын захирал, доктор
2. **Б.Оюунгэрэл**
   Ахлах сургуулийн захирал
3. **Н.Наранцэцэг**
   Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
4. **Ж.Баасансүрэн**
   Байгаль хамгаалагч
5. **Д.Шархүү**
   ӨУБЭШС-ын ажилтан, доктор
6. **М.Пүрэвдорж**
   Усны харуул



7. **Д.Нарантуяа**
   БОХ-ын байцаагч
8. **Б.Тунгалагсайхан**
   Байгаль хамгаалагч
9. **Б.Оюунбилэг**
   Бугат багийн хүний эмч
10. **Ч.Алтанцэцэг**
   «Могой толгой» мал эмнэлгийн эзэн
12. **Д.Цэрэндэжид**
   Ахлах сургуулийн багш

**Олон нийтийн төлөөллийн ажлын хэсэг:**



1. **М.Одонтуяа**
   Төрийн сангийн төлөөлөгч
2. **Ё.Эрдэнэбат**
   ЗДТГ-ын ХХАА-н түшмэл
3. **Н.Лхагважав**
   ӨУБЭШС-ын ажилтан, доктор
4. **Ц.Энхбаяр**
   ИТХ-ын нарийн бичгийн дарга
5. **А.Дарамбазар**
   «Аривжих сайжрах» ТББ-ын захирал
6. **Б.Түвшинтунгалаг**
   БХА-ны менежер
7. **Ш.Оюунжаргал**
   ӨУБЭШС-ын ажилтан
8. **Г.Бадарч**
   Ахмадын холбооны дарга
9. **Д.Дэлгэрмаа**
   Орон нутгийн сургагч багш
10. **Ө.Нямцэрэн**
   Өндөр настан
11. **Ж.Бямбадорж**
   Ахлах сургуулийн багш
12. **Э.Онон**
   ЗДТГ-ын хүн ам зүйч

## 2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл

Сумын эдийн засаг-бизнесийг хөгжүүлэх олон нийт хүлээн зөвшөөрсөн, хэрэгжих боломжтой чиглэлүүдийг үзэл баримтлал сайтай, хэтийн баримжаатай, чанартай боловсруулах явдал сумын төр захиргааны хувьд нэлээд тулгамдсан асуудал байсаар ирсэн билээ. Гэхдээ хөгжлийн стратегиэ ямар арга зүйгээр боловсруулахаа бүрэн гүйцэд төсөөлж чадаагүй, сумынхаа иргэд, байгууллагуудыг оролцуулах арга замаа үндэслэлтэй төлөвлөөгүй явж ирсэн тал байсныг ил тод хэлэх нь зүйтэй. Сумын эдийн засгийн хөгжлийн асуудлыг дан ганц захиргааны үүрэг, хариуцах

ажил мэтээр ойлгодог явдал олон нийтийн дунд түгээмэл байсны дээр тэд өөрсдөө энэ үйл ажиллагаанд оролцож, хувь нэмэр оруулах иргэний үүргээ төдийлэн сайн ухаараагүй явж ирсэн юм.

Сумынхаа хөгжлийн үйл явцад хувь нэмрээ оруулах иргэний мэдлэг ойлголтыг батжуулах, чин эрмэлзлийг дэмжихэд төслийн эхнээс анхаарч зохих арга хэмжээ авч ирлээ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн эхний шатны арга хэмжээ болох бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээ нь иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн олон төлөөллийг хангалттай хэмжээнд хамарч чадсан юм. Түүнчлэн олон нийтэд ойлголт өгөх, оролцоог өрнүүлэх арга хэмжээг уулзалт, ярилцлага, багийн иргэдийн хурал зэрэг арга хэмжээний үед таниулан сурталчлах, мэдээлэл гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах зэргээр хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнд сумынхаа иргэдийн дийлэнхид нь тодорхой мэдээлэл хүрсэн нь төслийн ажил анхнаасаа оролцоог сайтар хангаж, олон нийтийг идэвхжүүлж чадсаныг гэрчилнэ.

Сумынхаа ЭЗХ-ийн стратеги боловсруулахад төр захиргаа, бизнес эрхлэгчид, төрийн үйлчилгээний болон олон нийт, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хувь хүмүүс зэрэг нийтдээ 60 шахам хүн албан үүргийнхээ дагуу болон төлөөллийн журмаар шууд оролцов. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажил, арга хэмжээнд аль болох олон байгууллага, хүнийг оролцуулахыг байнга хичээж ажилласны үр дүнд хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт орж, төсөл, түүний үр дүнг жинхэнэ «өмчлөгчид» болохоо ойлгох, мэдрэх чухал нөхцлийг бүрдүүлж чадсан гэж үзэж байна.



## 2.4. Бизнесийн орчны судалгаа

Бизнесийн орчны судалгаа явуулах, түүний үр дүнг сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн олон жилийн статистик үзүүлэлтүүдээр баталгаажуулах нь сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадвар, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлыг үндэслэл, баримжаа сайтай тодруулах хамгийн боломжтой арга хэрэгсэл юм.

Бизнесийн орчны судалгааны хүрээнд бизнесийн хөгжил, орон нутгийн бизнесийг дэмжих үйл ажиллагаа явагдаж буй орчны асуудлаар оролцогчдын санал бодол, үнэлэмжийг судлах санал асуулгыг таван бүлэгт хамаарах 41 асуултаар явуулснаас

гадна сумын эдийн засгийн үндсэн статистик үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг сүүлийн 5-10 жилийг хамруулан цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Бизнесийн орчны судалгааны дүнг СВОТ шинжилгээ хийх, цаашилбал бизнес орчны талаар сумын ЭЗХ-ийн стратегид тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг томъёолох суурь материал болгон ашиглав.

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд сумын төр захиргааны зүгээс эдүгээ гүйцэтгэж буй үүргийг хувийн хэвшлийнхний үнэлгээнд тулгуурлан тодорхойлсон явдал энэ судалгааны нэг чухал үр дүн болсон юм. Тухайлбал:

1. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн санал дүгнэлтийг ул суурьтай таньж ойлгоход шаардлагатай мэдээ, тоо материал, баримт мэдээл цуглуулах
2. Сумын эдийн засаг-нийгмийн амьдралд оршин буй давуу ба сул талууд, бизнесээ өргөжүүлэх, өсөлт бий болгох, хадгалахад бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлуудтай холбоо бүхий мэдээ баримт хуримтлуулах
3. Бизнесийн орчинг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тухай бүр нь мэдэрч ажиллахын тулд орон нутгийнхны үнэлэмж, санал бодлыг судлах зэрэг болно.

Энэ судалгааг бүх шатанд амжилттай зохион байгуулж явуулахад бид бүх талаар анхаарч ажилласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумынхаа бизнес эрхлэгчдийг энэ судалгаанд өргөн хамруулсны дээр тэдний гаргасан санал зөвлөмжийг ЭЗХ-ийн стратегид тусгасан явдал орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх шаардлага, арга замын талаар нийтлэг ойлголтод хүрэхэд чухал түлхэц өгсөн юм. Ийм байдлаар сумын эдийн засгийн өсөлтөд жинтэй нөлөө үзүүлсээр ирсэн, цаашдаа ч энэ нөлөө нь улам өсөх бизнесийн бүлгүүдийн санал үнэлэмжийг сумынхаа ЭЗХ-ийн стратегид тусгах үндсэн мэдээллээр хангаж өгсөнд бизнес орчны судалгааны ач холбогдол оршиж байгаа гэж үзэж буй болно. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг тогтворжуулах сумын ЭЗХ-ийн стратегийг байнга хянан сайжруулах урт хугацааны удирдамж болох талаасаа бизнесийн орчны судалгааны үр дүн, дүгнэлтүүд чухал ач холбогдолтой юм.

## 2.5. СВОТ шинжилгээ

Бизнес орчны судалгааны дүнг задлан шинжлэх, сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх стратегийн чиглэлүүдийг тогтоох зорилгоор СВОТ шинжилгээг явууллаа. Сумын бизнес эрхлэгчдэд

тулгарч байгаа гол асуудлуудыг тодорхойлж, эерэг болон сөргөөр илэрч болох бүх талууд, тэдгээрийн зохистой шийдлийг хослолоор зэрэгцүүлэн томъёолоход СВОТ шинжилгээний зорилго, хандлага чиглэгдсэн болно. Ингэснээр төсөөлөн буй зорилгодоо хүрэх хамгийн зохистой, хэрэгжих хувилбарыг сонгох болон сумын ЭЗХ-ийн стратегийг дээр дурьдсан хандлагад тулгуурлан боловсруулах үндэслэлийг тодорхойлж чадлаа.

Давуу тал ба боломжийг өндөр үр дүнд хүрэх стратегийн ирээдүйн чиглэл гэдэг агуулгаар авч үзэн нягтлан тодруулахад СВОТ шинжилгээ чухал хэрэглүүр болж өглөө. Үүний чацуу оршин буй сул тал ба саад бэрхшээлийг даван туулахын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойллоо. Сумын эдийн засгийн хөгжил, бизнес орчны өнөөгийн байдлыг нарийвчлан үнэлэх, эдийн засгийн хөгжлийн стратегийн гол шийдлийг СВОТ шинжилгээгээр тогтоолоо

СВОТ шинжилгээг хийхдээ бизнес орчны судалгаанаас гарсан дүгнэлтийг сумын олон нийтээр хэлэлцүүлсэн дүн, эдийн засгийн холбогдох судалгаанд илүүтэй түшиглэсэн болно. Төрийн үйлчилгээ, бизнесийн хөгжлийн чиглэлээр СВОТ шинжилгээний матрицийн 4 элементийг тодорхойлсноор «Давуу тал-Боломж», «Давуу тал-Саад бэрхшээл», «Сул тал-Боломж», «Сул тал-Саад бэрхшээл»-ийн СВОТ хослолыг нарийвчлан шинжлэх боломж хангагдсан юм. Базаж хэлбэл, сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараа, зорилго, зорилтыг томъёолж, төслүүдийг сонгоход СВОТ шинжилгээний дүн суурь мэдээлэл болж өглөө.

## 2.6. Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төсөл

***Алсын хараа:*** Стратегийн алсын хараа нь сумын нийт иргэдийн чин эрмэлзэл, хэтийн хүсэл тэмүүллийг тусгахаас гадна хэтийн ирээдүйд хүрэх түвшингийн талаархи тэдний төсөөллийг нэгтгэн илэрхийлдэг билээ. Түүнчлэн стратегийн зорилго, зорилтод хүрэхэд олон нийтийг алсын хараа хөтөлж чадна. Нийгэм-эдийн засгийн ба бизнесийн хөгжил, эдийн засгийн чадавхи, байгалийн нөөц баялаг, бизнесийн дадлага туршлага, уламжлал, ёс заншил, язгуур урлаг зэрэг эдүгээ цагийн нөхцөл боломж, бодит байдал дээр тулгуурлан стратегийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлж өгдөг.

Нөөц боломжоо аль чиглэлд түлхүү зориулах, үр ашигтай дайчлан ашиглахад сумын захиргаа, олон нийтэд хөтөч болдог алсын харааг сумын эдийн засгийн хөгжлийн үйл явц, стратегийн үндсэн бүрдэл хэсгүүдийг цогцоор хамарсан, дунд хугацаанд хүрэх үр ашгийн баримжаа, чиглэлтэйгээр томъёолсон гэж үзэж байна.

Алсын хараа маань сумын эдийн засаг, байгаль орчин, ахуй соёл, түүхэн уламжлал дээр суурилсан болохыг нотлох онцлог нөхцөл байдлыг тодруулахыг оролдлоо. Алсын хараа уян хатан, стратегийг хэрэгжүүлэх явцад гарч болох өөрчлөлтөд нийцүүлэн хянан өөрчлөх, сайжруулах боломжтойгоор томъёологдсон болохыг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

***Зорилго:*** Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги нь угаасаа орон зайн ба цаг хугацааны хэмжүүрээр тодорхойлогдох дэвшил, ахиц өөрчлөлт бий болгох тухай асуудал билээ. Хүрч болох дэвшил, хэрэгжүүлэн бий болгох өөрчлөлтийг урьдчилан төсөөлж, тодорхойлох үндсэн дээр стратегийнхээ үр дүн, өгөөжийг хэрхэн томъёолохоо шийдэх чиг баримжаа авахад сумынханд дэмжлэг үзүүлэх үүднээс стратегийн зорилго тодорхойлох асуудалд хандсан юм. Алсын хараандаа амжилттай хүрэхэд хөтлөн залах үндсэн чиглэлийг тодорхойлохоос зорилгоо томъёолох ажлаа эхлэсэн болно. Сумын эдийн засгийн хөгжлийн нийтлэг ба тусгай асуудлуудад тулгуурласан, стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан байх шаардлагыг тавьж ажиллалаа. Алсын хараа ба зорилтын амьд холбоог хангахуйцаар зорилгоо томъёолоход анхаарлаа.

***Зорилт:*** Зорилгоор дамжин алсын хараанд хүрэх, түүнчлэн хөтөлбөр, төсөлтэй зорилгыг холбох чухал хэрэглүүр нь зорилт юм. Стратеги болон тусгайлсан зорилго, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх боломжийг хангах үүднээс хүрэх түвшингийн үзүүлэлт, тоон хэмжигдэхүүнтэйгээр зорилтыг томъёолох зарчмыг баримтлалаа. Товчхон хэлэхэд, зорилтыг зорилгын шууд үргэлжлэл байхаар төсөөлж ажилласан болно. Сумын бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээгээр тогтоогдсон давуу талаа бэхжүүлэх, сул талаа даван туулах, боломжийг зөв ашиглах, саад бэрхшээлийг үндэслэлтэй тооцож ажиллах боломжийг стратегийн зорилтууд сумынханд олгож байгаа юм.

***Хөтөлбөр:*** Хамтад нь хэрэгжүүлснээр тодорхой зорилт хангагдах талаас нь харж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр нь төслүүдийг бүлэглэх замаар томъёолсон хэд хэдэн хөтөлбөрийг стратегид оруулсан. Өөрөөр хэлбэл, зорилтыг зорилгоос шууд салбарлуулан гаргахад төвөгтэй байсны учир хөтөлбөрийг ийнхүү завсрын шатлал маягтайгаар боловсруулсан юм. Цаашдаа төслүүдийг нэгтгэн бие даасан томоохон хөтөлбөр боловсруулах суурь материал болох учраас стратегийн хөтөлбөрт ийнхүү ач холбогдол өгсөн болно.

***Төсөл:*** Уламжлалт аргачлалаар бол стратеги төлөвлөгөө боловсруулах ажил үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр үндсэндээ шувтардаг билээ. Харин үйл ажиллагааны төлөвлөгөөний оронд тодорхой хөтөлбөрөөс уламжлуулан харилцан холбоо бүхий төслүүдийг стратегидээ тусгасан нь бидний хэрэглэсэн арга зүйн шинэлэг хандлага боллоо. Ийнхүү төсөл нь «алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл»

гэсэн гинжин холбооны төгсгөл хэсэг болж байгаа юм. Товч танилцуулгыг төсөл тус бүрээр боловсруулж стратегид тусгасан болно. Төслийн танилцуулгад товч тодорхойлолт, хүлээгдэж буй үр дүн, зорилтот бүлэг, төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид, боломжит хувь нэмэр оруулагчид, урьдчилсан боломж, зэхэц нөхцөл, эрсдэлтэй хүчин зүйлс, шаардагдах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх хугацаа, үр дүнгийн тогтворжилтийн талаархи товч мэдээллийг багтаалаа.

Тодруулан хэлэхэд, төсөл сонгох, боловсруулах ажлыг хэд хэдэн шат дамжлагатайгаар хэрэгжүүлсэн болно. Олон нийтийн хэлэлцүүлэг, ажлын хэсгүүдийн саналыг төслийн үндсэн багийн хэмжээнд нэгтгэн боловсруулж гаргасан хувилбарыг Төлөвлөлтийн Комиссоор хэлэлцэн зохих засвар, нэмэлт өөрчлөлт оруулж төслүүдийг эцэслэн боловсруулллаа. Ихтамир сумын эдийн засгийн хөгжлийн стратегид нийтдээ 38 төсөл тусгагдсан болно.

***Бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлүүд.*** Эдийн засгийн өсөлт бий болгох, сум орноо хөгжүүлэхэд нутгийн бизнесийн үүрэг онцгой чухал учраас бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлүүдийг оролцогчдын хамтаар тодорхойлж стратегид тусгаж өглөө. Нийтдээ 24 чиглэлийг товчилсон тодорхойлолттойгоор энэхүү стратегид оруулав. Төслийн үндсэн баг, ажлын хэсгүүд, Төлөвлөлтийн комиссын шугамаар болон олон нийттэй хийсэн уулзалт, зөвшилцөөнөөр дээрхи чиглэлүүдийг тогтоосон болно.

## 2.7. Хүлээгдэж буй үр дүн

Стратегийг хэрэгжүүлснээр олон талтай, тооны хувьд ч цөөнгүй чухал үр дүн гарна хэмээн төсөөлж байгаа бөгөөд хүлээгдэж буй зарим гол үр дүнг тодруулбал:

- Сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд сумаас оруулах хөрөнгө, хувь хандивыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгах асуудлыг шийдвэрлэхэд ИТХ, ЗДТГ-т чиглэл болж өгөх,
- Стратегийн дэд хэсгүүдийн хэрэгжилтийг хариуцсан алба, байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохицуулах чадавхи, боломжийг дээшлүүлэх,
- Стратегид тусгагдсан тэргүүлэх чиглэл төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран санхүүжүүлэх боломжийг өргөжүүлэх,
- ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд оролцох, хувь хандив оруулах сонирхол бүхий орон нутгийн, үндэсний, олон улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, хандивлагчдыг татах, тэдэнд хандах боломж сайжрах,
- Сумын эдийн засгийг хөгжүүлэх чадавхи, орон нутгийн нөөц боломж тодорхойлогдсон, ашиглалт, эргэлтэд зохих хэмжээгээр орсон байх,

- Бизнес, бизнес орчны холбогдолтой мэдээллийн сүлжээ бий болж төлөвших, бэхжих,
- Төрийн үйлчилгээний байгууллагын чадавхи дээшилж, үйлчилгээний чанар сайжрах,

## 2.8. Стратегийг хэрэгжүүлэх

ЭЗХ-ийн стратеги нь сумын төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн хувьд эдийн засаг-бизнесийн хөгжлийн бодлого, гол гогцоо асуудлуудаар чиглэл авах албан ёсны баримт бичиг мөн. Энэ агуулгаараа тухайн үеийн шаардлага, нөхцөл байдлаас хамааруулан стратегийг байнга хянан өөрчилж, шинэчилж байх ёстой.

Ихтамир сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэх ажил хоорондоо нягт уялдаа бүхий 4 үндсэн арга хэмжээгээр дамжин хэрэгжинэ.

- Санхүүгийн эх үүсвэрийг идэвхжүүлэх, санхүүжилт олох,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх,
- Хяналт үнэлгээг хугацаатай төлөвлөн хэрэгжүүлэх,
- Хянан сайжруулах, нэмэлт өөрчлөлт хийх,

Стратеги хэрэгжих хугацаа сумын одоогийн ба дараачийн сонгуулиар томилогдох удирдлагын бүрэн эрхийн хугацаанаас урт байх учраас түүний хувь заяа нь шинэ удирдлага үйл ажиллагааны залгамж чанарыг хэр хадгалж, олон нийтийн оролцоог хэрхэн хангаснаас ихээхэн хамаарна.

Стратегиэ хэрэгжүүлэх гол этгээд болохын хувьд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох үүрэг хариуцлага сумын төр, захиргаанд ногдож байгааг бид ойлгож ажиллах ёстой. Ер нь стратегид шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэх, ИТХ-аар батлуулах асуудлыг сумын ЗДТГ хариуцах нь зүйтэй гэж үзэж буй болно. Өөрөөр хэлбэл, стратегийн болоод төслийн хэрэгжилтийг зохицуулах, стратегийг хянах, зохих нэмэлт өөрчлөлт оруулж байх асуудлыг Төлөвлөлтийн комисстой хамтран сумын ЗДТГ санаачилж, гаргасан шийдвэрийн биелэлтийг хариуцах юм. Санхүүгийн ба техник ажиллагааны туслалцаа дамжлэг авах асуудлаар сумын захиргаа хандивлагчид, засгийн газар, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

Стратегийн хэрэгжилтийн явц гүнзгийрэхийн хэрээр энэ үйл явцад оролцох олон нийтийн сонирхол, идэвх дээшлэх нь мэдээж. Иймээс оролцогчидтой хамтран стратегийн хэрэгжилтийн байдлыг байнга хянаж, үнэлж байх нь алдаа оноогоо

дүгнэж, шинээр дэвшигдэн гарч ирэх асуудлууд, шаардлагыг оновчтой тодорхойлон стратегийн хүрээнд шийдвэрлэх боломжийн хангаж өгнө. Төсөл маань сумынхны өмч учраас хяналт үнэлгээг хамтран хэрэгжүүлж байх үүрэг сумын удирдлага, олон нийтэд оногдох юм. Төлөвлөлтийн комисс энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэх болно.



# БҮЛЭГ 3

# ИХТАМИР СУМЫН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Сум байгуулагдсан түүх

1931 онд явагдсан засаг захиргааны шинэчлэлтээр Ихтамир сумыг 3.4 мянган хүн ам 500 орчим өрхтэйгээр бие даалган байгуулжээ. Эдүгээ тус сум 4.8 мянган $км^2$ нутаг дэвсгэртэй, 5.5 мянган хүн амтай, өрхийн тоо 1383 хүрээд байна.

## 3.2. Нутгийн удирдлагын бүтэц

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2004 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан бөгөөд улс төрийн хоёр намыг төлөөлсөн 20 гишүүнтэй дээд байгууллага юм. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын өдөр дутмын үйл ажиллагааг ИТХ-ын Тэргүүлэгчид эрхлэн гүйцэтгэдэг.

Сумын Засаг даргын тамгын газар (ЗДТГ) нь тамгын газрын дарга, багийн дарга, байгаль хамгаалагч, төрийн сангийн төлөөлөгч, хүнс хөдөө аж ахуйн түшмэл, байгаль орчны улсын байцаагч, газрын даамал, нийгмийн даатгалын байцаагч, татварын байцаагч, хүн ам зүйн байцаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа, бичиг хэргийн эрхлэгч, үйлчлэгч, жолооч зэрэг 26 үндсэн ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус сум нь Тайхар, Хөхнуур, Хан-Өндөр, Бугат, Борт, Эрдэнэтолгой гэсэн 6 багтай.

Хүн эмнэлгийн салбар, ахлах (11 жилийн) сургууль, цэцэрлэг, Өндөр уулын бүсийн эрдэм шинжилгээний станц (ӨУБЭШС), соёлын төв, номын сан, эрчим хүч түгээлтийн салбар, усны харуул зэрэг төрийн үйлчилгээний байгууллагууд болон төрийн мэргэжлийн зарим үйлчилгээг эрхэлдэг мал эмнэлэг, үржлийн алба үйл ажиллагаа явуулж байна.

Нутгийн удирдлагын бүтэц



## 3.3. Газарзүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг

***Нутаг дэвсгэр, газар зүйн байршил.*** Ихтамир сум Архангай аймгийн нутгийн төв хэсэгт баруун талаараа Чулуут, хойгуураа Өндөр-Улаан, урдуураа Булган, Эрдэнэбулган, зүүн хойгуур Эрдэнэмандал, зүүн талаар Батцэнгэл сумтай тус тус хил залгана. Баруун урд талаараа Баянхонгор аймгийн Галуут сумтай уулархаг газраар зурвас хиллэнэ. Сумын төв нь Цэцэрлэг хотоос 27 км, Улаанбаатар хотоос 500 км-т орших Заанхошуу хэмээх газар Хойт Тамирын голын эрэг дээр төвлөрдөг.



Ихтамир сумын нутаг дэвсгэр нь Хангайн нурууны тусгай хамгаалалттай газарт хамаарах Хангайн гол ноён нурууны төв хэсгийн уулсын зүүнээс Тамир, Хануйн голыг дагаж зүүн тийш сунаж, хангай-тал хээрийн өвөрмөц хослол үүсгэсэн газарзүйн онцлог тогтоцтой. Нутгийн баруун зах нь уулархаг (нутгийн 40 хувийг уул нуруу эзлэдэг), ой хөвчтөй, харин дунд ба зүүн хойд хэсэг нь ойт хээрийн бүсэд багтана. Ихтамир сумын нутаг далайн түвшнээс дунджаар 1600-2525 метр өргөгдсөн. Хамгийн өндөр цэг болох Гурван Анагийн оргил нь 3449 метр.

Хойт Тамир, Хануй, Хүнүй, Жаргалант, Өлөнт, Баянцагаан зэрэг хүн, малын ундаа болсон жижиг гол, горхи, булаг шандтай. Хойт Тамирын голын эхний тагийн бүсэд далайн түвшнээс 2668 м орчим метр өндөрт орших Хөх нуур нь манай орны хамгийн өндөрт байрладаг цэнгэг устай нуур юм. Өндөр уулын таг газар байгалийн өвөрмөц тогтолцоог бүрдүүлдэг энэ нуурын мандлын талбай нь 6.7 $км^2$. Түүнчлэн жижиг нуур, цөөрөм, тогтоол ус сумын нутгаар тархсан болно.

***Цаг уур, ургамалшилт.*** Монгол орны цаг уурын нийтлэг төрх болох эх газрын эрс тэс уур амьсгалын хувьд нэлээд зөөлөвтөр хэсэгт Их тамир сумын нутаг дэвсгэр хамаардаг боловч улирал, сарын хэлбэлзэл ихтэй байдаг нь нутаг дэвсгэрийн өндөрлөг, хэрчигдэлттэй шууд холбоотой.

Хангайн нуруунд хөрсний чийгийн ууршилт ихтэй, хур тундас элбэг байдаг. Жилд дундажаар 258 мм тунадас унадаг. Жилийн тунадасны 90% шахам нь дулааны улиралд ногддог. Өвөл дунджаар 6-10 см зузаан цасан бүрхүүл тогтох боловч ихэнх нь уулархаг газраар унадаг. Дулааны улиралд +20$^0$С, өвлийн цагт -15-20$^0$С хүрнэ. Жилийн дундаж хэм -2...-4$^0$С байдаг. 9-р сарын ихээр анхны цас, гандуу биш бол анхны бороо 5-р сарын дунд үеэс орно.

Хөрсний хувьд шимт давхарга нь төдийлэн зузаан биш, ойт хээрийн бүсэд 15-20 см, тал хээрийн бүсэд 20-25 см орчим. Ер нь цаг уур, газарзүй-экологийн ба нутаг дэвсгэрийнх нь байршлын онцлогтой хамааралтайгаар тус суманд ургамал, амьтны нэн баялаг нөөц, төрөл зүйл бүрэлдэн тогтсон гэж хэлж болно. Говь, заримдаг цөлийн унаган ургамлаас бусад зүйл ургамал манай суманд бий. Ургамлан нөмрөг нь ийнхүү баялаг тул түүнийг дагасан олон төрөл зүйлийн зэрлэг амьтад, шувуу амьдарна.

***Байгалийн нөөц баялаг.*** Ихтамир сумын байгаль-цаг уурын онцлог ба газар зүйн байршил нь үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар ашиглах боломжтой байгалийн олон төрлийн нөөц бий болох үндсэн нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж болно. Мод бэлтгэлийн ба ойтой холбоотой нөөц баялгийг агуулдаг хармод, гацуур, хуш, нарс, бургас, хус, хайлаас зэрэг төрөл бүрийн мод бүхий ой сумын нутгаар хэсэгчилсэн ба түгээмэл тархсан бөгөөд бүх нутаг дэвсгэрийн 27 хувийг ойн нөөц бүхий газар эзэлдэг.

Сумын нутаг дэвсгэрийн ургамлын нөмрөг нь таг, өндөр уул, ойт хээр, хээр, намгархаг газруудад тархсан бүх чийгсэг, хуурайсаг гол зүйл ургамлаас бүрдсэн эмийн, тэжээлийн ба бусад хэрэглээний ургамал элбэгтэй. Ялангуяа зэрлэг жимс, самар, мөөг зэрэг өрхийн хэрэгцээнд болон жижиг үйлдвэрлэлийн хэмжээнд боловсруулах боломжтой ашигт ургамлын нөөц ихтэй. Сумынхны хийсэн баримжаа тооцоогоор самар сайн ургасан жил тус сум 40-50 сая төгрөгийн самар борлуулж, мөн 2-3 тонн жимс боловсруулах наад захын нөөцтэй ажээ.

Чулуун нүүрс, жонш, төмрийн хүдэр, шохой зэрэг ашигт малтмал, хар хүрэн, улаан зос, сайн чанарын наанги шорооны орд, нөөц бий. Одоогоор сумын төвөөс зүүн чигт орших Баянцагаан дахь 2 сая тонн антрацит нүүрсний нөөц бүхий гүний ордыг хувийн хэвшлийн нэгж ашиглаж аймаг, ойр орчмын сумын төвүүдэд нийлүүлж байна. Цаашдаа тоосго, хайрга, элс, шохой зэрэг барилгын сайн чанарын материал үйлдвэрлэж аймгийн хэрэгцээнд зохих байр суурь эзлэх бүрэн боломжтой сумын нэг нь Ихтамир юм. Түүнчлэн Засгийн газраас саяхан батлан бүх аймаг, сумдад хэрэгжүүлж эхэлсэн «40000 мянган орон сууц» хөтөлбөр барилгын материалын ирээдүйтэй зах зээл байх үндэслэлтэй юм.

Буга, аргаль, янгир, ирвэс, шилүүс, гахай, бор гөрөөс, чоно, тарвага зэрэг ан амьтан ихтэй. Тамир, Хануйн гол төрөл бүрийн загастай. Хун, галуу, хойлог, шонхор, зэрэг 50 гаруй төрлийн жигүүртэн шувууд бий.

***Газрын нөөц.*** Ихтамир сум нь 484586 га газартай, түүний дотор ХАА-н зориулалттай газар 352472 га, бэлчээр 348430 га, хадлан 2365 га, тариаланд тохиромжтой газар 1651 га, ойн нөөц 131000 га, усны эдэлбэр газар 1440 га эзлэхээс гадна тусгай

хамгаалалттай газарт 104000 га, зам шугам сүлжээний газарт 544 га, хот суурингийн эдэлбэр газарт 302.4 га, уул уурхайн газарт 3.4 га хамаардаг.

***Түүх соёлын дурсгалт газрууд.*** Хойт Тамирын голын хөндийд байх Хүннү, Түрэгийн үеийн булш, бунхан, хүн чулуу, буган хөшөө, бичээс бичигт хад зэрэг түүх-соёлын үнэт дурсгалууд эртний судлаачид төдийгүй жуулчид, аялагчдыг зүй ёсоор татдаг, хүмүүс олноор ирж үзэж сонирхдог юм. Сумын төвөөс 4 км зайтай Тамирын голын хөвөөнд улс даяар алдартай «Тайхар» чулуу хэмээх байгаль түүхийн гайхамшигт нэгэн дурсгал, голын тэгшхэн зүлгэн дунд хүний гараар бүтсэн хөшөө дурсгал мэт дүнхийн оршино. Тайхар чулуун дээр Уйгар, Түрэг, Персийн үеийн тод үсэг, манж, хятад, ланз, төвд, худам монгол зэрэг олон хэлээр бичсэн 150 гаруй бичиг тэмдэглэлээс гадна шинэ чулуун зэвсгийн үеийн улаан зосон сүг зураг байгааг судлаачид тогтоожээ.



***Аялал жуулчлал.*** Хангайн нуруу, түүний дотор Ихтамир сумын нутаг дээр үеэс айлчид, жуулчид, аялагчдыг татаж ирсэн түүхтэй. Тус сумын нутаг дээр, тухайлбал Тайхар чулууны орчимд жуулчны 3 бааз байгуулагдан ажиллаж байгаа нь Тайхар чулуу, Тагийн Хөх нуур болон байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэж байгуулагдсан юм. Түүнчлэн Хоргын тогоо, Тэрхийн цагаан нуурын байгалийн аялал жуулчлалын үндэсний маршрут болон Суман, Чулуут голын загасчлах аялалын зам дайрч өнгөрдөг нь аялал жуулчлал хөгжихөд таатай нөхцөл бүрдүүлж байна.

## 3.4. Хүн ам зүй, хүний нөөц, чадавхи

***Хүн амын өсөлт.*** 2006 оны эцсийн байдлаар тус сум 1383 өрхтэй, нийт хүн ам 5585-д хүрчээ.

Сүүлийн 2 жилд буюу 2005-2006 онд хүн амын тоо буурч байгаа нь иргэдийн шилжилт нэмэгдэж байгаатай холбоотой юм. Сумын ахлах дунд сургууль төгсөгчид, настайчууд өөр хот, аймгийн төв рүү бүрмөсөн шилжих явдал их байгаа болно.

Сумын хүн амын бодит өсөлт эерэг үзүүлэлттэй, өөрөөр хэлбэл төрөлт нь нас баралтаас давж буй дүр зураг харагдаж байна.

Суурин хүн амын тоо

| Он | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүн ам | 6538 | 6059 | 6261 | 6468 | 6577 | 6127 | 6213 | 6286 | 5714 | 5585 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

Хүн амын механик өсөлт

| Он | | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төрөлт | | 123 | 182 | 140 | 145 | 156 | 144 | 126 | 124 | 129 |
| Нас баралт | | 22 | 35 | 36 | 41 | 34 | 38 | 32 | 35 | 32 |
| Төрөлт, нас баралтын зөрүү | тоо | 101 | 137 | 114 | 104 | 122 | 106 | 96 | 89 | 97 |
| | % | 82.1 | 75.2 | 81.4 | 71.7 | 78.2 | 73.6 | 76.1 | 71.7 | 75.2 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

Хүн амын насны бүлэглэл

| Насны бүлэг | 0–19 | 20–34 | 35–54 | 55–64 | > 64 | Дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний тоо | 2478 | 1411 | 1227 | 218 | 380 | 5714 |
| Хувь | 43.3 | 24.7 | 21.5 | 3.8 | 6.9 | 100 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

Төрөлт нас баралт хэвийн байгаа боловч гадагш шилжин явсан хүний тоо шилжин ирсэн хүнийхээс өндөр байгаа учраас хүн амын тооны өсөлт одоогоор сөрөг тэнцэлтэй байна.

Хүн амын насны бүлэглэлийг 2005 оны байдлаар харуулснаас үзвэл 20 хүртлэх насны хүүхэд, залуучууд 43.3%, 20-64 насныхан тал хувийг эзэлж байгаа нь ажиллах хүчний нөөц сайтай, цаашдаа нөхөлт ч хангалттай гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

***Ажил эрхлэлт.*** Хувийн хэвшлийн ажил эрхлэлт сүүлийн 10 жилд буюу 1997-2007 онд өөрчлөгдсөн байдлыг дараах хүснэгтээс үзэж болно.

Сумын нийт хүн амыг насаар бүлэглэснээс үзвэл 19-64 насны хүн 2928 байгаатай харьцуулбал эдийн засгийн үндсэн салбаруудад ажил эрхлэлт харьцангуй сайн буюу 2005 оны байдлаар 83.0 хувь нь ямар нэг ажилтай гэсэн ерөнхий дүн гарч байна. Нийтдээ төрийн ба хувийн хэвшлийн 1470 нэгжид 2400-аад хүн ажиллаж байна. Гэхдээ мал бүхий иргэд, улирлын ажилтай хүмүүс нэлээдгүй байгаагийн дээр малчин өрхүүдэд далд ажилгүйдэл тодорхой хэмжээгээр оршсоор байгаа билээ.

Ажиллагсдын тоо

| Он | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ажиллагсдын тоо | 2328 | 2314 | 2103 | 2576 | 2592 | 2408 | 2432 | 2423 | 2403 | 2432 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

***Ажилгүйдэл.*** Ажилгүй хэмээн сумын захиргаанд албан ёсоор бүртгүүлсэн, ажил идэвхтэй эрж буй хүний тоо сүүлийн 10 жилд жил бүр буурсаар ирсэн нь ажил эрхлэлт харьцангуй сайжирч байгаа гэсэн дүгнэлтийг баталж байна. 2006 оны байдлаар ажилгүйчүүдийн дотор эрэгтэйчүүд давамгайлж байгаа ба боловсролын түвшин ахихын хэрээр ажилгүйдэл буурах хандлага тодорхой ажиглагдаж байна. Ажилгүй гэгдэх хүмүүсийн олонхи нь сумын төвд оршин сууж байна.

***Өрхийн амьжиргааны түвшин.*** Нийт өрхийн 94.6% нь бага орлоготой, ядуу, нэн ядууд багтдаг. Хүн амын 73.9% нь бага орлоготой, 17.7% нь ядуу, 13.2% нь нэн ядуу өрхөд, харин дөнгөж 0.8% нь чинээлэг, 5.7% нь дундаж орлоготой өрхөд амьдарч байна.

Ажилгүйчүүдийн тоо

| Он | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ажилгүйчүүдийн тоо | 182 | 154 | 96 | 84 | 68 | 63 | 55 | 54 | 49 | 28 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*



# БҮЛЭГ 4

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ: ОДОО БА ХЭТИЙН ТӨЛӨВ

## 4.1. Нийтлэг асуудлууд

***Түцвэр тоо баримт.*** Сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн зарим тоо баримтыг 2006 оны дүнгээр товчлон дурьдвал, 112 хүн байнгын ба түр ажлын байртай болж, гүний болон богино яндант худаг 12, гар худаг 10-ыг шинээр гаргасан байна. Аж ахуйн нэгжүүд 6 га-д, 62 өрх өвөлжөө хаваржааны газар хүнсний ногоо, ногоон тэжээл тариалж, «Тамирын цагаан ааруул» үндэсний шилдэг бүтээгдэхүүний гэрчилгээ авч бренд бүтээгдэхүүнээр тодорхойлогджээ.

Манай сумын уугуул, «Монгол өртөө» группын ерөнхийлөгч, ноён Рэнцэнжамцын Болдбаатар өөрийн хөрөнгөөр төрөлх сумандаа ЗДТГ-ын шинэ барилга бариулснаас гадна 10 цоохор гэр, үндэсний иж бүрэн хөгжим хандивлаж 70 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувиасаа хийлээ.

## 4.2. Төсвийн санхүүжилт, зарцуулалт

Сумын төсвийн 2006 оны санхүүжилт 2002 оныхоос 2.3 дахин нэмэгдсэн нь улсын төсвийн санхүүжилт өссөнтэй холбоотой юм.

Төсвийн нийт санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувийн жин нэмэгдсээр байхад орон нутгийн орлого тэр хэмжээнд хүрч өсөхгүй байгаа юм.

Төслийн орлого, зарлага

| Төсөв | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн нийт орлого: (сая.төг)** | | | | | |
| Орон нутгийн татвараас | 33.4 | 22.9 | 22.3 | 26.1 | 36.9 |
| Орон нутгийн тарифт төлбөрөөс | | | | | 19.0 |
| **Бүгд** | **33.4** | **22.9** | **22.3** | **26.1** | **55.9** |
| **Төсвийн нийт санхүүжилт: (сая.төг)** | | | | | |
| Улсын төсвийн | 293.6 | 332.7 | 446.5 | 601.3 | 709.9 |
| Орон нутгийн | 33.4 | 22.9 | 22.3 | 26.1 | 55.8 |
| **Бүгд** | **327.0** | **355.6** | **468.8** | **627.4** | **765.7** |
| **Зарлага: (сая.төг)** | | | | | |
| Үйл ажиллагааны зардал | 171.1 | 178.6 | 218.5 | 263.3 | 325.8 |
| Тэтгэвэр, тэтгэмж, нийгэм халамжийн үйлчилгээнд | 160.0 | 180.0 | 254.8 | 368.3 | 449.7 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

## 4.3. Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн судалгаа (дор хүснэгтэд үзүүлсэн)-наас үзэхэд тус сумын ДНБ-ний үйлдвэрлэлд эзэлж буй хувийн жин, эдийн засгийн ач холбогдлоороо мал аж ахуйн салбар тэргүүлж байна.

Төмс, хүнсний ногоо тариалах явдал өргөжсөний үр дүнд газар тариаланд зохих ахиц гарч удаалан аж үйлдвэрийн бүтээгдэхүүн бага хувийг эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сүүлийн 5 жилээр

| Бүтээгдэхүүн | | Хэм. нэгж | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үр тариа | тн | | | 80 | 150 | 10 |
| 2 | Төмс | тн | 63 | 72 | 84 | 100 | 130 |
| 3 | Хүнсний ногоо | тн | 6.3 | 9.4 | 8.1 | 13.1 | 10 |
| 4 | Хадлан | тн | 3400 | 3500 | 3800 | 4200 | 4324 |
| 5 | Мах | тн | 1127.3 | 1320.1 | 1564.7 | 1012.8 | 1175.1 |
| 6 | Сүү | тн | 1564.3 | 1758.2 | 1802.1 | 1866.8 | 2145.6 |
| 7 | Цагаан идээ | тн | 782.1 | 879.1 | 901 | 933.4 | 1072.8 |
| 8 | Ямааны ноолуур | кг | 7749 | 10858 | 10528 | 11081.8 | 12412.8 |
| 9 | Хонины ноос | тн | 40.9 | 44.1 | 48.1 | 52.5 | 59.3 |
| 10 | Богийн арьс | мян.ш | 16.8 | 17.5 | 18.6 | 19.6 | 16.9 |
| 11 | Бодын арьс | мян.ш | 7.3 | 6.4 | 6.9 | 6.2 | 5.8 |
| 12 | Нүүрс | тн | | | | 2000 | 2200 |
| 13 | Гуалин | $м^3$ | 4.4 | 8.2 | 3.5 | 2.7 | 1.7 |
| 14 | Зүсмэл материал | $м^3$ | 245 | 415 | 266 | 86 | 140 |
| 15 | Архи | лирт | 680 | 200 | | | |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

## 4.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд

***Тоон үзүүлэлтүүд.*** Малчин өрх, газар тариалан эрхлэгчдийг оруулахгүйгээр тооцоход бусад салбарын 80 нэгжид 289 хүн ажилаж байгаа бөгөөд 2006 онд татварын албанд бүртгэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж 53 байжээ. Монголын бусад сумдтай адилаар хувийн секторт гарч буй тооны өсөлт худалдааны салбарын өсөлтөөр нөхцөлдөж байна.

***Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбар.*** Малчин өрхийг оруулбал сумын хэмжээнд 1071 нэгж үйлдвэрлэл эрхэлж байна. Тус сумaнд худалдааны 24, үйлчилгээний

Аж ахуйн нэгжийн тоо

| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Аж ахуйн нэгжийн тоо | 19 | 22 | 25 | 26 | 31 | 37 | 48 | 51 | 54 | 53 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

Аж ахуйн нэгжийн бүлэглэл

| Салбарууд | Бичил | Жижиг | Дунд | Том | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| ХАА | 3 | | | | 3 |
| Аж үйлдвэр | | 2 | | | 2 |
| Барилга | | | 1 | | 1 |
| Тээвэр | 15 | | | | 15 |
| Худалдаа | 20 | 4 | | | 24 |
| Үйлчилгээ | 8 | | | | 8 |
| Аялал жуулчал | | | 2 | 1 | 3 |
| **Дүн** | **46** | **6** | **3** | **1** | **56** |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

3, нийтийн хоолны 8 цэг, аялал жуулчлалын 3 бааз ажиллаж, суман дахь худалдаа үйлчилгээний ажилд тус сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч 222 орчим иргэн оролцдог. Цаашид худалдааны бус буюу суманд хөрөнгийн хуримтлал, ажлын тогтвортой байр бий болгох чадамж бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр бизнесийн орчныг сайжруулах, тийм бизнесийг дэмжих нь зүйтэй байна.

***Аж ахуйн нэгжийн бүлэглэл.*** Тус сумын аж ахуйн нэгжүүдийн 86.7%-ийг бичил буюу үндэсний ангиллаар 5 хүртэл ажиллагсадтай бичил нэгжүүд эзэлж байгаа нь ажиллагсдын тоогоор бүлэглэсэн дүнтэй тохирч байна.

Аж ахуйн нэг нэгжид ажиллагсдын тоо 1.6 байгаа нь бичил нэгжүүд давамгайлж буйг харуулж байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 7 ажиллагсадтай төрийн өмчийн 2 нэгж оролцож, аж ахуйн нэгжүүд ажлын байрны 90 орчим хувийг хангаж байна

***Мал аж ахуй.***



2002 оноос хойш сумын нийт мал жил бүр 10 шахам мянгаар өсч иржээ. Ихтамир сум 1024 малчин өрхтэй бөгөөд аж ахуй эрхлэгчдийн 89.3%-ийг эзэлж байгаа нь сумын эдийн засаг МАА-гаас шууд хамааралтайг илтгэж байна.

2006 оны үзүүлэлтээр тооцвол, нэг малчин өрхөд хонин толгойд шилжүүлснээр 333.5 толгой мал ногдож байна. Малын тоо сүүлийн жилүүдэд жигд өсөх хандлагатай байгаа боловч бусад сумдтай адилаар ямааны тоо сүүлийн 5 жилд 2001 оныхтой харьцуулбал 33.3%-иар нэмэгдэж малын тооны өсөлтийн талаас илүүг бүрдүүлж байна.

Аж ахуйн нэгжийн ажиллагсдын тоо

| | Төрийн алба | | Хувийн сектор | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо |
| **Үйлдвэрлэлийн салбар** | | | | | | |
| Мал аж ахуй | | | 1024 | 1931 | 1024 | 1931 |
| Газар тариалан | | | 43 | 86 | 43 | 86 |
| Хүнсний үйлдвэрлэл | | | 3 | 6 | 3 | 6 |
| Эрчим хүч, дулаан, ус | 1 | 3 | | | 1 | 3 |
| Уул уурхай | | | 1 | 5 | 1 | 5 |
| **Дүн** | **1** | **3** | **1071** | **2028** | **1072** | **2031** |
| **Үйлчилгээний салбар** | | | | | | |
| Худалдаа | | | 24 | 96 | 24 | 96 |
| Ахуйн үйлчилгээ | | | 35 | 102 | 35 | 102 |
| Тээвэр, зам | | | | 25 | | |
| Холбоо | 1 | 4 | 1 | 3 | 2 | 7 |
| Зочид буудал, нийтийн хоол | | | 8 | 24 | 8 | 24 |
| Гар урлал | | | 3 | 15 | 3 | 15 |
| **Дүн** | **1** | **4** | **71** | **265** | **72** | **244** |
| **Нийт дүн** | **2** | **7** | **1442** | **2283** | **1444** | **2375** |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

Малын тооны өсөлт, сүүлийн 5 жилээр

| | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|---|---|---|---|---|---|
| Нийт малын тоо | 138179 | 130075 | 139252 | 152658 | 161028 |
| Тэмээ | 8 | 8 | 11 | 10 | 3 |
| Адуу | 17144 | 16212 | 16562 | 17018 | 15905 |
| Үхэр | 26416 | 23886 | 20981 | 22634 | 24116 |
| Хонь | 57305 | 51224 | 55157 | 60356 | 65595 |
| Ямаа | 37306 | 38745 | 46541 | 52640 | 55409 |
| Хонин толгойд шилжүүлснээр | 369432 | 342943 | 338930 | 362722 | 371512 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2005*

Малчин өрх, аж ахуйн нэгжийн тоо, багаар

| Баг | Өрхийн тоо | ААН | Дүн | Хувь | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өрх | ААН |
| Эрдэнэтолгой | 238 | = | 238 | 100.0 | = |
| Хөхнуур | 147 | 1 | 148 | 99.3 | 0.68 |
| Хан-Өндөр | 208 | = | 208 | 100.0 | = |
| Бугат | 235 | 3 | 238 | 98.73 | 1.27 |
| Тайхир | 316 | 47 | 363 | 85.2 | 14.8 |
| Борт | 239 | 2 | 241 | 99.18 | 0.82 |
| Бүгд | 1383 | 52 | 1436 | 100 | 100 |

*Эх сурвалж: Сумын статистик мэдээ, 2006*

***Газар тариалан.*** Тус сум одоогоор 26 га газарт ихэвчлэн төмс хүнсний ногоо тариалж байгаа. ХАА-н нэгдлийн үеийн тариалангийн үйлдвэрлэл бүрэн зогссон учраас нийтдээ 1605 га газар атаржсан байна. Газар тариалангийн салбарт 83 хүн ажилладаг. Жилдээ хураан авч буй ургацыг 2005 оныхоор төлөөлүүлэн харуулбал:

- Малын тэжээл – 10.3 тонн
- Таримал тэжээл – 15 тонн
- Байгалийн хадлан – 3649 тонн
- Дарш – 1.5 тонн
- Хүнсний ногоо – 6.8 тонн
- Төмс – 125 тонн

***Багийн эдийн засгийн байдал.*** Хөдөөгийн багуудад аж ахуйн нэгж цөөн, ихэнх нь сумын төвийг харъяалах Тайхир багт байршдаг онцлогтой. Байгалийн нөхцлөөр нэн тохиромжтойд тооцогддог, ялангуяа мод, жимс, ус гэх мэт нөөцөд хамгийн ойр орших Эрдэнэтолгой, Хөхнуур, Хан-Өндөр багуудад ямар ч нэгж байхгүй байгаа нь цаашид анхаарах асуудал мөн.

Цаашдаа Борт мэтийн эрчим хүч, төв зам зэрэг дэд бүтцэд ойр, тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтаар холбогдох боломжтой багуудад үйлдвэрлэл, үйлчилгээний чадавхи бий болгох асуудалд багагүй анхаарах, ингэснээр үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, малчдад ойртуулахад ач холбогдолтой байх талтай.

## 4.5. Зах зээл, маркетинг

Тус сумын бүтээгдэхүүний борлуулалт, ханган нийлүүлэх зах зээл сумын байршил, үйлдвэрлэл, иргэдийн эрэлт хэрэглээний шинж чанараар тодорхойлогдож байна. Хөдөө аж ахуйн түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнийг сум, аймаг, төвлөрсөн

хот сууринд борлуулах ба өргөн хэрэглээний барааг аймгийн төв, Улаанбаатар хот, БНХАУ-ын Эрээн хотоос татдаг.

Хүн ам илүү төвлөрч, зах зээл давуу хөгжсөн хамгийн ойр зах зээл нь аймгийн төв учраас энэ зах чиглэсэн худалдаа, үйлчилгээ эрхлэх боломжтой, энэ нь сумын эдийн засгийн хөгжилд зохих хэмжээгээр нааштай нөлөөлдөг. Цаашдаа сумын дотоод хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах, цаашилбал аймгийн төв зэрэг боломжтой зах зээлд гарахыг эрмэлзэх явдал ач холбогдолтой байх болно.



***Банк, санхүүгийн үйлчилгээ.*** Манай суманд ХААН, ХАС, Монгол шуудан банкны салбарууд, бусад банк бус санхүүгийн байгууллага явуулын үйлчилгээ үзүүлж байна. Сумын төвд ХААН банк, Монгол шуудан банкны он-лайн сүлжээнд холбогдсон салбар ажилладаг. Монгол даатгал, Түшиг даатгал зэрэг хувийн хэвшлийн даатгалын компаниуд явуулаар үйлчилдэг. Зөвхөн 2006 оны байдлаар ХААН, ХАС банкнаас 620.0 гаруй сая төгрөгийн зээл олгож, иргэд, байгууллага, бизнес эрхлэгчдэд үйлчилжээ.

## 4.6. Төрийн ба нийгмийн үйлчилгээ

Тус суманд төрийн бүх төрлийн үйлчилгээ явагддаг бөгөөд эдгээрийг бие даасан байгууллага, нэгжүүд хариуцан хэрэгжүүлж байна.



| | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо |
|---|---|---|
| Төрийн удирдлага | 1 | 30 |
| Санхүү, банк | 2 | 7 |
| Боловсрол | 1 | 83 |
| Эрүүл мэнд | 1 | 24 |
| Дүн | 5 | 144 |

***Төрийн үйлчилгээнд ажиллагсад.*** Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн үйлчилгээний 5 үндсэн нэгжид 144 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 6 орчим хувь болж байна.

***Боловсрол***

*Ерөнхий боловсролын сургууль.* 11 жилийн сургалтад бүрэн шилжиж, 2007-2008 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хангаж байна. Шалтгаангүй сургууль завсардалт бүрэн зогсч, хамран сургалт 95.0 хувьд хүрлээ. Сургуулийн хичээлийн ба дотуур байрын хүрэлцээг сайжруулах, мэргэжлийн багш, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах зэрэг арга хэмжээг ойрын хугацаанд хэрэгжүүлэхийг зорьж байна.

*Сургуулийн өмнөх боловсрол.* Хүүхдийн цэцэрлэг 120 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, одоогоор 10 орон тоотой ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын тогтолцоонд хамрагдаж буй хүүхдийн тоо хамрагдвал зохих хүүхдийн 50 хувь хүрэхүй байгаа. Хүн ам илүү төвлөрсөн 2-3 чиглэлд зуны түр цэцэрлэг ажиллуулах замаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн сургуульд орох бэлтгэлийг хангаж байна. Цаашид цэцэрлэгийн байрыг өргөтгөх, тохижилтыг нь сайжруулах замаар сургуулийн өмнөх боловсрол олгох тогтолцоонд хүүхдүүдийн хамралтын хүрээг өргөтгөх зорилттой ажиллаж байна.



***Эрүүл мэндийн үйлчилгээ.*** Сумын их эмчийн салбарт одоо 3 их эмч, 25 хүн ажилладаг. Сумын хүн эмнэлгийн салбар түргэн тусламжийн машинтай, бүх багийн эмч нар мотоцикльтой болсон. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг сайжруулах, багийн эмч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх ажлыг шат дараалалтайгаар хийж, иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж байна. Цаашид эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хүн

эмнэлгийн салбарын байрыг өргөтгөх, мэргэжлийн их эмч, эмнэлгийн ажилтан, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, багуудад эрүүл мэндийн төв, бага эмчийн салбар байгуулах, хүн амын эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах хойшлуулшгүй зорилт тавигдаж байгаа юм.

***Нийтийн биеийн тамирын үйлчилгээ.*** Орон нутагт үндэсний болон их спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлого чиглэл боловсруулан баталж, спортын наадам, уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээг жил бүр төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, спортод гоц авъяастай хүүхэд, залуучуудыг дэмжин урамшуулдаг журам гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авч байгаагийн дээр сурагчид, иргэдийн бие бялдрын үнэлгээ явуулан спорт, нийтийн биеийн тамирын ямар арга хэмжээ авах шаардлагатайг тогтоох ажил хийгдэж байна. Дунд сургууль, соёлын төв дээр бие бялдар чийрэгжүүлэлтийн танхим нээн ажиллуулах зорилт тавьж байна.

***Соёл, урлагийн үйлчилгээ.*** Тус сумын соёлын төв нь 6 орон тоотойгоор ажиллаж байна. Сумын засаг даргын захирамжаар түүх соёлын дурсгалт газар, эд өлгийн зүйлсийг хамгаалалтад авч, орон нутаг судлах музей, нийтийн номын санг тохижуулах, музейн үзмэрийн сан, номын фондыг баяжуулах, урлаг спортын наадам боломжийнхоо хэрээр зохион байгуулж эхлэв. Соёлын төвийн барилгыг иж бүрэн засах, үйл ажиллагааг тогтмолжуулах, номын санг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах нь соёлын үйлчилгээний гол зорилт юм.

## 4.7. Дэд бүтэц

Хөдөөгийн дэд бүтцийг сайжруулах талаар авч төр засгаас хэрэгжүүлсэн удаа дараагийн арга хэмжээний үр дүнд тус сумын дэд бүтэц жил ирэх тутам хөгжиж ирлээ.

***Эрчим хүч.*** Цэцэрлэг хотоос Ар Халзангийн давааны хар модон ойн дундуур татсан төвийн эрчим хүчний өндөр хүчдэлийн сүлжээтэй Ихтамир сумыг 1989 онд холбосноор эрчим хүчээр байнга хангагддаг цөөн сумын нэг болсон юм.

***Зам харилцаа.*** Ихтамир сумыг дайрч өнгөрдөг Баян-өлгий, Увс, Ховд, Завхан аймгууд болон Хөвсгөлийн баруун өмнө, баруун, Архангайн хойт талын сумын төв зам бол Монгол улсын автозамын дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй зам тээвэр, аялал жуулчлалын гол магистраль мөн. Энэхүү төв замын дагуух томоохон голууд, түүний дотор Тамир, Хануй зэрэг манай сумын нутгийн гол дээр орчин үеийн төмөр бетон гүүр тавьсан нь сумын дэд бүтцийн хөгжлийг улам сайжруулж өгсөн болно.

***Холбоо мэдээлэл.*** Эдүгээ телевизийн 5 суваг, түүнээс гадна хөрш орнуудын өргөн диапазонт нэвтрүүлгийг үздэг малчин өрхийн тоо 2005 онд 50 орчим хувьд хүрлээ. 2000-аад оны эхнээс Монгол улсын бүх багуудад богино долгионы радио холбооны систем суурилуулснаар утсан телефоноос өөр харилцаа холбооны хэрэгсэлгүй байсан хөдөө нутагт томоохон дэвшил авчирсан билээ. Шилэн кабелийн сүлжээ бүх аймагт хүрсний зэрэгцээ нэлээд олон сумыг шууд холбосны үр дүнд 2006 онд манай сум үүрэн телефоны МОБИКОМ үйлчилгээ болон интернетийн сүлжээнд холбогдож орчин цагийн холбооны системийг өргөн ашиглаж эхэллээ.

## 4.8. Гадаад харилцаа, хандивлагчдын төсөл хөтөлбөр

Тус сум улсын төв хэсэг оршдог тул хилийн гарц байхгүй, гадаад худалдаа, хөгжүүлэхэд төвөгтэй байдаг. Гэвч сумын удирдлагын чармайлтаар БНХАУ-тай харилцаа тогтоож, 2006 онд Хятад-Монголын найрамдлын нэрэмжит сум боллоо. Түүнээс гадна ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох зорилгоор гадаадын байгууллагын дэмжлэг тусламжаар тус суманд «Ногоон алт», «Хөдөөгийн ядуурлыг бууруулах» зэрэг 2 хөтөлбөр, 10 төсөл амжилттай хэрэгжиж, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн нэг чухал эх үүсвэр болж байна. Тухайлбал:

- «Жей-Си-Эс» ОУБ-ын «**Өрхийн тариалан төсөл**»-өөр 80 өрх тусгай талбайд төмс, хүнсний ногоо тарьж 2006 онд төмс 47.2 тонн, бусад нарийн ногоо 12 тонн буюу 233.0 сая төгрөгийн ургац авав. Эдгээр өрхүүд ажлын байр, стандартын зоорь, жижиг оврын трактор, нарийн ногооны хүлэмж, 5 га боловсруулсан газар, нэгдсэн хашаатай боллоо.
- «Дэлхийн Зөн» (ДЗОУБ)-ын «**Үр ба багаж**» төслийн хүрээнд нэн ядуу, өндөр настан, өрх толгойлсон олон хүүхэдтэй 140 гаруй өрх хашаандаа төмс, хүнсний ногоо тарьж, 13.8 тонн ургац хурааж 5.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, ДЗОУБ-ын санхүүжилттэй «**Сүрьеэ өвчнөөс сэргийлэх төсөл**» 2005 оноос хэрэгжиж 1725000 төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, эм бодис бүхий лаборатори байгуулсны дээр 817.0 мянган төгрөгөөр сургалтын кабинет байгуулж өгөв.
- ДЗОУБ-ын хөрөнгө оруулалттай «**Гэр**» төслөөс манай сумын орон гэргүй 16 өрхөд иж бүрэн гэр олгож туслалаа.
- «**Хүүхэд ивээх сан**» төсөл нэн ядуу амьдралтай 195 өрх тус бүрээс 1 хүүхдийг Солонгос улсын сайн санаат айл өрхтэй холбоо тогтооход тусалж байна.
- ДЗОУБ-ын санаачилгаар сумын хүүхдийн цэцэрлэгт 70.0 мянган төгрөгийн тоглоом, зөөлөн эдлэл, телевиз өгч тохижуулан хүүхдийн хөгжлийн төвийг ЗДТГ-ын дэргэд байгуулав.

- Японы хөрөнгө оруулалттай «**Монгол эмийн үйлчилгээ**» төсөл зургаан багийн 500 өрхийн хүн амд монгол эмийн үйлчилгээ үзүүлж байна.
- Швейцарын Хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн «**Айлаас айлд**» төсөл 3 багийн малчин өрх хамрагдаж нэг өрх аялалын хугацаанд 250.0-470.0 мянган төгрөгийн орлого олсон байна.
- «**Өрхийн амьжиргааг дэмжих**» хөтөлбөрийн бичил зээлийн үйлчилгээнээс багийн хүний бага эмч нарыг мотоцикльтой болгож хөдөөгийн үйлчилгээг сайжруулахад чухал хувь нэмэр оруууллаа.
- ННХ/ННФ-оос хэрэгжүүлсэн «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх - **ДЕЛТА**» төслийн санхүүжилтээр сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги боловсруулж, ЗДТГ-ын дэргэд иж бүрэн тохижуулсан сумын бизнес хөгжлийн алба байгууллаа. 2007-2008 онд сумын төвийг тохижуулах нэг төслийг санхүүжүүлж хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа эхлээд байна.
- Швейцарийн Хөгжлийн Агентлагийн хөрөнгө оруулалттай «**Ногоон Алт**» хөтөлбөрөөс бэлчээрийн хамтын менежментийг боловсронгуй болгох замаар малчдын аж амьдралыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр нэлээд олон төрлийн үйл ажиллагаа явуулж ирлээ.
    - Гар шахуурга бүхий 10 гаруй гар худаг, цахилгаан насостой 3 худаг тус тус ашиглалтад оруулсан нь хүн, малын усан хангамж, чанарыг сайжруулахад томоохон дэмжлэг боллоо.
    - Хөдөөгийн 5 багт бэлчээр ашиглагчдын 14 хэсэг зохион байгуулж, бэлчээр ашиглалтыг сайжруулах, талхлагдлаас сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээнд малчдын оролцоог өргөжүүлэх, үр өгөөжтэй санаачлага, үйл ажиллагааг дэмжих зорилгоор болзолт уралдаан зарлан ажиллаж үр дүнд хүрч байна.
    - Суманд малчдын холбоо байгуулан сургалтын байр, автомашинтай болголоо.

    Энэ хөтөлбөрөөс 3 жилийн хугацаанд 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зөвхөн манай суманд хийжээ.
- Тус суманд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хандивлагчийн хөтөлбөрийн нэг нь «**Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр**» юм.
    - Хүн эмнэлэг, багийг бага сургууль, Бугат багийн төвийг 30 гаруй сая төгрөгөөр засварлан тохижуулж ажлын ба үйлчилгээний нөхцлийг сайжруулав.
    - Малчдын албан бус бүлэг байгуулж, газар тариалан эрхлэгчдэд трактор, төмс, хүнсний ногооны үр өгч туслалцаа үзүүлж ирлээ.
    - Сургалтын байр, оёдол, эсгүүр, цайны газар, зурагчин, үсчин зэрэг орлого нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна.
    - Гүн өрмийн ба богино яндант 7 гаргаж 90 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.



# БҮЛЭГ 5

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

## 5.1. Бизнесийн орчны судалгааны дүн

Орон нутгийн ЭЗХ-ийн стратеги боловсруулах ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэг нь сумын бизнесийн орчны судалгаа байв. Судалгааг 2006 оны 8-10-р сард явууллаа. Энэхүү судалгаа нь ОНЭЗХ-ийн стратеги боловсруулахад шаардагдах суурь мэдээлэл хуримтлуулах зорилготой бөгөөд энэ явцад орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжлийн тухайн үеийн байдал, хэтийн төлөвийг ойлгож мэдэх, ололттой талууд ба тулгамдаж буй асуудлын талаар бодитой мэдээлэл авах туршлага дадлага эзэмшихэд нь орон нутгийнханд туслах зорилгыг давхар агуулж байлаа. Судалгааны дүнг олон нийтээр хэлэлцүүлж тэдний саналыг авсан болно.

***Судалгаанд хамрагдагсад***

- Бизнесийн орчны судалгаанд бизнес эрхлэгч 53 аж ахуйн нэгж, иргэдийн 50%, 1024 малчны 5.0% нь хамрагдсан нь сумын бүх бизнес эрхлэгчдийн 6.7% болж байна.
- Судалгаанд бизнес өмчлөгч эзэн 16, гүйцэтгэх ажилтан 2, бусад ажилтан 8, бүгд 26, түүнчлэн 60 малчин оролцлоо
- Судалгаанд оролцогчдыг эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөр нь хуваавал, мал аж ахуй эрхлэгчид 50.0%, худалдаа эрхлэгчид 26.0%, ЖДҮ эрхлэгчид 6.0% газар тариалан эрхлэгчид – 5.0%, бусад салбарын төлөөлөл 9.0% байлаа.
- Судалгаанд хамрагдагсдын 40.0% нь 5 хүртэл жил, 28.7% нь 6-12 жил, 33.3% нь 10 ба түүнээс дээш жил ажилласан хүмүүс байв.
- Аж ахуйн нэгж, малчин өрхийн 82.2% нь 5 хүртэл, 17.8% нь 6-50 ажиллагсадтай.

***Сумын бизнесийн өргөжилт.*** Судалгаанд оролцогчдын 75.6% нь өөрсдийн эрхэлж буй бизнесийг өргөжиж байгаа гэж үнэлсэн нь тус суманд бизнесийн үйл ажиллагаа ерөнхий хандлагаараа өргөжиж байгааг илэрхийлж байна.

***Бүтээгдэхүүнээ борлуулдаг зах зээл.*** Тус сумын бизнес эрхлэгчдийн 90 гаруй хувь, малчид бүгдээрээ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ аймаг, сумандаа борлуулдаг. Бизнес эрхлэгчид үндэсний болон бүс нутгийн зах зээлд оролцоо багатай хэвээрээ байна.

***Мэргэжилтэй ажиллагсдын хангамж, хэрэгцээ.*** Судалгааанд оролцсон бизнес эрхлэгчид ба малчдын 58.3% нь бизнесээ өргөжүүлэхэд мэргэжилтэй ажиллах хүч хэрэгтэй гэж хариулжээ. Хамгийн эрэлттэй сургалтын тоонд маркетинг, менежмент, компьютер, санхүү-бүртгэл, чадавхи бэхжүүлэх чиглэлийг оруулжээ.

***Бизнесийн өрсөлдөөний үнэлгээ.*** Судалгаанд хамрагдсан хүмүүсийн үзэж байгаагаар сумандаа болон аймгийн төвийн зах зээлд бизнесийн өрсөлдөөн илүү ажээ. Харин сумын бренд бүтээгдэхүүн болох «Тамирын цагаан ааруул»-аараа үндэсний хэмжээнд тэргүүлэх байранд яваа жишээгээр цаашид олон бүтээгдэхүүн гаргах талаар шургуу ажиллах, энэ тал дээр анхаарах нь зүйтэй гэж зөвлөж байна.

***Бизнесээ өргөтгөх, шинээр бизнес эрхлэх сонирхол.*** Судалгаанд оролцогчдын:

- 22.0% нь тоо хэмжээг нэмэгдүүлэх
- 17.7% нь бараа үйлчилгээний чанарыг сайжруулах
- 10.6% нь орон нутагт хэрэгжих боломжтой эрчимжилт нэвтрүүлэх
- 53.7% нь шинээр бизнес эрхлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлж, борлуулалтаа нэмэгдүүлэх бололцоотой гэж үзэж байна.

***Бизнесийг хөгжүүлэхэд бизнесийн холбоо, байгууллагуудын туслалцаа.*** Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид ба малчдын 2/3 нь бизнесийн холбоо, байгууллагууд тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлдэггүй гэжээ. Бизнесийн холбоо, байгууллагууд ялангуяа малчдад бараг хүрдэггүй дүр зураг энэ суман дээр ажиглагдлаа.

***Бизнесээ цаашид өргөжүүлэх сонирхол.*** Судалгаанд оролцогчдын 78.6% нь сумандаа, бусад нь аймагтаа бизнес, үйлчилгээгээ өргөтгөх сонирхолтой. 29.8 нь үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, эрчимжүүлэх, харин 40.5% нь үйлдвэрлэлийнхээ хэмжээг нь нэмэгдүүлэх замаар бизнесээ өргөжүүлнэ гэжээ.

***Шинээр бизнес эрхлэх болон өргөтгөхөд тохиолдож буй гол бэрхшээлүүд.*** Бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн ноцтой бэрхшээлүүд нь хөрөнгө, санхүү дутагддаг, иргэдийн худалдан авах чадвар сул, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байр олдоц муутай, захиргааны бодитой дэмжлэг дутмаг зэрэг олон асуудалтай холбоотой ажээ. Мөнгө санхүү, мэргэжлийн ба бизнесийн мэдлэг чадвар дутагдахаас гадна бэлчээр, усны хүрэлцээ муу цаашдаа улам хүндрэх төлөвтэй болж байгаа өөрчлөлтийг гол бэрхшээл хэмээн малчид нэрлэж байна.

***Орон нутгийн захиргаа, бизнесүүдийн хамтын ажиллагаа.*** Орон нутгийн засаг захиргаатай ажиллахад зарцуулах жилд хугацаа харьцангуй зөрүүтэй (бизнес эрхлэгчдийнхээр 5, малчдынхаар 39 хоног) боловч хүмүүс боломжийн гэж үзэж байна. Бизнес эрхлэгчдээс зарцуулж буй хугацаа нэг бол хэтэрхий богино, эсвэл урт байгаа нь бодит амьдралтай төдийлэн сайн нийцэхгүй байна. Гэхдээ энэ нь төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг улам нягтруулах, төрийн үйлчилгээний талаар иргэдэд сайн таниулж ойлгуулах шаардлагатай байна.

***Сумын захиргааны зүгээс бизнест учирч буй сөрөг нөлөөлөл.*** Сумын төр захиргааны үйл ажиллагаанаас болж бизнест ноцтой сөрөг нөлөөлөл учрах нь харьцангуй бага гэсэн ерөнхий дүн гарч байна. Гэхдээ цаг их зарцуулдаг, үйлчилгээний төлбөр хураамж нь өндөр, мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулалтад давхардал гардаг, зөрчилддөг, зарим асуудлаар нийтлэг мөрдөх, тодорхой журам байхгүй гэх мэт зарим асуудлууд тодорхой нөлөөтэй гэж судалгаанд оролцогчид үзжээ.

***Сумын төр, захиргаанаас хүсч байгаа дэмжлэг.*** Дэд бүтцийг сайжруулах, мэдээллээр хангах семинар, сургалт, дадлагажуулалтын арга хэмжээ зохион байгуулах, сумын захиргааны үйл ажиллагааны шуурхай байдлыг дээшлүүлэх, дүрэм журам, зохицуулалтыг сайжруулах асуудлуудыг хөндөж сумаас арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэхийг хүсэж байна.

***Бизнесийн үйл ажиллагаа, өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийн*** тоонд автозам, холбоо, хөдөө баг, малчдын эрчим хүчний хангамж, үйлдвэрлэл, үйлчилгээ

явуулах байрны олдоц хүрэлцээ болон санхүүгийн найдвартай эх үүсвэр олох, бизнест дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нөхцөл, чадамж зэргийг оруулжээ. Бэлчээр ашиглалт, эзэмшлийг сайжруулах, малын хулгай, хөдөөд гарч буй нийгмийн сөрөг үр дагавар бүхий гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гар харах явдлыг багасгах нь бизнест үзүүлж буй дарамтыг бууруулахад малчдын хувьд чухал ажээ.

***Хамгийн хурдацтай өсөж буй салбар:***

- МАА
- Худалдаа
- Гадны эзэдтэй аялал жуулчлал
- Газар тариалан
- Боловсрол
- Тээвэр

***Хамгийн их хөрөнгө оруулалт татах боломжийг бүрдүүлэх хүчин зүйлс:***

- Хүн амын өсөлт, боловсрол, мэргэжлийн харьцангуй сайн түвшин
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт сайн байгаа
- Дэд бүтэц сайтай, цаашид өргөжин хөгжих боломжтой
- Үйлчилгээ өргөжих нөхцөл бүрдсэн

***Хамгийн их уналттай салбар:***

- Ахуйн үйлчилгээ
- Эрүүл мэнд
- Мал эмнэлэг
- Бэлчээрийн нөөц, усан хангамж

***Бизнесийн хөгжилд саад болж буй сул талууд.***

- Архидалт
- Нийгмийн сахилга, хэв журмын зөрчил
- Ажилгүйдэл, ядуурал
- Хулгай гэмт хэрэг
- Ажлын хариуцлага сул
- Жижиг авилгал, гар харах явдал (малчдынхаар)

***Бизнесийн орчны үнэлгээ.*** Орон нутгийн бизнес орчны нөхцөл байдлыг сайжрах хандлагатай гэж үздэг оролцогчдын тоо орчин өөрчлөгдөөгүй гэсэнтэй бараг тэнцүү харагдаж байна.

- 41.2-50.0% нь сайжирсан
- 35.0-55.9% нь өөрчлөгдөөгүй

Гэхдээ судалгаанд оролцсон малчдын 15% нь сумаас хамаарахгүй шалтгаанаар бизнесийн орчин муудаж байна гэж хариулсан нь дээрхи байдлыг үүсгэж байгаа юм.

***Санхүү-зээлийн эх үүсвэр.*** Суманд үйл ажиллагаа явуулж буй хоёр гол банкнаас олгож буй зээлийн хэмжээ жил дараалан нэмэгдэж иржээ.

| Зээлийн эх үүсвэр, сая төг | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|---|---|---|---|---|---|
| • ХААН банк | 30.0 | 45.0 | 60.0 | 120.0 | 200.0 |
| • ХАС банк | | | 20.0 | 80.0 | 120.0 |

Ер нь хэрэглээнд зориулж бага хэмжээний зээлийг богино хугацаагаар авах явдал иргэд, байгууллагын дунд нэлээд байгаа, бизнесийн зээл огцом өсөхгүй байгаа ажээ.

## 5.2. СВОТ шинжилгээний дүн

Сумын эдийн засгийн бизнес орчны судалгааны дүнг үндэслэн СВОТ буюу орчны нөхцөл байдлын шинжилгээг хийлээ. СВОТ шинжилгээг хийхдээ олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй арга зүйг баримтлан сумын эдийн засгийн хөгжил, бизнесийн орчны давуу тал, боломж, сул тал, саад бэрхшээлүүдийг тодорхойлсон юм. Эдгээр тодорхойлогдсон үзүүлэлтүүдийг ашиглан сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулахдаа эдийн засаг, бизнесийн орчинг цаашид сайжруулах боломжийг «Давуу тал–боломж», «Давуу тал-саад бэрхшээл», «Сул тал–боломж», «Сул тал–саад бэрхшээл»-ийн хослолд оруулж тодорхойлсон нь их ач холбогдолтой боллоо. СВОТ шинжилгээний болон түүний хослолын матрицийг хавсаргав.

## СВОТ шинжилгээний матриц

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| **Давуу талууд** | **Сул талууд** | **Боломж** | **Саад бэрхшээл** |
| • Сумын захиргаанаас бизнес эрхлэгчидтэй ажиллах хугацаа хангалттай, боломжтой<br>• Бизнес өргөжүүлэх, шинээр эхлэх сонирхол, чин эрмэлзэл өндөр<br>• Бизнес эрхлэгчдээс сумын хөгжилд оруулж буй хувь нэмэр боломжийн<br>• Ажил эрхлэлтийн түвшин дунд зэрэг<br>• Ядуурлыг бууруулах арга хэмжээний хамрах хүрээ, өгөөж нэмэгдэж байгаа<br>• Орон нутагт явуулж буй сургалтын тоо, хамрах хүрээ нэмэгдэх хандлагатай байгаа<br>• Уламжлалт үйлдвэрлэл, үйлчилгээний чадавхи сайн<br>• Бизнес эрхлэгчдийн туршлага, арга барил одоо эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаатай тохирдог<br>• Бизнес өргөтгөх, шинээр эхлэх боломж хангалттай<br>• Банкны үйлчилгээ өргөжиж байгаа<br>• Мал аж ахуй, газар тариалан эрхлэх нөөц, боломж сайн<br>• Дотоод, гадаадын аялал жуулчлал хөгжүүлэх боломж сайн<br>• Үндэсний томоохон дэд бүтцэд холбогдох, байнга ашиглах боломж өндөр | • ЭЗХ–ийн асуудлыг сумаас нэгтгэн зангидах, хариуцах явдлыг сайжруулах шаардлагатай<br>• Сумын захиргаа, мэргэжилтнүүдээс бизнес мэдээлэл, дэмжлэг үзүүлэх явдал сул<br>• Бизнесийн нэгж, бүлгийг хуулийн этгээдийн статустай болгох, баталгаажуулах ажил хоцрогдонгүй<br>• Бизнес эрхлэгчдийн хамтач ажиллагаа, хоршилтын байдал арга хэлбэрээ хангалттай сайн олоогүй<br>• Орлого нэмэгдүүлэх болон үйл ажиллагаагаа салбарлуулах уламжлалт бус салбарыг дэмжих дэмжлэг сул<br>• Ажилгүйдэл, ядуурлыг тууштай бууруулж чадахгүй байгаа<br>• Бизнес эрхлэгчдээс сумын ЭЗХ–ийн арга хэмжээнд оролцож буй байдал хангалтгүй<br>• Үйлчилгээ, дэмжлэг авах талаар бизнес эрхлэгчдийн санаачлага хөөцөлдлөгөө сул хэвээр байгаа<br>• Суманд мөрдөж буй бизнесийн зохицуулалт хангалтгүй<br>• Хууль бус өрсөлдөөнд захиргааны зохицуулах оролцоо сул | • Эрчим хүч, зам харилцааны дэд бүтэц сайн хөгжсөн<br>• Хангaн нийлүүлэх ба борлуулалтын аймгийн зах зээлд ойр байрладаг, гарц сайн<br>• Сумын ба аймгийн төвийн зах зээлийн багтаамж сайн<br>• Гарцаа зөв олох, түүнийгээ барьж чадвал бусад томоохон зах зээлд гарах боломж харьцангуй сайн<br>• Суманд хөрөнгө оруулах чадавхи, сонирхолтой нутгийн бизнес эрхлэгчид бий<br>• Дотоодын хөрөнгө оруулалт суманд орж ирэх боломж харьцангуй магадлалтай<br>• ОУБ–ын хөтөлбөр, төслийн шугамаар дэмжлэг туслалцаа авах боломжийг сайн ашиглаж байгаа<br>• Үйлдвэрлэлийг өргөтгөх, шинээр эхлэхэд дэмжлэг болох дэд бүтцийн боломжтой<br>• Үндэсний хөтөлбөр, төслүүд түшиц газраар сонгох сонирхолтой | • Төрийн үйлчилгээ явуулахад санхүүгийн эх үүсвэр хуваариладаггүй<br>• Холбогдох хууль тогтоомж, бусад актуудын хэрэгжилт сул<br>• Хангaн нийлүүлэх төвлөрсөн ба гадаад зах зээлийн алслагдалт<br>• Зээлийн нөхцөл (хүү, эргэн төлөгдөх хугацаа, зээлийн хэмжээ) зохистой бус<br>• Зах зээлийн өрсөлдөөн цаашдаа улам нэмэгдэх хандлагатай<br>• Гадаадаас хөрөнгө оруулалт суманд орж ирэх боломж муу<br>• Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн олдоц, хүрэлцээ тааруу<br>• Бусад салбарыг дэмжих дэмжлэг гадны дэмжлэг сул<br>• Бизнесийн ба мэргэжлийн холбоодтой туслалцаа дэмжлэг авах холбоо сул<br>• Суманд иргэний нийгмийн байгууллагаас үйл ажиллагаа явуулдаггүй |

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| Давуу талууд | Сул талууд | Боломж | Саад бэрхшээл |
| • Газарзүйн ба зах зээлд гарах байршил тохиромжтой<br>• Сумын удирдлага, мэргэжилтнүүдийн чадавхи, туршлага хангалттай<br>• Сумын удирдлагатай хамтран ажиллах боломж сайн<br>• Үндэсний хөтөлбөр, төсөлд хамрагдалт өргөжиж байгаа<br>• Зөв ашиглаж чадвал байгалийн нөөц, өгөөж хангалттай<br>• Байгалийн ба түүх–соёлын дурсгалт газрууд, аялал жуулчлалын боломж бий<br>• Нутгийн уугуул иргэдээс дэмжлэг авах боломж бий | • Төрийн үйлчилгээний ба бизнес хоршилтод хүнд суртал оршсоор байгаа<br>• Гэмт хэрэг, хууль бус үйлдэл бүрмөсөн арилахгүй байгаа<br>• Ажилгүйчүүдийн боловсрол, мэргэжлийн түвшин доройй, мэргэжилгүй далд ажилгүйчүүд олон байгаа<br>• Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар дорвитой үр дүн гарахгүй байгаа<br>• Мэргэжилтэй ажиллах хүчний хангамж сул, олдоц муу<br>• Мэргэжлийн ба мэргэшүүлэх сургалт хангалтгүй<br>• Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эрсдэл даах чадвар сул<br>• Малчдын эрсдэлд эмзэг байдал, эрсдэл даах, нөхөн сэргэх чадвар сул<br>• Хурдацтай өсөж буй салбаруудаас сумын хөгжлийн нөөц бүрдүүлэлтэд үзүүлж буй нөлөө сул<br>• Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй<br>• Хууль, эрхзүйн зохицуулалтыг орон нутагт нийцүүлэн өөрчлөх, хийх боломж байхгүй<br>• Газрын, байгаль орчны гэх мэт гол хуулиудын хэрэгжилт сул, хангалтгүй<br>• Эрчим хүч, замын дэд бүтцийн боломжийг ашиглах явдал сул | • Дэд бүтэц, орон нутгийн инс–титуцийн хөгжлийн хувьд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх үндсэн шаардлагыг хангадаг | |

## 5.3. СВОТ шинжилгээний хослолын матриц

| Давуу тал–Боломж **(Дт–Бо)** | Давуу тал–Саад бэрхшээл **(Дт–Сб)** | Сул тал–Боломж **(Ст–Бо)** | Сул тал–Саад бэрхшээл **(Ст–Сб)** |
|---|---|---|---|
| **Дт1.Бо4.** МААГТ–ийн бүтээгдэхүүнийг аймгийн зах зээлд нийлүүлэх | **Ст1.Бо6.** ХАА–н үе шатны ажилд зээл авах нөхцлийг хөнгөвчлөх | **Ст1.Бо2.** Ажилгүйдэл ядуурлыг бууруулахад сумын гаралтай бизнесүүдийг оролцуулах | **Ст1.Сб1.** Төрийн ба ТББ иин дэмжих үйлчилгээг нэмэгдүүлэх |
| **Дт1.Бо5.** МААГТ–аас бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх | **Ст2.Бо2.** Газар, байгалийн нөөцийг ашиглахад гадаадын хөрөнгө оруулалтыг татах | **Ст2.Бо5.** ОНЭЗХ–ийн алба байгуулж, бренд бүтээгдэхүүнийг сурталчлах | **Ст2.Сб4.** ОНЭЗХ–ийн алба байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх |
| **Дт2.Бо2.** Газар, байгалийн нөөцийг ашиглахад хөрөнгө оруулалтыг татах | **Ст3.Бо1.** Аялал жуулчлалын дагалдах үйлчилгээг хөгжүүлэх | **Ст3.Бо3.** Хандивлагчид, ОУ–ын байгууллагуудад мэдээлэл түгээх | **Ст3.Сб5.** Бизнес эрхлэгчдийг зах зээлийн мэдээллээр хангах |
| **Дт3.Бо1.** Аялал жуулчлал хөгжүүлэх дэд бүтэц бий болгох | **Ст4.Бо5.** Зэргэлдээх аймаг болон сумын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах | **Ст4.Бо4.** Оролцогчдын хоршилт, хамтын ажиллагаанд тулгуурлан зах зээлд гарах | **Ст4.Сб3.** Төр, ТББ болон бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хангах |
| **Дт4.Бо2.** Зах зээлийн давуу талыг ашиглан хөрөнгө оруулалтыг татах | **Ст5.Бо1.** Төрийн үйлчилгээг явуулах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх | **Ст6.Бо3.** ОУ–ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн ажилтнуудыг сургах | **Ст5.Сб4.** Сахилга, дэг журмыг бэхжүүлэхэд анхаарах |
| **Дт5.Бо5.** Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих | **Ст6.Бо4.** Орон нутгийн төсвийн эрх мэдлийг өргөтгөх | **Ст7.Бо1.** Дэд бүтцийн хөгжлийг ашиглан эрсдлээс сэргийлэх | **Ст6.Сб3.** Олон төрлийн мэргэжил олгох сургалт зохион байгуулах |
| **Дт6.Бо3.** Бизнез өргөтгөх, шинээр эрхлэхэд ОУ–ын дэмжлэг авах | **Ст7.Бо3.** Төр бизнесийн байгуулагуудын ажлын уялдааг хангах | **Ст8.Бо2.** Орлого нэмэгдүүлэх шинэ салбар хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх | **Ст7.Сб2.** Гадаадын хөрөнгө оруулалтыг эрсдэл даах чадавхи бий болгоход зориулах |
| **Дт7.Бо5.** Үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд хамтран ажиллах | **Ст8.Бо2.** Хандивлагчид, ОУ–ын байгууллагын дэмжлэгийг өргөнөөр авах | **Ст9.Бо4.** Орон нутгийн бизнес орчныг сайжруулах | **Ст8.Сб6.** Гадаадын хөрөнгө оруулалтыг эрсдэл даах чадавхи бий болгоход зориулах |
| **Дт8.Бо2.** Ядуурлыг бууруулахад улсын төсөв, хөрөнгө оруулалтыг чиглүүлэх | | **Ст10.Бо5.** Экспортын ба бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | **Ст9.Сб4.** Бизнес орчныг сайжруулах |

## 5.4. “Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төсөл” матриц

*Алсын хараа: Домогт «Тайхар чулуу»-аар алдаршсан нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болно.*

| Зорилго | Зорилт | Хөтөлбөр | Төсөл | № |
|---|---|---|---|---|
| **Зо1.** Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгална | **Зо1.Зт1.** Ой, ус хамгаалах арга хэмжээ нийт нөөцийн 5 хүртэл хувийг хамарч байгааг 2015 онд 30 хувьд хүргэх | **Зо1.Зт1.Хө1.** Ой, усны нөөцийг хамгаалах | **Зо1.Зт1.Хө1.Т1.** Байгалийн усны эх үүсвэрийг хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх | 1 |
| | | | **Зо1.Зт1.Хө1.Т2.** Шинэсэн ба бургасан ойг нөхөн сэргээх | 2 |
| | **Зо1.Зт2.** Талхлагсан бэлчээр 104,5 мянган га байгааг 2015 он гэхэд 30 хувиар багасгах | **Зо1.Зт2.Хө1.** Бэлчээ–рийн менежментийг сайжруулах | **Зо1.Зт2.Хө1.Т1.** Бэлчээрийн хамтын менежмент хэрэгжүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | 3 |
| | | | **Зо1.Зт2.Хө1.Т2.** Бэлчээр усжуулах усны нөөцийн хайгуул, зураглал хийх | 4 |
| **Зо2.** Хүний хөгжлийг хангахуйц нийгмийн халамж, төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ | **Зо2.Зт1.** Ерөнхий боловсролын сургуульд сургуулийн насны хүүхдийн 5 хүртэл хувь нь хамрагдахгүй байгааг 2015 онд бүрэн хамруулах | **Зо2.Зт1.Хө1.** Боловсролын үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх | **Зо2.Зт1.Хө1.Т1.** Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар, тохижилтыг сайжруулах | 5 |
| | | | **Зо2.Зт1.Хө1.Т2.** “Чадварлаг багш–чанартай сургалт” хөтөлбөр боловсруулах | 6 |
| | | | **Зо2.Зт1.Хө1.Т3.** Мэргэжлийн сургалт, мэдээллийн төв байгуулах | 7 |
| | **Зо2.Зт2.** Хүн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 70 хувьтай байгааг 2015 онд бүрэн хангах | **Зо2.Зт2.Хө1.** Эрүүл мэндийн үйлчилгээ–ний нөхцлийг сайжруулах | **Зо2.Зт2.Хө1.Т1.** Хүн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах | 8 |
| | | | **Зо2.Зт2.Хө1.Т2.** Багийн хүний эмч нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах | 9 |
| | **Зо2.Зт3.** Соёл, урлаг, спортын арга хэмжээнд хүн амын дөнгөж 30 хувь нь хамрагдаж байгааг 2015 он гэхэд 2 дахин нэмэгдүүлэх | **Зо2.Зт3.Хө1.** Урлаг, соёл, спортыг хөгжүүлэх | **Зо2.Зт3.Хө1.Т1.** Спортын цогцолбор төв байгуулах | 10 |
| | | | **Зо2.Зт3.Хө1.Т2.** Соёлын төвийн барилгын их засвар, тохижилтыг сайжруулах | 11 |
| | | | **Зо2.Зт3.Хө1.Т3.** Ардын урлаг, спортын наадам зохион байгуулах | 12 |

| Зорилго | Зорилт | Хөтөлбөр | Төсөл | № |
|---|---|---|---|---|
| **Зо2.** Хүний хөгжлийг хангахуйц нийгмийн халамж, төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ | **Зо2.Зт4.** Одоо сумын хөдөөгийн холбоо, шуудангийн үйлчилгээний түвшин 20 хувьтай байгааг 2015 он гэхэд 80 хувьд хүргэх | **Зо2.Зт4.Хө1.** Холбоо, мэдээллийг сайжруулах | **Зо2.Зт4.Хө1.Т1.** Хөдөөгийн шуудангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | 13 |
| | | | **Зо2.Зт4.Хө1.Т2.** Хөдөөгийн баг, малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | 14 |
| | **Зо2.Зт5.** Иргэд, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж 5% байгааг 2015 он гэхэд 30%-д хүргэх | **Зо2.Зт5.Хө1.** Орон сууцны хангамж сайжруулах | **Зо2.Зт5.Хө1.Т1.** Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах | 15 |
| | | | **Зо2.Зт5.Хө1.Т2.** Иргэдэд үзүүлэх орон сууцны зориулалтын ипотек зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх | 16 |
| | **Зо2.Зт6.** Нийгмийн халамж үйлчилгээний шуурхай байдлын сэтгэл ханамж 60% байгааг 2015 онд 90 хувьд хүргэх (санал асуулгаар тодорхойлох) | **Зо2.Зт6.Хө1.** Сэтгэлд хүрсэн нийгмийн халамж | **Зо2.Зт6.Хө1.Т1.** Нийгмийн халамжийн үйлчилгээний орон нутагт зохицсон менежмент нэвтрүүлэх | 17 |
| | | | **Зо2.Зт6.Хө1.Т2.** Эмзэг бүлгийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | 18 |
| **Зо3.** Уламжлалт болон орчин үеийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, аялал жуулчлал эрчимтэй хөгжих нөхцлийг бүрдүүлнэ | **Зо3.Зт1.** Суурин мал аж ахуйн ферм ба туслах аж ахуйн тоо 2 байгааг 2015 он гэхэд 40-д хүргэх | **Зо3.Зт1.Хө1.** Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих | **Зо3.Зт1.Хө1.Т1.** МАА-газар тариалан хосолсон фермийн аж ахуй хөгжүүлэх загвар боловсруулах | 19 |
| | | | **Зо3.Зт1.Хө1.Т2.** “Туслах аж ахуй – өрхөд” хөтөлбөр боловсруулах | 20 |
| | | | **Зо3.Зт1.Хө1.Т3.** Малын тэжээлийн үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | 21 |
| | | | **Зо3.Зт1.Хө1.Т4.** Хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах сумын хөтөлбөр боловсруулах | 22 |
| | **Зо3.Зт2.** ХАА-н бүтээгдэхүүн түүхий эд, байгалийн баялгийн 5 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байгааг 2015 он гэхэд 20 хувьд хүргэх | **Зо3.Зт2.Хө1.** Боловсруулах чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх | **Зо3.Зт2.Хө1.Т1.** ХАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, маркетингийн судалгаа | 23 |
| | | | **Зо3.Зт2.Хө1.Т2.** Сумын шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | 24 |
| | | | **Зо3.Зт2.Хө1.Т3.** Ашигт малтмал, барилгын материалын үйлдвэрлэлийн нөөцийн зураглал хийх | 25 |
| | | | **Зо3.Зт2.Хө1.Т4.** “Хөгжлийн түншлэл” хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх | 26 |

| Зорилго | Зорилт | Хөтөлбөр | Төсөл | № |
|---|---|---|---|---|
| **Зо3.** Уламжлалт болон орчин үеийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, аялал жуулчлал эрчимтэй хөгжих нөхцлийг бүрдүүлнэ | **Зо3.Зт3.** Суманд хүлээн авч буй жуулчдын тоо одоо 500 байгааг 2007 оноос жил бүр10 хувиар нэмэгдүүлэх | **Зо3.Зт3.Хө1.** Аялал жуулчлал өргөжүүлэх | **Зо3.Зт3.Хө1.Т1.** Суманд аялал жуулчлал хөгжүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулах | 27 |
| | | | **Зо3.Зт3.Хө1.Т2.** Тайхар чулууны бичээсийг сэргээн засварлах | 28 |
| | | | **Зо3.Зт3.Хө1.Т3.** “Гэрээс гэрт жуулчлал–малчдад” санаачлагын дэд хөтөлбөр хөтөлбөр боловсруулах | 29 |
| | | | **Зо3.Зт3.Хө1.Т4.** Жуулчдад зориулсан үйлчилгээний бүс тогтоох | 30 |
| | **Зо3.Зт4.** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн хангамж 30 хувьтай байгааг 2015 он гэхэд 50 хувь хүртэл нэмэгдүүлэх | **Зо3.Зт4.Хө1.** Худалдаа, ахуйн үйлчилгээг сайжруулах | **Зо3.Зт4.Хө1.Т1.** Төрөлжсөн хүнсний зах ажиллуулах байраар хангах | 31 |
| | | | **Зо3.Зт4.Хө1.Т2.** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад орон нутгийн өмчийн байраар хангах | 32 |
| **Зо4.** Дэд бүтцийн хөгжил, сумын төвийн тохижилтод хөрөнгө оруулалт татна | **Зо4.Зт1.** Дэд бүтцийн хөрөнгө оруулалт сумын төсвийн 5 хувьтай тэнцэж байгааг жилд дундажаар 20 хувиар нэмэгдүүлэх | **Зо4.Зт1.Хө1.** Дэд бүтэц сайжруулах | **Зо4.Зт1.Хө1.Т1.** Цэцэрлэг–Ихтамирын 30 км хатуу хучилттай зам тавих | 33 |
| | | | **Зо4.Зт1.Хө1.Т2.** Борт багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбох | 34 |
| | **Зо4.Зт2.** 2008 оноос эхлэн сумын төвийн тохижилтод төсвийн орлогын 10% хувийг зарцуулдаг болох | **Зо4.Зт2.Хө1.** Сумын төвийн тохижилт | **Зо4.Зт2.Хө1.Т1.** Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | 35 |
| | | | **Зо4.Зт2.Хө1.Т2.** Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах | 36 |
| | | | **Зо4.Зт2.Хө1.Т3.** Дэмид жанжны нэрэмжит талбайн тохижилт | 37 |
| | | | **Зо4.Зт1.Хө1.Т4.** Сумын төвийн хог, хаягдлыг цэвэрлэх, боловсруулж устгах | 38 |

## 5.5. Төсөл хэрэгжүүлэлтийн матриц

| Төслийн № | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сая төг | ам. доллар | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | | | % | сая төг | % | сая төг | % | сая төг | | | | | |
| 1 | **Зо1.Зт1.Хө1.Т1.** Байгалийн усны эх үүсвэрийг хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх | 33.4 | | 3.0 | 1.0 | | | 97.0 | 32.0 | Хандив-лагч | 2007 | 2010 | ш | Нийт иргэд |
| 2 | **Зо1.Зт1.Хө1.Т2.** Шинэсэн ба бургасан ойг нөхөн сэргээх | 20.0 | | | | 10.0 | 2.4 | 90.0 | 17.6 | ЗГ | 2009 | 2015 | ш | Нийт иргэд |
| 3 | **Зо1.Зт2.Хө1.Т1.** Бэлчээрийн хамтын менежмент хэрэгжүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | 20.0 | | | | 50.0 | 10.0 | 50.0 | 10.0 | Малчид | 2009 | 2015 | э | Малчид |
| 4 | **Зо1.Зт2.Хө1.Т2.** Бэлчээр усжуулах усны нөөцийн хайгуул, зураглал хийх | 4.5 | | | | 33.3 | 1.5 | 66.7 | 3.0 | Хандив-лагч | 2008 | 2009 | ш | Малчид |
| 5 | **Зо2.Зт1.Хө1.Т1.** Сургууль, цэцэрлэгийн барилгын засвар, тохижилт хийх | 24.4 | | 3.3 | 0.8 | 2.5 | 0.6 | 94.2 | 23.0 | Хандив-лагч | 2007 | 2008 | хб | Нийт иргэд |
| 6 | **Зо2.Зт1.Хө1.Т2.** "Чадварлаг багш-чанартай сургалт"хөтөлбөр боловсруулах | 10.5 | | 19.0 | 2.0 | 4.8 | 0.5 | 74.2 | 8.0 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Нийт иргэд |
| 7 | **Зо2.Зт1.Хө1.Т3.** Мэргэжлийн сургалт, мэдээллийн төв байгуулах | 2.4 | | | | 25.0 | 0.6 | 75.0 | 1.8 | Хандив-лагч | 2007 | 2015 | э | Нийт иргэд |
| 8 | **Зо2.Зт2.Хө1.Т1.** Хүн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах | 13.0 | | | | | | 100.0 | 13.0 | Хандив-лагч | 2008 | 2012 | хб | Нийт иргэд |
| 9 | **Зо2.Зт2.Хө1.Т2.** Багийн хүний эмч нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах | 5.0 | | 20.0 | 1.0 | | | 80.0 | 4.0 | Хандив-лагч | 2008 | 2012 | ш | Хөдөөгийн иргэд |

| Төслийн № | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сая төг | ам. доллар | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | | | % | сая төг | % | сая төг | % | сая төг | | | | | |
| 10 | **3о2.3т3.Хө1.Т1.** Спортын цогцолбор төв байгуулах | 24.0 | | 23.8 | 5.0 | | | 72.2 | 18.0 | Хандив-лагч | 2009 | 2011 | ш | Нийт иргэд |
| 11 | **3о2.3т3.Хө1.Т2.** Соёлын төвийн барилгын их засвар, тохижилтыг сайжруулах | 25.6 | | | | | | 100.0 | 25.6 | Хандив-лагч | 2007 | 2008 | хб | Нийт иргэд |
| 12 | **3о2.3т3.Хө1.Т3.** Ардын урлаг, спортын наадам зохион байгуулах | 4.0 | | 25.0 | 1.0 | 25.0 | 1.0 | 50.0 | 2.0 | ШУБСЯ | 2008 | 2015 | ш | Нийт иргэд |
| 13 | **3о2.3т4.Хө1.Т1.** Хөдөөгийн шуудангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | 9.0 | | 44.4 | 4.0 | 22.2 | 2.0 | 33.4 | 3.0 | ЗГ | 2007 | 2008 | ш | Хөдөөгийн иргэд |
| 14 | **3о2.3т4.Хө1.Т2.** Хөдөөгийн баг, малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | 25.6 | | | | 39.1 | 10.0 | 60.9 | 15.6 | Хандив-лагч | 2007 | 2010 | э | Хөдөөгийн иргэд |
| 15 | **3о2.3т5.Хө1.Т1.** Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах | 260.0 | | | | 100 | 260 | | | ЗГ | 2007 | 2012 | хш | Нийт иргэд |
| 16 | **3о2.3т5.Хө1.Т2.** Иргэдэд үзүүлэх орон сууцны зориулалтын ипотек зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх | 2.8 | | 10.7 | 0.3 | | | 89.3 | 2.5 | Хандив-лагч | 2008 | 2012 | ш | Нийт иргэд |
| 17 | **3о2.3т6.Хө1.Т1.** Нийгмийн халамжийн үйлчилгээний орон нутагт зохицсон менежмент нэвтрүүлэх | 14.0 | | 21.3 | 2.0 | 5.3 | 0.5 | 74.0 | 11.5 | ЗГ | 2007 | 2009 | ш | Эмзэг бүлгийн иргэд |

| Төслийн № | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сая төг | ам. доллар | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | | | % | сая төг | % | сая төг | % | сая төг | | | | | |
| 18 | **Зо2.Зт6.Хө1.Т2.** Эмзэг бүлгийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | 4.0 | | 30.0 | 1.2 | | | 70.0 | 2.8 | Хандивлагч | 2008 | 2009 | хб | Эмзэг бүлгийн иргэд |
| 19 | **Зо3.Зт1.Хө1.Т1.** МАА–газар тариалан хосолсон фермийн аж ахуй хөгжүүлэх загвар боловсруулах | 20.0 | | | | | | 100.0 | 20.0 | Хандивлагч | 2007 | 2013 | ш | Малчид |
| 20 | **Зо3.Зт1.Хө1.Т2.** “Туслах аж ахуй–өрхөд” хөдөлгөөн хэрэгжүүлэх | 14.0 | | 16.6 | 2.0 | | | 83.4 | 12.0 | | 2007 | 2010 | ш | Малчид, тариаланчид |
| 21 | **Зо3.Зт1.Хө1.Т3.** Малын тэжээлийн үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 10.0 | | 30.0 | 3.0 | | | 70.0 | 7.0 | Хандивлагч | 2008 | 2011 | хб | Малчид, тариаланчид |
| 22 | **Зо3.Зт1.Хө1.Т4.** Хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах сумын хөтөлбөр хэрэгжүүлэх | 25.0 | | | | | | 100.0 | 25.0 | Хандивлагч | 2008 | 2009 | хб | Малчид |
| 23 | **Зо3.Зт2.Хө1.Т1.** ХАА–н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, маркетингийн судалгаа хийх | 5.0 | | | | | | 100.0 | 5.0 | Хандивлагч | 2008 | 2008 | ш | Бизнес эрхлэгчид |
| 24 | **Зо3.Зт2.Хө1.Т2.** Сумын шилмэл мал, шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | 5.5 | | 36.4 | 2.0 | | | 63.6 | 3.5 | Хандивлагч | 2007 | 2015 | ш | Бизнес эрхлэгчид |

| Төслийн № | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сая төг | ам. доллар | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандив-лагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | | | % | сая төг | % | сая төг | % | сая төг | | | | | |
| 25 | **Зо3.Зт2.Хө1.Т3.** Ашигт малтмал, барилгын материалын үйлдвэрлэлийн нөөцийн зураглал хийх | 7.0 | | 11.4 | 0.8 | | | 88.6 | 6.2 | Хандив-лагч | 2009 | 2010 | ш | Бизнес эрхлэгчид |
| 26 | **Зо3.Зт2.Хө1.Т4.** "Хөгжлийн түншлэл" хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх | 5.4 | | 24.0 | 1.3 | | | 76.0 | 4.1 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Бизнес эрхлэгчид |
| 27 | **Зо3.Зт3.Хө1.Т1.** Суманд аялал жуулчлал хөгжүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулах | 2.0 | | 10.0 | 0.2 | | | 90.0 | 1.8 | Хандив-лагч | 2008 | 2009 | ш | Бизнес эрхлэгчид |
| 28 | **Зо3.Зт3.Хө1.Т2.** Тайхар чулууны бичээсийг сэргээн засварлах | 1.8 | | 33.3 | 0.6 | | | 66.7 | 1.2 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Нийт иргэд |
| 29 | **Зо3.Зт3.Хө1.Т3.** "Гэрээс гэрт жуулчлалд" малчдыг хамруулах дэд хөтөлбөр боловсруулах | 35.0 | | 71.4 | 25.0 | | | 28.6 | 10.0 | Хандив-лагч | 2007 | 2008 | хб | Малчид |
| 30 | **Зо3.Зт3.Хө1.Т4.** Жуулчдад зориулсан үйлчилгээний бүс тогтоох | 2.7 | | 37.0 | 1.0 | | | 63.0 | 1.7 | Хандив-лагч | 2009 | 2010 | ш | Жуулчид |
| 31 | **Зо3.Зт4.Хө1.Т1.** Хүнсний төрөлжсөн зах ажиллуулах байраар хангах | 35.0 | | 14.3 | 5.0 | 14.3 | 5.0 | 71.4 | 25.0 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Нийт иргэд |
| 32 | **Зо3.Зт4.Хө1.Т2.** Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад орон нутгийн өмчийн байраар хангах | 18.0 | | 33.3 | 6.0 | | | 66.7 | 12.0 | Хандив-лагч | 2010 | 2011 | ш | Бизнес эрхлэгчид |
| 33 | **Зо4.Зт1.Хө1.Т1.** Цэцэрлэг–Заанхошуу (Ихтамир сумын төв) хүртэл 31 км хатуу хучилттай зам тавих | 650.0 | | | | 100 | 650 | | | ЗГ | 2007 | 2009 | хш | Нийт иргэд |

| Төслийн № | Төслийн код, нэр | Өртөг | | Санхүүжилт | | | | | | Түншүүд | Хэрэгжүүлэлт | | Хэрэгжилтийн байдал | Ашиг хүртэгчид |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сая төг | ам. доллар | Орон нутаг | | Улсын төсөв | | Хандивлагчид | | | Эхлэх | Дуусах | | |
| | | | | % | сая төг | % | сая төг | % | сая төг | | | | | |
| 34 | **Зо4.Зт1.Хө1.Т2.** Борт багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбох | 10.0 | | | | 50.0 | 5.0 | 50.0 | 5.0 | ЗГ | 2011 | 2012 | ш | Хөдөөгийн иргэд |
| 35 | **Зо4.Зт2.Хө1.Т1.** Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | 5.6 | | 10.7 | 0.6 | | | 89.3 | 5.0 | Хандив-лагч | 2008 | 2009 | ш | Нийт иргэд |
| 36 | **Зо4.Зт2.Хө1.Т2.** Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтыг шинэчлэн сайжруулах | 9.7 | | | | 20.6 | 2.0 | 79.4 | 7.7 | Хандив-лагч | 2009 | 2010 | ш | Нийт иргэд |
| 37 | **Зо4.Зт2.Хө1.Т3.** Дэмид жанжны нэрэмжит талбайг тохижуулах | 8.7 | | 25.2 | 2.2 | 34.4 | 3.0 | 40.3 | 3.5 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Нийт иргэд |
| 38 | **Зо4.Зт1.Хө1.Т4.** Сумын төвийн хог, хаягдлыг боловсруулах, устгах | 9.7 | | 10.3 | 1.0 | | | 89.7 | 8.7 | Хандив-лагч | 2007 | 2008 | ш | Нийт иргэд |
| | **Дүн** | 1376.3 | | | 68.3 | | 950.1 | | 357.9 | | | | | |

Тэмдэглээ: ш – шинээр эхлэх, х – эхэлж байгаа, хб – санхүүжилт хайж байгаа

## 5.6. Төслийн эрэмбийн матриц

| № | Төслийн код, нэр | Хатуу (х), зөөлөн (з) | Нэн чухал | Чухал | Чухал биш | Байр |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | **Зо4.Зт1.Хө1.Т1.** Цэцэрлэг–Заанхошуу (Ихтамир сумын төв) хүртэл 31 км хатуу хучилттай зам тавих | х | 15 | 4 | | **1** |
| 38 | **Зо4.Зт1.Хө1.Т4.** Сумын төвийн хог, хаягдлыг цэвэрлэх, боловсруулж устгах | х | 14 | 5 | | **2** |
| 1 | **Зо1.Зт1.Хө1.Т1.** Байгалийн усны эх үүсвэрийг хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх | з | 12 | 8 | | **3** |
| 35 | **Зо4.Зт2.Хө1.Т1.** Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | з | 12 | 6 | | **4** |
| 3 | **Зо1.Зт2.Хө1.Т1.** Бэлчээрийн хамтын менежмент хэрэгжүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | з | 11 | 9 | 1 | **5** |
| 27 | **Зо3.Зт3.Хө1.Т1.** Суманд аялал жуулчлал хөгжүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулах | з | 10 | 8 | 1 | **6** |
| 4 | **Зо1.Зт2.Хө1.Т2.** Бэлчээр усжуулах усны нөөцийн хайгуул, зураглал хийх | з | 10 | 7 | 1 | **7** |
| 22 | **Зо3.Зт1.Хө1.Т4.** Хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах сумын хөтөлбөр хэрэгжүүлэх | х | 9 | 10 | | **8** |
| 8 | **Зо2.Зт2.Хө1.Т1.** Хүн эмнэлгийн салбарын тоног төхөөрөмжийг сайжруулах | х | 9 | 9 | 2 | **9** |
| 14 | **Зо2.Зт4.Хө1.Т2.** Хөдөөгийн баг, малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах | х | 9 | 8 | 2 | **10** |
| 6 | **Зо2.Зт1.Хө1.Т2.** "Чадварлаг багш–чанартай сургалт" хөтөлбөр боловсруулах | з | 8 | 11 | 2 | **11** |
| 36 | **Зо4.Зт2.Хө1.Т2.** Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтыг хийх | х | 8 | 10 | | **12** |
| 19 | **Зо3.Зт1.Хө1.Т1.** МАА–газар тариалан хосолсон фермийн аж ахуй хөгжүүлэх загвар боловсруулах | х | 8 | 10 | 1 | **13** |
| 11 | **Зо2.Зт3.Хө1.Т2.** Соёлын төвийн барилгын их засвар, тохижилтыг сайжруулах | х | 8 | 10 | 2 | **14** |
| 37 | **Зо4.Зт2.Хө1.Т3.** Дэмид жанжны нэрэмжит талбайг засч тохижуулах | х | 8 | 9 | 1 | **15** |
| 2 | **Зо1.Зт1.Хө1.Т2.** Шинэсэн ба бургасан ойг нөхөн сэргээх | х | 6 | 13 | 2 | **16** |
| 24 | **Зо3.Зт2.Хө1.Т2.** Сумын шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | з | 6 | 12 | 1 | **17** |
| 18 | **Зо2.Зт6.Хө1.Т2.** Эмзэг бүлгийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | з | 6 | 12 | 1 | **18** |
| 29 | **Зо3.Зт3.Хө1.Т3.** "Гэрээс гэрт жуулчлалд" санаачлагын хөдөлгөөн хэрэгжүүлэх | з | 6 | 12 | 2 | **19** |

| № | Төслийн код, нэр | Хатуу (х), зөөлөн (з) | Нэн чухал | Чухал | Чухал биш | Байр |
|---|---|---|---|---|---|---|
| 21 | **Зо3.Зт1.Хө1.Т3.** Малын тэжээлийн үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | з | 6 | 10 | 2 | **20** |
| 30 | **Зо3.Зт3.Хө1.Т4.** Жуулчдад зориулсан үйлчилгээний бүс тогтоох | х | 6 | 11 | 1 | **21** |
| 34 | **Зо4.Зт1.Хө1.Т2.** Борт багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбох | х | 6 | 10 | 3 | **22** |
| 32 | **Зо3.Зт4.Хө1.Т2.** Худалдаа, ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад орон нутгийн өмчийн байраар хангах | х | 6 | 9 | 4 | **23** |
| 28 | **Зо3.Зт3.Хө1.Т2.** Тайхар чулууны бичээсийг сэргээн засварлах | х | 6 | 7 | 6 | **24** |
| 26 | **Зо3.Зт2.Хө1.Т3.** “Хөгжлийн түншлэл” хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх | з | 6 | 6 | 7 | **25** |
| 17 | **Зо2.Зт6.Хө1.Т1.** Нийгмийн халамжийн үйлчилгээний орон нутагт зохицсон менежмент нэвтрүүлэх | з | 5 | 13 | 1 | **26** |
| 7 | **Зо2.Зт1.Хө1.Т3.** Мэргэжлийн сургалт, мэдээллийн төв байгуулах | з | 5 | 11 | 2 | **27** |
| 15 | **Зо2.Зт5.Хө1.Т1.** Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах | х | 5 | 10 | 4 | **28** |
| 16 | **Зо2.Зт5.Хө1.Т2.** Иргэдэд үзүүлэх орон сууцны зориулалтын ипотек зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх | з | 5 | 9 | 6 | **29** |
| 13 | **Зо2.Зт4.Хө1.Т1.** Хөдөөгийн шуудангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | х | 4 | 13 | 2 | **30** |
| 20 | **Зо3.Зт1.Хө1.Т2.** “Туслах аж ахуй-өрхөд” хөдөлгөөн хэрэгжүүлэх | з | 4 | 12 | 2 | **31** |
| 31 | **Зо3.Зт4.Хө1.Т1.** Төрөлжсөн хүнсний зах ажиллуулах байраар хангах | х | 4 | 12 | 3 | **32** |
| 12 | **Зо2.Зт3.Хө1.Т3.** Ардын урлаг, спортын наадам зохион байгуулах | з | 4 | 10 | 5 | **33** |
| 23 | **Зо3.Зт2.Хө1.Т1.** ХАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, маркетингийн судалгаа хийх | з | 3 | 15 | 1 | **34** |
| 5 | **Зо2.Зт1.Хө1.Т1.** Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар, тохижилтыг сайжруулах | х | 3 | 14 | 2 | **35** |
| 10 | **Зо2.Зт3.Хө1.Т1.** Спортын цогцолбор төв байгуулах | х | 3 | 13 | 4 | **36** |
| 9 | **Зо2.Зт2.Хө1.Т2.** Багийн хүний эмч нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах | з | 2 | 14 | 3 | **37** |
| 25 | **Зо3.Зт2.Хө1.Т3.** Ашигт малтмал, барилгын материалын үйлдвэрлэлийн нөөцийн зураглал хийх | з | 2 | 14 | 5 | **38** |

# 5.7. Бизнесийн хөгжлийг дэмжих стратегийн чиглэлүүд

| №1 | Монгол үндэсний хувцас |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумандаа монгол үндэсний хувцас хийж дэлгэрүүлж ажиллана.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Л.Долгормаа, утас: 99336889

| № 2 | Тамирын цагаан ааруул |
|---|---|

Товч тодорхойлолт: "Тамирын цагаан ааруул" нэртэйгээр олны хүртээл болсон сүүн хуруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанар, борлуулалтыг сайжруулснаар экологийн цэвэр бүтээгдэхүүнээр нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болгоход оршино.
Холбоо барих байгууллага, хаяг, утас: ӨУБМААЭШСХ, утас: 99780561

| № 3 | Цэвэр ус |
|---|---|

Товч тодорхойлолт: Эрүүл ахуйн нөхцөлд савласан цэвэр усаар хүмүүсийг хангах
Холбоо барих хүн, хаяг, утас: Г.Лхагвасүрэн, "Шинэ өргөө" ХХК, утас: 99768435

| № 4 | Гялгар цаас боловсруулах |
|---|---|

Товч тодорхойлолт: Сум орон нутагт гялгар цаасыг цуглуулж төрөлжүүлэн боловсруулж бэлэн бүтээгдэхүүн болгож, эргэн ашиглах
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Э.Нарангэрэл, утас: 99932305

| № 5 | Жимс тарих |
|---|---|

Товч тодорхойлолт: Айл өрх бүр гаднаа мод жимс тарих нь (i) Өрхийн хэрэгцээгээ хангах, (ii) Орчныг үзэмжтэй болгох, (iii) Жимс жимсгэнийг зарж борлуулах ач холбогдолтой
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д.Нарантуяа, утас 99791548

| № 6 | Хөдөөгийн фермерийн аж ахуй |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумандаа төрөлжсөн хөдөөгийн фермерийн аж ахуй байгуулах
Холбоо барих хүн, хаяг, утас: Г.Лхагвасүрэн, "ОАЖН" ХХК –ийн захираль утас: 99768135

| № 7 | Тоосго үйлдвэрлэх |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумандаа тоосго үйлдвэрлэх, хэрэгцээг хангах
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн С.Нямцэрэн, өндөр настан

| № 8 | Халуун ус, саун |
|---|---|

Товч тодорхойлолт: Ихтамир сумын 2015 он хүртлэх хөгжлийн стратегид дэмжлэг үзүүлэх, бүх насны хүмүүсийн эрүүл ахуй, соёлжилтыг сайжруулах
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Ц.Жарантай, утас: 99709922

| № 9 | Арьс шир боловсруулах |
|---|---|

Товч тодорхойлолт: Хөдөө суурин газар жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ард иргэдийн гар дээр байгаа арьс ширийг худалдан авч орлого нэмэгдүүлэхийн зэрэгцээ орон нутгийн гутлын түүхий эдээр хангах зорилготой
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д.Дагдан, утас: 99935793

| № 10 | Тарвага |
|---|---|

Товч тодорхойлолт: Тарваганы тоо толгойг өсгөж, үржүүлэн байгалиа хамгаалах, улмаар мах арьсыг ашиглаж өөрийн аж амьдралаа дээшлүүлэх, сумын эдийн засагт тус нэмэр болох
Холбоо барих хүн, хаяг, утас: малчин Д.Батбаатар, утас: 99891108

| № 11 | Радио телевиз цахилгаан тоног төхөөрөмжийн засвар |
|---|---|

Товч тодорхойлолт: Их тамир суманд засварын жижиг үйлчилгээ бий болгох
Холбоо барих хүн, хаяг, утас: засварчин Д.Сономбазар, утас: 99661185

| № 12 | Авто засвар үйлчилгээний төв |
|---|---|

Товч тодорхойлолт: Орон нутгийн тээврийн хэрэгсэлд болон зорчигчидод үйлчлэх, төв замын дагуу байрлалтай газар юм. Энэ засварын газрыг байгуулсанаар жуулчид, зорчигчид, орон нутгийн тээврийн хэрэгслийн өнгө үзэмж сайжрах, аятай тухтай зорчиход дэмжлэг үзүүлэхэд шууд нөлөөлөх ач холбогдол бүхий арга хэмжээ болно.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн М.Лхамрагчаа, утас: 99873925

| № 13 | Отрын гэр |
|---|---|

Товч тодорхойлолт: Өөрийн ба хөрш сумдын малчдыг отрын гэрээр хангах
Холбоо барих хүн, хаяг, утас: мужаан Хэнмэдэх, утас: 99947024

| № 14 | Монгол самар төсөл |
|---|---|

Товч тодорхойлолт: Их тамир суманд самар их ургадаг. Зарим жил дараа оны зун болтол самарчид ууланд самар түүдэг. Түүсэн самраа аймаг, УБ оруулж ченжүүдэд /асар их зардал гарган/ зардаг. Иймд орон нутагтаа самар цайруулах, савлах ажиллагааг орчмн үеийн тоног төхөөрөмжөөр хийж, гадаадад экспортонд гаргах зорилготой.
Холбоо барих байгууллага, хаяг, утас: Б.Лусмаа, "Их зууч" хоршооны дарга

| № 15 | Байгаль орчны нөхөн сэргээлт |
|---|---|

Товч тодорхойлолт: Байгаль орчныг нөхөн сэргээх хамгаалах. Сумын ногоон бүсийг хамгаалсанаар байгалийн үзэсгэлэнт байдлыг хангах
Холбоо барих хүн, хаяг, утас: Байгаль орчны байцаагч Б Тунгалаг

| № 16 | Шохойн цех |
|---|---|

Товч тодорхойлолт: Орон нутгийн байгалийн баялагийг ашиглан барилгын материалыг сумандаа үйлдвэрлэх чухал ач холбогдолтой бизнес хөгжинө.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д Дагдан, утас: 99935793

| № 17 | Хагас боловсруулсан бүтээгдэхүүн |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумын хэмжээнд одоогоор ЖДҮ-ийн чанартай үйлдвэрлэл, үйллчилгээ хөгжөөгүй, бүх төрлийн бараа бүтээгдхүүнийг аймгийн төв болон УБ хотоос авдаг. Иймд зарим нэр төрлийн хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хадгалах, бусад үйлчилгээний салбарууд болон албан байгууллаудын хэрэгцээнд нийлүүлэх шаардлагатай.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д Дагдан, утас: 99935793

| № 18 | Хамгаалагдсан хөрсөнд хүнсний ногоо тарих |
|---|---|

Товч тодорхойлолт: Эрт ургацын ногоогоор сумын иргэдийг хангах, байгаль цаг уурын тохиромжгүй нөхцөлд тогтмол арвин ургац авах ургацын хэмжээ чанарыг нэмэгдүүлэх боломжтой
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д.Пунсалмаа

| №19 | Хүнсний ногоо боловсруулах цех |
|---|---|

Товч тодорхойлолт: Сум орон нутгийн хүнсний ногоог боловсруулж эрүүл хүнсээр хангаж, сав баглаа боодолтой болгох, жилийн туршид хангаж хүнсний ногоог жижиглэн савлаж ард иргэд болон худалдаа үйлчилгээний газруудыг хангаж эдийн засгийн нөхцөлт бололцоонд тулгуурлан жижгээр савлаж зах зээлд нийлүүлж борлуулах цэг, үйлчилгээний газрууд бий болгох зорилготой.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Дэлгэрмаа, утас: 99872944

| № 20 | Барилга засварын бригад байгуулах |
|---|---|

Товч тодорхойлолт: Их тамир сум нь хүн амын төвлөрөлт их аймгийн төвтэй ойрхон оршдог сум юм. Барилга засварын ажил тасралтгүй явагддаг ба хуучин НДҮ – н мэргэжлийн ажилчин олонтой тийм учраас гадны хөрөнгө оруулалтаар хийгдэж буй засварын ажлыг өөрсдийн хүчээр хийх засварын бригад байгуулан ажиллах хүн амынхаа орлогыг дээшлүүлж сумын төсөвт зохих хэмжээний дэмжлэг үзүүлж чадах юм гэж үзэж байна.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д.Саранцэцэг

| № 21 | Чөлөөт цаг, чийрэгжүүлэлт |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумын тахир дутуу иргэдийн хамт олны дунд орох оролцоо сайжирна.
Үе мөчний өвчнөөс урьдчилан сэргийлэх хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх эрүүл чийрэг бие бялдартай болох
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Ц.Жарантай, утас: 99709927

| № 22 | Блокны цех |
|---|---|

Товч тодорхойлолт: Сумын хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн түүхий эд материалыг түшиглэн барилгын материал үйлдвэрлэх, аймаг орон нутгийн иргэдийг барилгын материалаар хангах зорилготой.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Ч.Шагдаржав, утас: 99932355

| № 23 | Зочид буудал |
|---|---|

Товч тодорхойлолт: Үйлчлүүлэгчдийн сэтгэлд бүрэн нийцсэн тав тухтай орчныг мэдрүүлэх Тэргүүн зэргийн байлгах зорилготой Ингэсэнээр үйлчлүүлэгчдийн хүрээ өргөжинө.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Д.Чимгээ, утас: 99806969

| № 24 | Зайрмагны үйлдвэр |
|---|---|

Товч тодорхойлолт: Хөдөө суурин газар ЖДҮ хөгжүүлж, ядуурлыг бууруулахын хамт ажлын байр нэмэгдүүлж, ард иргэдийн гар дээр байгаа сүү, сүүн бүтээгдэхүүнийг худалдан авч орлого нэмэгдүүлэхийн зэрэгцээ экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ард иргэдийг хангах, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.
Холбоо барих хүн, хаяг, утас: иргэн Түвшинтунгалаг

## 5.8. Төслийн товч танилцуулга

| № 1 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө1:Т1: Байгалийн усны нөөцийг хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө1: Ой, усны нөөцийг хамгаалах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Манай орны бүх нутагт сүүлийн үед тохиолдож буй гандалт, хуурайшилтын нөлөөнөөс гадна мал хэт бөөгнөрүүлэх, бохирдуулах зэргээр ил усны эх үүсвэрийг хамгаалалтгүйгээр хайр гамгүй ашигласнаас олон горхи, булаг ширгэж, хүн амын ба бэлчээрийн усан хангамж хүндрэлтэй болж байгаа нөхцөлд байгалийн усны нөөцийг хамгаалахад олон нийтийн оролцоог идэвхжүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино. Сумын байгууллага, малчид, малчдын бүлэг, иргэдийн хүч, оролцоотойгоор усны эх, ундрагыг хашиж хамгаалах, гар худаг гаргах, гүний худаг засварлах, ус өргөх төхөөрөмжөөр тоноглох зэргээр ус ашиглагчид тал бүрээс нь дэмжин хоршиж ажиллах нь ундны ба малын усан хангамжийг сайжруулах төдийгүй бэлчээр нутгаа зохистой ашиглахад ач холбогдолтой арга хэмжээ болно.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Усны эх үүсвэрийг ашиглагчдын хүч оролцоотойгоор хамгаалах боломж бүрдэх<br>• Бэлчээр нөхөн сэргээх, сэлгэх арга хэмжээг усны хангамжтай холбоотой хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ. | **Зорилтот бүлэг:**<br>• Малчид, малчдын бүлэг<br>• Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Малчид, иргэд<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Малчид<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Усны эх үүсвэрийн тооллого хийгдсэн, ашиглалтын одоогийн байдал тодорхойлогдсон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 33.4**<br>• Материалын зардал – 5.0<br>• Тоног төхөөрөмж – 9.0<br>• Сургалт, мэдээлэл – 4.0<br>• Сургалтын гарын авлага, тараах материал – 2.0<br>• Цалин шимтгэл – 1.0<br>• Засвар үйлчилгээний зардал – 12.4 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| 1.0 | 0.4 | 32.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажилд төсөл дууссанаас жилийн дараа эхлэнэ |

| № 2 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө1:Т2: Шинэсэн ба бургасан ойг нөхөн сэргээх | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө1**:** Ой, усны нөөцийг хамгаалах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Түймэрт автсан, зохицуулалт муутай хэт ашиглалтын улмаас шинэсэн ойн зарим хэсэг ихээхэн шингэрч байгалийн аясаар сэргэх боломжгүй болоод байна. Тамирын голын сав дагуух бургасан шугуй олон жилийн гандалт, хуурайшилтад өртөн сумын төвийн орчим хэсгээрээ хатах хандлага нэмэгдэх төлөв хүчтэй ажиглагдаж эхэллээ. Иймээс сумынхаа шинэсэн ба бургасан ойн боломжтой хэсгийг нь хамгаалалтад авах, нөхөн сэргээхтэй холбогдсон судалгаа хийх, дүгнэлт гаргах, цаашилбал тодорхой арга хэмжээг сумынхны хүчээр болон хандивлагчдын дэмжлэгтэйгээр үе шаттай хэрэгжүүлж эхлэх, тогтворжуулах арга замыг туршин тогтоох, өргөжүүлэхэд төслийн үйл ажиллагаа чиглэгдэнэ. Ойн ногоон бүсийг хамгаалж, нөхөн сэргээснээр гадаргын усны байгалийн нөхөлт, урсацын түвшинг бууруулахгүй байлгах, ой бүхий газрын байгалийн үзэсгэлэнт байдлыг хамгаалах, хадгалахад холбогдолтой юм.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалтын бодлогын үндэслэл тодорхойлогдох<br>• Ой нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ төлөвших<br>• Олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар байгалийн нөөцийг хамгаалах идэвхжүүлэлт, зохион байгуулалтын загварчлал боловсрогдох | • Сумын ЗДТГ<br>• Орон нутгийн иргэд<br>• Малчдын бүлгүүд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Орон нутгийн захиргаа<br>• Байгаль хамгаалагчид<br>• Төрийн бус байгууллага | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Иргэд, аж ахуйн нэгж<br>• Улсын төсөв<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, зэхэц:**<br>• Төсөл хэрэгжүүлэх ажиллах хүч байгаа | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Санхүүгийн их үүсвэр хангалтгүй<br>• Ган, ойн түймэр<br>• Мод түлшинд хэрэглэх явдал их |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 20.0**<br>• Материалын зардал – 9.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 3.6<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Судалгаа шинжилгээ – 3.0<br>• Суулгац – 2.4 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчдад санал болгох** |
|---|---|---|
| | 2.4 | 17.6 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2009 оноос жил бүр тодорхой төлөвлөгөө хуваарьтай хэрэгжүүлэх | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:**<br>Төсөл эхлэснээс хойш үйл ажиллагааг үргэлжлүүлж үр дүнг тогтворжуулна |
|---|---|

| № 3 | **Төсөл:** Зо1:Зт2:Хө1:Т1: Бэлчээрийн хамтын менежмент хэрэгжүүлэх сумын хөтөлбөр | **Хөтөлбөр:** Зо1:Зт2:Хө1: Бэлчээрийн менежментийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Бэлчээр, бэлчээр дэх бусад нөөцийг хамгаалах, сайжруулах, хуваарьтай ашиглах, хамгаалах асуудлыг малчдын бүлэг, хэсэгт түшиглэн хэрэгжүүлснээр бэлчээрийн хамтын менежментийг өргөн хүрээнд зохион байгуулалтын ба менежментийн шинэ арга хэлбэрээр нэвтрүүлэх боломжийг тусгасан сумын хөтөлбөр боловсруулахад төслийн үйл ажиллагааг чиглүүлнэ. Төсөл хэрэгжүүлснээр МАА–н бүтээмж, малын ашиг шим дээшилж малчин өрхийн амьжиргаа, орлогын эх үүсвэр нэмэгдэхээс гадна ядуурлыг бууруулах үндэслэл болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Бэлчээр ашиглалтыг нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломж бүрдэх<br>• Бэлчээрийн менежментийн үр ашигтай шинэ хэлбэр нэвтрэх<br>• Бэлчээрийн зураглалтай болох<br>• Бэлчээр хамгаалах арга хэмжээг малчдын хоршилт, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх | • Малчид, мал бүхий иргэд, байгууллага<br>• Сумын ЗДТГ |
| **Төслийн хамтран хэрэгжүүлэгчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Малчид, малчдын бүлэг<br>• Газрын даамал | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Малчид<br>• Сум багийн байгаль хамгаалагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Тус суман дахь Өндөр уулын бүсийн эрдэм шинжилгээний станцаас дэмжлэг авах боломжтой<br>• Малчдад сургалт хийж, анхны мэдлэгтэй болгосон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Байгалийн ган зуд тохиолдох<br>• Хууль тогтоомжийг биелүүлэхгүй байх |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд 20.0**<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 3.5<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт 4.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 4.0<br>• Зураг төсөв – 3.0<br>• Судалгаа шинжилгээ – 3.5 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчдад санал болгох** |
|---|---|---|
| | 10.0 | 10.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Өндөр уулын бүсийн эрдэм шинжилгээний станц

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжих үеэс эхлэн үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 4 | **Төсөл:** Зо1.Зт2.Хө1.Т2: Бэлчээр усжуулах усны нөөцийн хайгуул, зураглал хийх | **Хөтөлбөр:** Зо1.Зт2.Хө1: Бэлчээрийн менежмент сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Гандалт, хуурайшилтын эрч, хамрах хүрээ өнөөгийн байдлаар үргэлжлэх тохиолдолд гадаргын усны эх, ундрагыг хашиж хамгаалах, зохистой ашиглах замаар бэлчээрийн усан хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж нэн хомс болох нь тодорхой. Цаашид хуучин худаг сэргээн засварлах, инженерийн хийцтэй худаг шинээр гаргах зэргээр гүний усны нөөцийг ашиглахад эртнээс анхаарч шаардлагатай арга хэмжээг одооноос авч эхлэх хэрэгтэй байна. Ийм арга хэмжээний нэг нь бэлчээр усжуулах усны нөөцийн хайгуул, зураглал хийх ажил юм. Хүн амын ундны болон малын усны хангамжийг сайжруулах нь бэлчээр ашиглалт, эзэмшлийг баталгаажуулах, нөөцийн хамтын менежмент (Зо1:Зт1:Хө1:Т1: Байгалийн усны нөөцийг хамгаалахад олон нийтийн оролцоог дээшлүүлэх) зэрэг стратегид тусгагдсан бусад төслүүдтэй уялдаатай хэрэгжүүлэх төлөвлөлтийн ба лавлах материал болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Усны нөөцийн зураглалтай болох<br>• Бэлчээр усжуулах ажлыг бэлчээр нөхөн сэргээх, сэлгэх арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх боломж сайжрах | • Малчид, малчдын бүлэг<br>• Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Малчид, иргэд<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 4.5**<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 3.0<br>• Зураг төсөв – 1.5 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| | 1.5 | 3.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажил төсөл дууссанаас жилийн дараа эхлэнэ |
|---|---|

| № 5 | **Төсөл:** Зо2:Зт1:Хө1:Т1: Сургууль, цэцэрлэгийн барилгын засвар, тохижилтыг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт1:Хө1: Боловсролын ба мэргэшүүлэх үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тус сумын дунд сургууль, цэцэрлэгийн ажиллагааг сайжруулснаар боловсролын залгамж холбоог орон нутагт бэхжүүлэх үндэс бүрдэнэ. Төрийн зүгээс боловсролын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанартай холбоотой чухал асуудал юм. Тус сумын цэцэрлэг гэхэд 1970 онд байгуулагдсанаас хойш барилгын их засвар хийгээгүй, шал, дээвэр, ахлах ба дунд насны бүлгийн хичээл, амралтын өрөөний хана, туургад ан цав нуралт үүсээд байна. Эдгээр сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа ямар нэг байдлаар тасалдах юм уу хязгаарлагдахад хүрвэл сургуулийн өмнөх боловсролыг сайжруулах нөхцөл шаардлага хангагдахгүйд хүрээд байна. Түүнчлэн сургуулийн барилга, дотуур байрны нөхцөл муу байгаа нь боловсролын үйлчилгээний чанар хангалтгүй болоход хүргэж байна. Ялангуяа анги дүүргэлт үндэсний стандартаас давсан нөхцөлд санал болгож буй төслийн хүрээнд хийгдэх засварын ажлаар шинэ анги танхим нээн халаалтыг сайжруулж бага анги (1–4)-д заримдаа 3 ээлжээр хичээллэдэг явдлыг бууруулах хэрэгтэй байна. Дээр дурьдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн барилгын засвар, тохижилт сайжруулан шинэ анги нээж, хичээллэх ээлжийг хэвийн горимд оруулах, улмаар сурагчдын сурлагын амжилтын түвшинг ахиулах боломжийг хангахад төслийн үйл ажиллагаа чиглэх болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Сургуулийн өмнөх ба сургуулийн боловсролын үйлчилгээний чанар, анги танхимын хүрэлцээ дээшлэх<br>• Сурагчдын суралцах нөхцөл сайжрах, сурлагын амжилт дээшлэх<br>• Ээлжээр хичээллэдэг явдлыг бууруулж багш, ажиллагсдын өөрийгөө хөгжүүлэх болон хичээлийн бэлтгэлийг чанартай хангахад зарцуулахад зарцуулах цаг нэмэгдэх | • Сумын ЗДТГ<br>• Сургууль, цэцэрлэг<br>• Цэцэрлэг, сургуулийн ажиллагсал, хүмүүжигч хүүхдүүд, сурагчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Сургууль, цэцэрлэг | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 24.4**<br>• Засвар үйлчилгээ – 20.0<br>• Цалин, шимтгэл – 3.6<br>• Зураг төсөв – 0.8 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| 0.8 | 0.6 | 23.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажил төсөл дуусcанаас жилийн дараа эхлэнэ |
|---|---|

| № 6 | **Төсөл:** Зо2:Зт1:Хө1:Т2: “Чадварлаг багш-чанартай сургалт” хөтөлбөр | **Хөтөлбөр:** Зо2:Зт1:Хө1: Боловсролын ба мэргэшүүлэх үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тус сум төвдөө ахлах сургууль нэгтэйгээс гадна Хан-өндөр багийн төвд бага сургууль бий. Хөдөө орон нутагт мэргэжлийн туршлагатай багш дутагдалтайгаас сурагчдын сурлагын чанар байнга ахихгүй, тогтворжиж чадахгүй байна. Зарим хичээлийг мэргэжлийн бус хүнээр заалгах, түр курсээр бэлтгэгдсэн багш нарыг авч ажиллуулахад хүрдэг явдал түгээмэл байна. Түүнчлэн багш нарыг тогтвортой ажиллах нөхцлөөр хангах, амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх зэрэг олон талт арга хэмжээг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, үүний тулд багш нарын тогтвор суурьшлыг дээшлүүлэх, чадварлаг багш нарын сумандаа татаж ажиллуулах асуудлыг тусгасан дунд хугацааны хөтөлбөр боловсруулахад төслийг чиглүүлэн хэрэгжүүлнэ. “Зо2.Зт1.Хө1.Т1: Сургууль, цэцэрлэгийн барилгын засвар, тохижилт хийх” ба “ЗО2:ЗТ5:Хө1:Т1: Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцлийг сайжруулах” төслүүдийн үндсэн үзэл баримтлал, гол үйл ажиллагааг энэ төсөлд суулгаж баталгаажуулна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Багшлах боловсон хүчнээр сургуулийг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого боловсрогдоно<br>• Сургалтын чанарт дэвшил өөрчлөлт гарч сурлагын дундаж үнэлгээ ахина<br>• Багш нарын ажиллах, амьдрах нөхцлийг бодлогын үндсэн дээр шийдвэрлэдэг болно | • Сумын ЗДТГ<br>• Сургууль, багш нар<br>• Суралцагсад |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Бага ба дунд ургууль<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Хөтөлбөр боловсруулахад шаардагдах мэдээлэл, тоо материал бэлтгэсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 10.5**<br>• Тоног төхөөрөмж – 7.0<br>• Цалин, шимтгэл – 2.5<br>• Сургалт – 1.0 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчдад санал болгох** |
|---|---|---|
| 2.0 | 0.5 | 8.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажил төсөл дууссанаас хойш эхлэнэ. |
|---|---|

<table>
<tr><td>№ 7</td><td colspan="2">Төсөл: Зо1:Зт1:Хө2:Т2: Мэргэжлийн сургалт, бизнес мэдээллийн төв байгуулах</td><td colspan="3">Хөтөлбөр: Зо2.Зт1.Хө1: Боловсролын ба мэргэшүүлэх үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх</td></tr>
<tr><td colspan="6">Төслийн товч тодорхойлолт: Сумын нийт иргэд, хүүхэд залуучуудын мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх, ажилгүй хүмүүсийг сургалтанд хамруулан мэргэшүүлэх замаар мэргэжилтэй ба дадлага бүхий ажиллах хүчний хангамжийг сайжруулах боломж бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийг зах зээлийн ба технологийн мэдээллээр хангахад төслийг зорилго чиглэгдэнэ.</td></tr>
<tr><td colspan="3">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Мэргэшүүлэх ба дадлагажуулах сургалтыг сумандаа явуулах боломж бүрдэх<br>• Бизнес мэдээллийн төв тогтвортой ажиллана<br>• Сургалтын хөтөлбөр боловсруулах<br>• Мэдээллийн тоног хэрэгслээр хангагдана</td><td colspan="3">Зорилтот бүлэг:<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Ажил эрхлээгүй хүмүүс</td></tr>
<tr><td colspan="3">Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес мэдээллийн алба<br>• Соёлын төв</td><td colspan="3">Боломжит хувь нэмэр оруулагчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд<br>• Хандивлагчид</td></tr>
<tr><td colspan="3">Урьдчилсан боломж, нөхцлүүд:<br>• Бизнес мэдээллийн алба байгуулагдсан<br>• Мэргэшүүлсэн ажиллах хүчний ба сургалтын эрэлт хэрэгцээ тогтоогдсон байх</td><td colspan="3">Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</td></tr>
<tr><td colspan="3">Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:</td><td colspan="3">Бүгд – 2.4<br>• Тоног төхөөрөмж – 1.8<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 0.6</td></tr>
<tr><td colspan="2">Орон нутгийн хөрөнгө</td><td colspan="2">Төсвийн хөрөнгө</td><td colspan="2">Хандивлагчдад санал болгох</td></tr>
<tr><td colspan="2"></td><td colspan="2">0.6</td><td colspan="2">1.8</td></tr>
<tr><td colspan="6">Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас: Сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="3">Хэрэгжүүлэх хугацаа: 2007 оноос эхлэн хэрэгжүүлж эхлэх</td><td colspan="3">Төслийн үр дүнгийн тогтворжилт:<br>Төсөл дууссаны дараах эхний жилээс үр дүн тодорхой болж тогтворжино</td></tr>
</table>

| № 8 | **Төсөл:** Зо2:Зт2:Хө1:Т1: Хүн эмнэл-гийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээний нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тус сум хүн ам олонтойгоос гадна сүүлийн үед баруун аймгуудаас малчин өрхүүд хот айлаараа, саахалтаараа шилжин ирж суурьших хандлага нэмэгдэж байгаа нь хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлж байна. Төсөв санхүүжилт хүрэлцээгүй байсны учир хүн эмнэлгийн салбарын тоног төхөөрөмж шинэчлэгдээгүй явж ирсэн юм. Хүн амын өсөлтийг дагалдан өвчлөлт нэмэгдэх хандлагатай байгаагийн дотор эмнэлгийн тусламж зайлшгүй авах шаардлагатай эмзэг хэсэг болох хүүхдүүд, настайчуудын эрүүл мэндэд онцгой анхаарах шаардлагатай байна. Үүний тулд юуны өмнө сумын хүн эмнэлгийн салбарын нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх арга хэмжээг энэхүү төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Хүн эмнэлгийн салбарын тоног төхөөрөмж үе шаттай шинэчлэгдэнэ<br>• Хүн амын бүх давхаргад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ сайжирна<br>• Хүн эмнэлгийн ажиотны ажлын чанар, тогтвор суурьшил, мэргэжлийн чадавхи сайжирна | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Сумын иргэд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Шаардагдах судалгаа, дүгнэлт хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 13.0**<br>• Тоног төхөөрөмж – 10.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 1.0<br>• Сургалт – 1.5<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 0.5 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| | | 13.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 4 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажил төсөл дууссанаас жилийн дараа эхлэнэ |

| № 9 | **Төсөл:** Зо2:.Зт2:Хө1:Т2: Багийн хүний эмч нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт2:Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээний нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тус сум хүн амын дийлэнхи олонхи нь буюу 1200–аад малчин өрх хөдөөгийн 5 багт амьдарч байна. Баг бүрт хүний бага эмч ажилладаг боловч эмнэлгийн үзлэг, наад захын эмчилгээ хийх байргүй нэлээд олон жил болж байна. Ажлын тохитой байргүй гэх шалтгааны улмаас хүний эмч нар багтаа тогтвортой ажиладаггүй, сумын төвд суурьшихыг эрмэлзэх боллоо. Үүнээс болж хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх асуудал жил ирэх тутам улам хүндэрсээр байгаа билээ. Багийн төвд тохилог нөхцөл бүхий ажлын байртай болгож багийн эмч нарыг ажиллуулбал сумын хүн эмнэлгийн салбарын ачааллыг бууруулахаас гадна эмнэлгийн үйлчилгээг малчид, хөдөөгийн хүн амд чирэгдэл багатай хүргэх юм. Хамгийн гол нь эрүүл мэндийн үйлчилгээний шуурхай байдал дээшилж, эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд ихээхэн дөхөм болох юм. Энэ төслийг "Зо2.Зт2.Хө1.Т1. Хүн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг сайжруулах" төсөлтэй харилцан уялдаатай, гэхдээ тусад нь бие даасан байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Багийн хүний эмчийн ажиллах нөхцөл сайжирч тогтвор суурьшил нь дээшилнэ<br>• Хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн тусламж үзүүлэх шуурхай байдал сайжирна<br>• Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад малчид, хөдөөгийн хүн амаас гарах зардал багасна | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Багийн иргэд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Эмчийн ажлын байр болгон тохижуулах орон байр олгох асуудлыг шийдвэрлэсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 5.0**<br>• Засвар үйлчилгээ – 3.0<br>• Материалын зардал – 1.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 0.5<br>• Цалин, шимтгэл – 0.5 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| 1.0 | | 4.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 4 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах ажил төсөл дууссанаас жилийн дараа эхлэнэ |

| № 10 | **Төсөл:** Зо2:Зт3:Хө1:Т1: Спортын төв байгуулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт3:Хө1: Урлаг, соёл, спортыг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Эрүүл, идэвхтэй амьдрах ёсыг сумын иргэдийн дунд хэвшүүлэх, чөлөөт цагаа зөв өнгөрөөхөд нь бүх талын дэмжлэг үзүүлэх чиг үүргийн нэг нь спортын төв байгуулах явдал билээ. Гэтэл нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх тусгайлсан газар, байгууламж тус суманд байхгүй нөхцөлд хүүхэд залуучууд үнэт цагаа хий дэмий үрэх, заримдаа нийгмийн хэв журам зөрчих, настайчууд хөдөлгөөний дутагдалд орж эрүүл мэнд нь доройтоход хүрдэг нь хэн бүхний мэдэх болсон зүйл юм. Хүн амын дунд спорт тэмцээн зохиох шаардлага их ч сумандаа ганцаар тоологдох дунд сургуулийн биеийн тамирын танхмын тоноглол хуучирсан, зөвхөн сургалтын зориулалттай учраас насанд хүрэгчдийн шаардлагад нийцэхгүй болсон нь сумынхаа хэр хэмжээнд тохирсон спортын төв байгуулах асуудлыг хүчтэй тавьж, төсөл хэрэгжүүлэхээр хөөцөлдөх шаардлага сумын захиргааны өмнө тулгарч байна. Энэ төсөл хэрэгжсэнээр зөвхөн спортын төдийгүй эмчилгээний ба заслын хөдөлгөөнт дасгал сургууль хийж нөхөн сэргээх эмчилгээнд хүмүүсийг хамруулах боломж бүрдэнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Хүн амын дунд нийтийн биеийн тамирын ба сонирхогчдын спортоор хичээллэх боломж нэмэгдэнэ<br>• Сумын нэрийн өмнөөс аймаг, бүс, улсын чанартай тэмцээнд оролцох тамирчдаа суманд дасгал сургууль хийлгэж бэлтгэдэг болно<br>• Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломж ихээхэн нэмэгдэнэ<br>• Биеийн тамир, спортын зарчмаар нөхөн сэргээх эмчилгээ хийх боломж, энэ талын үйл ажиллагаа бэхжинэ | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Сумын иргэд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Хүн эмнэлгийн салбар<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>Шаардагдах судалгаа дүгнэлт хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 24.0**<br>• Барилга байшин – 18.0<br>• Тоног төхөөрөмж – 4.0<br>• Цалин, шимтгэл – 2.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| 5.0 | | 19.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үр дүнгийн тогтвортой хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа төсөл дууссанаас 3 жилийн дотор хичээллэгсдийн тоо, сумын тамирчдын амжилт зэргээр тодорхойлогдоно |

| № 11 | **Төсөл:** Зо2:Зт3:Хө1:Т2: Соёлын төвийн барилгын засвар, тохижилт | **Хөтөлбөр:** Зо2:Зт3:Хө1: Урлаг, соёл, спортыг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Анх 1970-аад онд Гэрэлт зам нэгдэл (хуучин нэрээр) хөрөнгөөр барьсан соёлын төвд одоо хүртэл их засвар хийгээгүйгээс дээвэр нь муудаж бороо, цасны шар ус гоожих болсноор урлагийн их заал болон бусад олон өрөө, тасалгааг байнга ашиглах боломжгүй болсныг сайжруулахын тулд сумын төсвөөс илүүчлэн хөнгөн засвар хийсэн боловч олигтой үр дүнд хүрэлгүй хэдэн жилийн нүүр үзлээ. Шал, өрөө тасалгааны цонх, хаалга ч нэлээд муудаад байна. Иймд соёлын төвд их засвар хийж, хөдөлмөрчдөд урлаг, соёлын үйлчилгээг түгээх, хүргэх ажлыг өргөжүүлэх боломж бүрдэнэ. Тус сумын соёлын төв нь сайн зураг төслөөр баригдсан багтаамжтай, хоёр давхар барилга юм. Энэ төвд их засвар хийснээр соёл урлагийн арга хэмжээний зориулалттай өрөө, танхмын ашиглалт сайжрах төдийгүй, мэдээллийн төв, сургалт явуулах танхим шинээр байгуулах зэргээр төрийн үйлчилгээг сайжруулахад чухал дэвшил гарна. Суманд байгаа иргэний нийгмийн байгууллага, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийг ажлын байраар хангах зэргээр сумын төр захиргааны байгууллагаас бизнесийн ба олон нийтийн үүсгэл санаачлага, хөгжлийн баримжаа бүхий арга хэмжээг дэмжих чиг үүргээ хэрэгжүүлэхэд томоохон түлхэц өгөх болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Урлаг соёлын үйлчилгээ чанаржин тогтмолжино<br>• Ажиллагсдын тав тухтай нөхцлийг сайжруулна<br>• Төр захиргаанаас иргэний ба хандивлагчдын төслийн төлөөллийн байгууллагад үзүүлэх дэмжлэг сайжирна | • Сумын ЗДТГ<br>• Сумын нийт иргэд<br>• Хүүхэд залуучууд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Соёлын төв | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Иргэд, байгууллага |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Төр, захиргааны байгууллага дэмжиж байгаа<br>• Сумын нийт иргэд хүсэн хүлээж байгаа | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Санхүүжилт дутагдах |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 25.6**<br>• Засвар үйлчилгээ – 20.0<br>• Тоног төхөөрөмж – 2.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 1.0<br>• Цалин, шимтгэл – 1.6 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчдад санал болгох |
|---|---|---|
| | | 25.6 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 4 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Соёлын төвийн ажиллагаа жигдэрч тогтворжино |
|---|---|

| № 12 | **Төсөл:** Зо2:ЗтЗ:ТЗ: Ардын урлагийн наадам зохион байгуулах | **Хөтөлбөр:** Зо2:ЗтЗ:Хө1: Урлаг, соёл, спортыг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын иргэдийн дундаас ардын авъяастныг илрүүлэх, тэдний урын сан, чадварыг сумын олон нийтэд нээн таниулах, уртын дуу, үндэсний бүжиг, ахуйн уламжлалт ёс заншлыг урлагийн жанраар сурталчлах, залуу үед өвлүүлэх арга хэмжээг нутагт дэлгэрүүлж хэвшүүлэхэд төслийн үйл ажиллагаа чиглэнэ. Энэ төслийг хэрэгжүүлэхэд "Зо2:ЗтЗ:Хө1:Т2: Соёлын төвийн барилгын засвар, тохижилт" төслийн хэрэгжилт чухал урьдал нөхцлийг бүрдүүлэх болно.

| Хүлээгдэж буй үр дүн: | Зорилтот бүлэг: |
|---|---|
| • Урлаг соёлын арга хэмжээний хүрээнд ардын авъяастныг илрүүлнэ<br>• Сумын соёл урлагийн арга хэмжээний хамрах хүрээ, далайц нэмэгдэнэ<br>• Хөгжмийн зэмсэг, материалын хангамж сайжирна | • Сумын ЗДТГ<br>• Соёлын төвийн хамт олон<br>• Сумын иргэд, авъяастнууд |
| **Төслийг хэрэгжүүлэгчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Соёлын төв | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Иргэд байгууллагууд (хөгжмийн зэмсэг хийдэг ба гарын ур бүхий иргэд)<br>• Хандивлагчид<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Наадам зохион байгуулах шийдвэр гаргах<br>• Сумын төсөвт хөрөнгө тусгасан байх<br>• Ардын авъяастны судалгаа хийсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн: сая төг:** | **Бүгд – 4.0**<br>• Цалин, шимтгэл – 5.0<br>• Сургалт – 0.5<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 0.5<br>• Судалгаа шинжилгээ – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | 1.0 | 2.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Соёлын төвийн эрхлэгч Батбаяр, утас:99229819

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос жил бүр | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:**<br>Байнга тогтмол хэрэгжинэ |
|---|---|

| № 13 | **Төсөл:** Зо2:Зт4:Хө1:Т1: Хөдөөгийн шуудангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | **Хөтөлбөр:** Зо2:Зт4:Хө1: Холбоо мэдээллийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сүүлийн жилүүдэд хөдөөгийн иргэдэд үзүүлэх шуудангийн үйлчилгээ бараг хаагдсан, алдаг оног байгаа нь төрөөс үзүүлэх нэг чухал үйлчилгээ болох шуудангийн үйлчилгээ, түүнтэй холбоо бүхий бусад үйл ажиллагаа ихээхэн хоцрогдоход хүрээд байна. Хөдөөгийн 5 баг, малчдад шуудангийн үйлчилгээний хүрээг малчид, ард иргэдийг бүх төрлийн мэдээллээр хангах, сонин хэвлэл түгээх, албан бичиг, захидлыг шуурхай дамжуулах нөхцөл бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааг чиглүүлнэ. Төслийн хүрээнд хөдөөгийн шуудангийн үйлчилгээний эрэлтийг судлах, шуудангийн үйлчилгээ цаг хугацаандаа хэрэглэгчдэд хүргэх материаллаг баазыг бэхжүүлэх, иргэд, бүлгүүдийг энэ арга хэмжээнд оролцуулах асуудлыг шийдвэрлэнэ. Сумын төр захиргаанаас бизнес эрхлэгчдэд мэдээлэл дамжуулах, авах чухал суваг бий болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Иргэдийн холбоо, мэдээллийн үйлчилгээг шуурхай болгоно
- Албан бичиг, захидал мэдээ солилцох шуурхай болгоно
- Хэвлэл захиалах, түгээх арга хэмжээ өргөжинө

**Зорилтот бүлэг:**
- Багийн ажилтнууд
- Багийн нийт ард иргэд, малчид
- Сумын холбооны ажилчид

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Сумын холбооны салбар

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Холбооны салбар
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Төр захиргааны байгууллагуудаас дэмжлэг үзүүлэх чиглэлээ тогтоосон байх
- Багууд, малчдад шаардлагатай мэдээлэл хүргэх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Тогтвортой санхүүжилт олдохгүй байх

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 9.0**
- Тоног төхөөрөмж – 4.0
- Тээвэр, холбоо, цахилгаан – 3.0
- Цалин, шимтгэл – 1.0
- Мэдээлэл, сурталчилгаа – 1.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 4.0 | 2.0 | 3.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Ихтамир сумын холбооны салбар, 0133226504

**Хэрэгжүүлэх хугацаа:** 3 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төслөөр бий болсон зохицуулалт, арга хэлбэрийг цаашид тогтвортой хэрэгжүүлнэ

<table>
<tr><td>№ 14</td><td>Төсөл: Зо2:Зт4:Хө1:Т2: Хөдөөгийн баг, малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах</td><td colspan="2">Хөтөлбөр: Зо2:Зт4:Хө1: Холбоо, мэдээллийг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Төслийн товч тодорхойлолт: Ихтамир сум 2007 оны дундуур Мобиком–ын үүрэн телефоны сүлжээнд холбогдсон нь хөдөөгийн хүн амын дунд орчин цагийн харилцаа холбооны үйлчилгээг сонирхох явдал нэмэгдлээ. Утсан холбоо болон үүрэн телефоны тарифийн зөрүүнээс болж гар утсаар ярихыг эрмэлзэх боллоо. Түүнчлэн шаардлагатай үед янз бүрийн шалтгаанаар яаралтай холбоо барих боломж багуудад байхгүй. Малчид, хөдөөгийнхөнд холбооны үйлчилгээ хүргэх цорын ганц арга зам нь хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамруулах явдал юм. Суманд ирсэн үүрэн телефоны яриаг хүлээн авах, дамжуулах төхөөрөмжийг багуудад байршуулах, түүнчлэн сансрын холбооны бусад төхөөрөмжийг суурилуулах замаар хөдөөгийн баг, малчдыг хөдөлгөөнт холбоонд хамруулах арга хэмжээ авах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Баг, малчид хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамрагдах боломж нэмэгдэнэ<br>• Холбооны үйлчилгээний хүртэмж, шуурхай байдал сайжирна</td><td colspan="2">Зорилтот бүлэг:<br>• Сумын ЗДТГ<br>• Сумын нийт иргэд</td></tr>
<tr><td colspan="2">Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Хөдөлгөөнт ба үүрэн телефоны үйлчилгээ эрхэлдэг компаниуд</td><td colspan="2">Боломжит хувь нэмэр оруулагчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Хөдөлгөөнт ба үүрэн телефоны үйлчилгээ эрхэлдэг компаниуд<br>• Хандивлагчид<br>• Засгийн газар</td></tr>
<tr><td colspan="2">Урьдчилсан боломж, нөхцлүүд: Шаардагдахгүй</td><td colspan="2">Эрсдэлтэй хүчин зүйлс:<br>• Санхүүжилт дутагдах</td></tr>
<tr><td colspan="2">Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:</td><td colspan="2">Бүгд – 25.6<br>• Материалын зардал – 10.0<br>• Тоног төхөөрөмж – 10.6<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 3.0</td></tr>
<tr><td>Орон нутгийн хөрөнгө</td><td colspan="2">Төсвийн хөрөнгө</td><td>Хандивлагчид</td></tr>
<tr><td></td><td colspan="2">10.0</td><td>15.6</td></tr>
<tr><td colspan="4">Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас: Сумын ЗДТГ</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 3 жил</td><td colspan="2">Төслийн үр дүнгийн тогтворжилт:<br>Хөдөөгийн баг, малчид холбооны сүлжээнд хамрагдсанаар тогтвортой байдал нь хангагдана</td></tr>
</table>

| № 15 | **Төсөл:** Зо2:Зт5:Хө1:Т1: Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах | **Хөтөлбөр:** Зо2:Зт5:Хө1: Орон сууцны хангамж сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвийнхээ барилгажилтыг өргөжүүлэх замаар төвлөрсөн тосгоны хэв шинж, тохижилтыг сайжруулах, тохилог орон сууцаар төрийн ба төрийн үйлчилгээний албан хаагчдыг хангаж, тэдний тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллах баталгааг бүрдүүлэх шаардлагыг үндэслэн энэхүү төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Төслийг хэрэгжүүлснээр, эсвэл хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлснээр "Зо2.Зт1. Хө1.Т2. "Чадварлаг багш–чанартай сургалт", "Зо4.Зт2.Хө1.Т2. Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах" төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.  "40000 орон сууц" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 32 айлын орон сууц барьж ашиглалтад оруулахад төслийг чиглүүлнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Төрийн албан хаагчдын орон сууны хангамж сайжирч, амьжиргааны түвшин дээшилнэ
- Тогтвортой үр бүтээлтэй ажиллах баталгаагаар хангагдах нөхцөл сайжирна

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Төрийн ба төрийн үйлчилгээний албан хаагчид

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Засгийн газар

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Газрын асуудлыг шийдвэрлэх
- Байр худалдан авах хөрөнгө (зээл)-ийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх
- Дэд бүтэцтэй холбох зураглал хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Санхүүжилт дутагдах

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 260.0**
- Барилга, байшин – 200.0
- Тээвэр, холбоо, цахилгаан – 10.0
- Цалин, шимтгэл – 46.0
- Зураг төсөв – 10.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | 260.0 | |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 3–4 жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа орон сууцыг байнга тогтвортой ашиглана.

| № 16 | **Төсөл:** Зо2:Зт5:Хө1:Т2: Орон сууцны зориулалтын ипотек зээлийн үйлчилгээ нэвтрүүлэх | **Хөтөлбөр:** Зо2:Зт5:Хө1: Орон сууцны хангамж сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын захиргаа, төрийн албан хаагчид орон сууц худалдаж авах, өөрийн хөрөнгөөр барих эх үүсвэрээр дутмаг байдаг учраас төрөөс зохих дэмжлэг үзүүлэх шаардлагыг үндэслэн орон сууцны зориулалтын ипотек зээлийн үйлчилгээ нэвтрүүлэх төслийг туршин хэрэгжүүлэх санал дэвшүүлж байна. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр орон сууцтай болохыг хүссэн албан хаагчид тусгайлсан нөхцлөөр зээл авч орон сууцныхаа нөхцлийг сайжруулах асуудлыг хамгийн богино хугацаанд ашигтай хувилбараар шийдвэрлэх боломж олгоно. Төслийг "Зо2:Зт1:Хө1:Т2: Чадварлаг багш-чанартай сургалт", "Зо4:Зт2:Хө1:Т2: Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах", "Зо2:Зт5:Хө1:Т1: Төрийн албан хаагчдын орон сууцаар хангах" гэсэн 3 чухал төслийг хэрэгжүүлэхэд тусгайлсан дэмжлэг болгох үүднээс хэрэгжүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Төрийн албан хаагчдын орон сууны нөхцөл, хангамжийг сайжруулах хөрөнгийн эх үүсвэртэй болно<br>• Албан хаагчдын амьжиргааны нөхцөл дээшилнэ<br>• Тогтвортой үр бүтээлтэй ажиллах баталгаагаар хангагдана | • Сумын ЗДТГ<br>• Төрийн ба төрийн үйлчилгээний албан хаагчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Банкны байгууллагууд | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар<br>• Банкны байгууллагууд<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Зээл олгох банк сонгох, тохиролцоо хийх асуудлаар санал боловсруулах | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Зээлийн эрэлт нийлүүлэлтээс давах |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 2.8**<br>• Сургалт – 1.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.2<br>• Зураг төсөв – 0.6 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчид** |
|---|---|---|
| 0.3 | | 2.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3-4 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжүүлэх явцад үр дүнг тогтвортой ашиглана. |
|---|---|

| №.17 | **Төсөл:** Зо2:Зт6:Хө1:Т1: Нийгмийн халамж үйлчилгээний орон нутагт зохицсон менежмент нэвтрүүлэх | **Хөтөлбөр:** Зо2:Зт6:Хө1: Сэтгэлд хүрсэн нийгмийн халамж |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Ихтамир сум нь нийт 5968 хүн амтайгаас 86.8% нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай. Гэвч төрөөс үзүүлж буй уг үйлчилгээ нь цаг тухайдаа эзэндээ хүрч чадахгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажилтнуудын ажлын хариуцлагатай холбоотой чирэгдэл ихтэй байгаа учир орон нутагт зохицсон менежментийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Үйлчилгээний менежментийг сайжруулах, ажлын тусгай байртай болгох, тоног төхөөрөмжийг шинэчлэх арга хэмжээг төслийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Нийгмийн халамж үйлчилгээний орон нутагт зохицсон менежмент нэвтрүүлнэ<br>• Иргэдийн орлого нэмэгдэнэ<br>• Сумын эдийн засгийн чадамж дээшилнэ<br>• Эмзэг бүлгийг дэмжих нөхцөл бүрдэнэ | **Зорилтот бүлэг:**<br>• Хүн амын эмзэг бүлэг<br>• Нийгмийн халамж хүртэгч иргэд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Халамжийн үйлчилгээнд хамрагдагсад | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Халамжийн үйлчилгээг сайжруулах шаардлагын судалгаа хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 14.0**<br>• Барилга, байшин – 2.0<br>• Тоног төхөөрөмж – 7.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 1.5<br>• Судалгаа, шинжилгээ 0.5 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.0 | 0.5 | 11.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Их тамир сумын үндсэн баг, утас: 99811108, 99806600

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Шинэчилсэн менежмент төслийн дараах үед тогтвортой үргэлжилнэ. |

| № 18 | **Төсөл:** Зо2:Зт6:Хө1:Т2: Эмзэг бүлгийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо2:Зт6:Хө1: Сэтгэлд хүрсэн нийгмийн халамж |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Албан ёсны шалгуураар тус сумын хүн хүн амын 30-аад хувийг ядуу ба нэн ядуучууд эзлэдэг бөгөөд өрхөөр тооцвол 400 гаруй өрх нийгмийн эмзэг бүлэг хэмээх ангилалд багтаж байна. Ядуурлын гол шалтгаан нь ажилгүй, бизнесийн чанартай юм уу орлого олох ажил эрхлэх хөрөнгийн эх үүсвэргүй, мэдлэг чадвар сул, нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээ зориуд зохион байгуулж хамруулахгүй бол өөрсдөө санаачлага гаргах, хөдөлгөөн өрнүүлэх чадамжгүй зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм. Шинээр боловсруулан хэрэгжүүлэх ЭЗХ-ийн стратегийн үндсэн зорилгын нэг болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлогын хүрээнд эмзэг бүлэгт шууд хандсан цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эмзэг бүлгийнхэн өөрсдөө бие даасан үйл ажиллагаа санаачлан эхэлж ядуурлаас гарах, амьжиргааныхаа түвшинг дээшлүүлэх талаар тодорхой ахиц өөрчлөлт гаргана гэж хүлээх, харзнах нь явуургүй хандлага гэдэг нь нэгэнт тодорхой болоод байна. Иймд сумын хэмжээнд баримтлах бодлого, цэгцтэй үйл ажиллагааг тусгасан, оролцооны зарчимд баттай тулгуурласан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулах зорилтыг орон нутгийн түвшинд шийдвэрлэхэд ихээхэн дөхөм болно гэж үзэж байна. Дурьдсан чиглэлээр хөтөлбөр боловсруулах туршлага тус суманд байхгүй учир ЭЗХ-ийн стратегийн төсөл болгон хэрэгжүүлэх зорилго тавьж ажиллах нь зүйтэй юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсрогдоно
- Сумын иргэдийн амьжиргааны ерөнхий түвшин дээшилнэ

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Эмзэг бүлэгт багтах хүмүүс, өрх

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Эмзэг бүлэгтэй холбогдох судалгаа, үнэлгээ хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Оролцогчдын нийгмийн идэвх, сэтгэхүйн хоцрогдлыг даван туулах

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 4.0**
- Цалин, шимтгэл – 1.0
- Сургалт – 2.0
- Мэдээлэл, сурталчилгаа – 0.5
- Судалгаа, шинжилгээ – 0.5

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.2 | | 2.8 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 4 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа тодорхой үйл ажиллагааны хүрээнд үр дүнг тогтвортой ашиглах асуудлыг шийдвэрлэнэ

| № 19 | Төсөл ЗоЗ:Зт1:Хө1:Т1: Мал аж ахуй–газар тариалан хосолсон фермийн аж ахуй хөгжүүлэх загвар боловсруулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Тус сумын байгалийн нөөц, цаг уурын тааламжтай нөхцөл, газар тариаланд тохиромжтой хөрс, аймгийн төвийн зах зээлд ойр, төв замын дагуу дагуу байрладаг зэрэг онцлогууд нь мал аж ахуйг бэлчээрээр эрхлэхээс гадна фермерийн аж ахуйн хэлбэрээр хөгжүүлэхэд тохиромжтой юм. Ялангуяа малын тэжээлийн ургамал тариалах замаар газар тариаланг мал аж ахуйтай хорших боломж байгаа хэдий ч одоогоор үлгэр жишээ болохуйц хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй явж ирсэн нь газар тариаланг мал аж ахуйтай хоршсон фермерийн аж ахуйн загвар боловсруулах шаардлагыг бий болгож байгаа юм. Тодорхой шаардлагыг хангасан 10 хүртэл малчин өрхийг сонгон авч төсөл No1, No2, No20, No21–тэй нягт уялдаатай боловч бие даасан байдлаар хэрэгжүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:** |
|---|---|
| • Газар тариаланг мал аж ахуйтай хоршин эрхлэх аж ахуйн тохиромжтой загвар боловсруулна<br>• Фермерийн иймы аж ахуйг цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэх арга замыг тодорхойлно | • Сумын ЗДТГ<br>• Малчин 10 өрх |
| **Төслийн хамтран хэрэгжүүлэгчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Малчид, мэргэжилтнүүд<br>• Өндөр уулын бүсийн станц | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Малчид ба фермер өрхүүд<br>• Хандивлагчид |
| **Зэхэц ба боломж, нөхцлүүд:**<br>• Тариалан, ялангуяа малын тэжээл өрхийн хэмжээнд тариалахад газар олгох асуудлыг шийдвэрлэсэн байх<br>• Төсөлд хамрагдах өрхүүдийн урьдчилсан сонголт хийгдсэн, зохих мэдээлэлтэй болсон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Цаг агаарын тааламжгүй нөхцөл |
| **Шаардагдах санхүүжилт: сая төг:** | **Бүгд – 20.0**<br>• Материалын зардал – 4.0<br>• Тоног төхөөрөмж – 8.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 2.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 2.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.0<br>• Судалгаа, шинжилгээ – 1.0 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчид** |
|---|---|---|
| | | 20.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Өндөр уулын бүсийн салбарын захирал В.Дагвийхорол, Утас: 99780561

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 5 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Фермер 10 өрхийн нөхцөлд бүрэн хэрэгжинэ. |
|---|---|

| № 20 | **Төсөл:** ЗоЗ:Зт1:Хө1:Т2: "Туслах аж ахуй – өрхөд" хөдөлгөөн өрнүүлэх | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Өөрийн харьцангуй давуу талыг ашиглах замаар тус сумын иргэд, байгууллагууд, айл өрхүүдээс нэлээд үр дүнтэй хэрэгжүүлж болох нэг чухал дэд салбар бол гахай, шувууны аж ахуйг туслах аж ахуйн хэлбэрээр эрхлэх явдал мөн. Төллөх 5–аас доошгүй мэгжтэй гахайн аж ахуй, 50–аас доошгүй өндөглөгчтэй шувууны жижиг аж ахуйтай болж, сумаа болон аймгийн төвийг хангах, цаашилбал томоохон зах зээлд гарах боломж бүрдүүлэх зорилго бүхий төслийг үе шаттай хэрэгжүүлж энэ асуудлыг шийдвэрлэх эхлэлийг тавих боломжтой гэж үзэж байна. Сонирхсон байгууллага, өрхүүдийг түшиглэн гахай, тахианы жижиг аж ахуйг амжилттай эхлэн хөгжүүлснээр энэ үйл ажиллагааг цаашид дэлгэрүүлэхэд үржлийн ба хэрэгцээний сүргээр хангах боломж бүрдэх болно.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Аж ахуйн шинэ хэлбэр хөгжинэ<br>• Зах зээлд сумаас шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлнэ<br>• Малчин өрхийн орлого нэмэгдэж, амьжиргааны түвшин дээшилнэ | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:**<br>• Малчид<br>• Малчдын бүлэг |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Сонирхогч байгууллага, өрхүүд | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗТГ<br>• Хандивлагчид<br>• Хөрөнгө оруулагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Гахай, шувуу үржүүлж байсан туршлагатай юм уу сонирхож буй байгууллага, өрхүүдийг тогтоосон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Байгаль, цаг уурын нөлөө |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 14.0**<br>• Төслийн үйл ажиллагаа, материалын зардал – 12.0<br>• Цалин, шимтгэл – 1.0<br>• Сургалт – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.0 | | 12.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төслийн үр дүнгийн тогтворжилтыг шинээр бий болсон аж ахуйнуудын тусламжтайгаар хангах |

| № 21 | **Төсөл:** ЗоЗ:Зт1:Хө1:Т2: Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Байгаль–цаг уурын тааламжгүй өөрчлөлтөөс сүүлийн жилүүдэд бэлчээрийн ургац буурч, хадлан өвс шаардлагатай хэмжээгээр бэлтгэхэд ихээхэн хүндрэл учрах боллоо. Иймд байгалийн хадлан сайжруулах, тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалах, гар тэжээл бэлтгэх арга хэмжээг өргөжүүлж малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Санал болгож буй төслийн хүрээнд боловсруулах сумын хөтөлбөр нь бусад төслүүд (No1, No2, No20)–ийг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлж өгөхөөс гадна харилцан уялдааг хангах үндэслэл болж өгнө.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:** |
|---|---|
| • Малын тэжээлийн хангамж сайжруулах сумын хөтөлбөр боловсруулна<br>• Хадлангийн талбайг сайжруулах болон бусад төрлийн малын тэжээл бэлтгэнэ<br>• Тэжээл бэлтгэлийн нэмэгдүүлэх замаар МАА–г байгалийн эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авна | • Орон нутгийн нийт малчид<br>• Малчдын бүлэг<br>• Газар тариалан эрхлэгчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Сумын ЗДТГ<br>• Малчид, иргэд<br>• Эрдэм шинжилгээний байгууллага | • Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Сумын төр захиргааны төсөлд дэмжлэг<br>• Тэжээлийн ургамал тариалан техник газар бэлэн байгаа | • Гандалт, хэт халалт, хуурайшилтаас шалтгаалан ургац алдаж болзошгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн сая төг:** | **Бүгд – 10.0**<br>• Тоног төхөөрөмж – 3.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 4.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 1.0 |

| **Орон нутгийн хөрөнгө** | **Төсвийн хөрөнгө** | **Хандивлагчид** |
|---|---|---|
| 3.0 | | 7.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссаны дараах эхний жилээс үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 22 | **Төсөл:** ЗоЗ:Зт1:Хө1:Т4: Хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах сумын хөтөлбөр | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт1:Хө1: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын мал сүргийн үүлдэрлэг байдал, ашиг шимт чанарыг дээшлүүлэхэд сумын захиргааны зүгээс хариуцах үйл ажиллагааны чиглэл, үзүүлэх дэмжлэг, бусад арга хэмжээг нэгтгэн төлөвлөх арга замыг тодорхой-лох зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлнэ. Сүргийн үржил-ашиг шимт чанарыг дээшлүүлэх зорилгоор сумандаа ашиглах үржлийн шилмэл сүрэг бойжуулах төрөлжсөн аж ахуй бий болгох, түүнчлэн мал аж ахуйг эрчимтэй аргаар эрхлэхэд төслийн үр дүн зохих түлхэц өгнө. Эцэг мал солилцохоос авахуулаад шилмэл ба төрөлжсөн үүлдрийн хээлтүүлэгч авч ашиглах, сумандаа үржлийн мал бойжуулах чиглэлээр төрөлжсөн фермерийн жижиг аж ахуй бий болгох зэрэг олон талт асуудлыг хөтөлбөрт тусгана.

| Хүлээгдэж буй үр дүн: | Зорилтот бүлэг: |
|---|---|
| • Үржилд зөвхөн үржлийн сайн чанарын шилмэл хээлтүүлэгч ашигладаг болно<br>• Үржлийн шаардлага хангасан хээлтүүлэгч бойжуулдаг өрх, фермерийн малчдын бүлэг бий болж хөгжинө | • Сумын ЗДТГ<br>• Малчид, ммал бүхий бүх иргэд |
| **Төслийн хамтран хэрэгжүүлэгчид:**<br>• Малчид<br>• Сумын ЗДТГ<br>• МАА-н мэргэжилтнүүд | **Төсөлд хувь нэмэр оруулах боломжит оролцогчид:**<br>• Малчид<br>• Хандивлагчид<br>• Мал эмнэлэг-үржлийн алба<br>• Сумын ЗДТГ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Мал сайжруулах талаар сумаас баримтлах бодлого тодорхой байх<br>• Үржлийн цөм бүрдүүлэх сүрэгтэй байх<br>• МАА-н мэргэжилтэнтэй байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Ган, зудын гамшиг тохиолдох<br>• Халдварт өвчин гарах |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 25.0**<br>• Материалын зардал – 10.0<br>• Тоног төхөөрөмж – 5.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 6.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | | 25.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Шинээр байгуулагдсан үржлийн мал бойжуулах, борлуулах малчид, бүлгүүдийн хүчээр үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 23 | **Төсөл:** ЗоЗ:Зт2:Хө1:Т1: МАА–н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, маркетингийн судалгаа хийх | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт2:Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сүүлийн 5 жилийн байдлаар тус сумын ДНБ–д мал аж ахуйн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 90 орчимд хувьтай, харьцангуй тогтвортой байгаа юм. Энэ салбарын бүтээгдэхүүн, түүхий эд, бусад нөөц боломжийг зохистой ашиглах, мал аж ахуйн чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх асуудал тулгамдаж байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулах нь бүтээгдэхүүнээ тогтвортой үнээр нийлүүлэн орлогоо нэмэгдүүлэх боломжийг малчдад олгохын зэрэгцээ хөдөөгийн ядуурлыг бууруулахад чухал арга хэмжээ болох юм. Ийм учраас мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах ЖДҮ хөгжүүлэх өөрийн бодлого, чиглэлээ нарийн сайн тодорхойлж сумаас гаргаж буй болон шинээр зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүнээ боловсруулах асуудлаар маркетингийн судалгаа явуулах зэрэг арга хэмжээг энэ төслийн хүрээнд цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• МАА–н бүтээгдэхүүний маркетингийн судалгаа хийгдэнэ<br>• МАА–н бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлийг зах зээлтэй уялдуулан тогтооно<br>• Сумын ЖДҮ–ийн технологийн түвшин, үйл ажиллагааны хүрээ өргөжинө | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардлагагүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 5.0**<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 1.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 1.0<br>• Судалгаа, шинжилгээ – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | | 5.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 4 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг тогтвортой ашиглана |

| № 24 | **Төсөл:** 3о3:3т2:Хө1:Т3: Шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа | **Хөтөлбөр:** 3о3:3т2:Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** "Нэг суурин–нэг бүтээгдэхүүн" уриалгыг Ихтамир суманд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, байгаа нөөц боломжоо ашиглах, шинэ технологи нэвтрүүлэх замаар суманд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад төслийн зорилго чиглэнэ. Түүнчлэн бренд бүтээгдэхүүнийг тодруулах, сурталчлах, сумын үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдэд эзэмшүүлэх, хэрэгжүүлэх явдал төслийн гол зорилгын нэг байх болно. Сумынхаа үйлдвэрлэгчдийн дунд харилцан туршлага солилцох, хамтран ажиллах, хорших, жижиг хөрөнгө оруулалтыг татах, зах зээлд хийх борлуулалтаа нэмэгдүүлэхэд нь идэвхжүүлэх гол арга хэмжээ болгон хэрэгжүүлэх, малчдын оролцоог дээшлүүлэхэд сумын шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа чухал ач холбогдолтой юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Бүтээгдэхүүний борлогдох чадвар, чанар, цэвэр аюулгүй байдал дээшилнэ
- Үйлдвэрлэгчдийн дунд бренд ба нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хоршилт, хамтын ажиллагаа сайжирна
- Тэргүүн туршлага, арга ажиллагааг нийтэд сурталчлах, дэлгэрүүлэх боломж нэмэгдэнэ
- Бизнесийн сурталчилгаа сайжирна

**Зорилтот бүлэг:**
- Орон нутгийн иргэд
- Бизнес эрхэлэгчид
- Малчид

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Орон нутгийн засаг захиргаа
- Бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчид,
- АА–н нэгж, байгууллага

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл тавигдсан байх
- Үзэсгэлэн худалдаа явуулах шийдвэр гаргасан, мэдээлсэн, бэлтгэл ажил хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 5.5**
- Засвар үйлчилгээ – 1.0
- Материалын зардал – 2.0
- Тээвэр, холбоо, цахилгаан – 2.5
- Сургалт – 0.5

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | 2.0 | 3.5] |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос жил бүр

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Жил бүр тогтвортой үргэлжилнэ

| № 25 | **Төсөл:** Зо3.3т2.Хө1.Т3: Ашигт малтмал, барилгын материалын үйлдвэрлэлийн нөөцийн зураглал хийх | **Хөтөлбөр:** Зо3.3т2.Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумынхаа нутаг дэвсгэрт байгаа нүүрс, шохойн чулуу, зэрэг ашигт малтмал, барилгын материалын нөөцийн зураглал хийх нь дээрхи нөөцийг зөв стратегитэй ашиглах ирээдүйтэй арга замыг тодорхойлох эхлэлийг тавьж өгнө.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Ашигт малтмал, барилгын материалын үйлдвэрлэлийн нөөцийн зураглалтай болно<br>• Ашигт малтмал, барилгын материал боловсруулах ЖДҮ хөгжүүлэх чиглэл, хүчин чадал, зах зээлийн судалгаатай болно<br>• Ашигт малтмал, барилгын материал ашиглах, боловсруулах асуудлаар шийдвэр гаргахад сумаас оролцох оролцоо дээшилнэ<br>• Ажын байр нэмэгдэнэ | • Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардлагагүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 7.0**<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 1.0<br>• Цалин, шимтгэл – 2.0<br>• Сургалт – 1.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.0<br>• Зураг төсөв – 2.0<br>• Судалгаа, шинжилгээ – 2.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.8 | | 6.2 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 26 | **Төсөл:** ЗоЗ:Зт2:Хө1:Т3: "Хөгжлийн түншлэл" хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт2:Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын эдийн засгийг хөгжүүлэх стратегийн хүрээнд баримтлах олон асуудлын гол шижим нь төр–хувийн хэвшил, орон нутгийн бизнес эрхлэгчдийн хооронд тогтвортой хамтын ажиллагаа, хоршилтыг босоо ба хэвтээ чиглэлд бий болгох асуудлыг судлах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулахад төслийн үйл ажиллагааг чиглүүлнэ. Энэхүү түншлэлийг төр–хувийн хэвшил гэсэн босоо чиглэлтэйгээс гадна бизнес эрхлэгчдийн хооронд хэвтээ чиглэлд хөгжүүлэх арга замыг хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дунд хугацааны баримжаатайгаар боловсруулна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Босоо ба хэвтээ чиглэл бүхий түншлэл бий болгох, хөгжүүлэх хөтөлбөр боловсрогдоно<br>• Түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл тогтоогдоно | • Сумын төр захиргааны байгууллага<br>• Бизнес эрхлэгчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын төр захиргааны байгууллага<br>• Бизнес эрхлэгчид | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардлагагүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 5.4**<br>• Цалин, шимтгэл – 1.0<br>• Сургалт – 2.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.4<br>• Судалгаа, шинжилгээ – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.3 | | 4.1 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 4 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 27 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т1: Суманд аялал жуулчлал хөгжүүлэх бизнес төлөвлөгөө боловсруулах | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Аялал жуулчлалыг өргөжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Ихтамир сум нь Архангайн баруун хойт, Баянхонгорын хойт, Завханы зүүн ба хойт сумд Увс, Баян–Өлгий аймаг руу жуулчлал, аялал, амралт, зугаалгын журмаар явах төв зам дайран өнгөрдөг, нутаг дээрээ алдарт Тайхар чулууны орчимд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг жуулчны 3 баазтай. Түүнээс гадна үзэсгэлэнт байгаль, түүх–соёлын дурсгалт объектууд, нутгийн онцлогийг хадгалсан ахуйн хэвшинж, ёс заншил зэрэг нь тус суманд аялал жуулчлалыг татах, энэ төрлийн бизнес, үйл ажиллагааг сумандаа өгөөжтэй хэлбэрээр түншлэл, хоршилтын маягаар хослон хөгжүүлэх өргөн боломж байгаа юм. Монгол оронд аялал жуулчлал шинэ тутам хөгжиж буй салбар бөгөөд орон нутагт одоо хэр тэлж хөгжиж хараахан чадаагүй байна. Иймд сумандаа аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг хүчтэй тавьж хөөцөлдөж чадвал амжилтад хүрэх нэгэн өвөрмөц зурвас үе, боломж бидэнд олдож байгаа юм. Суманд аялал жуулчлал хөгжүүлэхэд анхнаасаа зөв хандлагаар явахын тулд бизнес төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Суманд аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг зохицуулан хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөтэй болно
- Сумын иргэд, байгууллага, бизнес эрхлэгчид аялал жуулчлалын бизнес бие даах юм уу түншлэлийн журмаар хоршин эрхлэх боломж нэмэгдэнэ
- Хүн амын орлого нэмэгдэх, үйл ажиллагааны хүрээ өргөжинө

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Аялал жуулчлалын үндэсний сүлжээтэй холбогдох боломж, сумандаа хэрэгжүүлэх арга хэмжээний талаар урьдчилсан судалгаа хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 2.0**
- Сургалт – 1.0
- Судалгаа, шинжилгээ – 1.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.2 | | 1.8 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 8 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа аялал жуулчлалын чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж 2–3 жилд үр дүнг тогтвортой ашиглана

| № 28 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө2:Т2: Тайхар чулууны хуучин бичээсийг сэргээн засварлах | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө2: Аялал жуулчлалыг өргөжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Ихтамир сумын нутагт байдаг "Тайхар" хэмээх 16 м өндөр чулуун цохио нь тухайн орчимдоо ганцхан содон объект юм. Тайхар чулуу нь манай эриний өмнөх Хүннү гүрний үеэс 20-р зууны эх хүртэлх үеийг хамрах 10-аад төрлийн 90 гаруй бичээс, хадны сүг зураг бүхий түүх-соёлын чухал эх сурвалж юм. Аялал жуулчлалыг суманд татахад цаашдаа их ач холбогдолтой байгалийн энэхүү өвөрмөц тогтцыг зохистой хамгаалах асуудлыг "шинэ" үеийнхэн орхигдуулснаас хүний нэр, хаяг, дүрс, элдэв зүйл тосон будгаар бичиж, нийт талбайнх нь 30 гаруй хувийг эрээн цоохор болгожээ. Нэн харамсалтай нь хуучин бичээс, сүг зургийг дээрээс нь шууд дарж тосон будгаар эрээчсэн учраас үүнийг заавал арилгах шаардлагатай болоод байна. Иймээс түүхийн дурсгалт бичээс, сүг зургийг анхных нь байдлаар тодруулах, сэргээх, "Тайхар" чулууны орчмыг хашиж хамгаалах замаар орон нутгийн хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэхэд энэ төсөл чухал хувь нэмэр болох юм.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Түүхийн дурсгалыг хэвээр нь хадгална<br>• Судлаачид, жуулчдыг олноор татна<br>• Сумын төсвийн орлого нэмэгдэнэ | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:**<br>• Сумын ЗДТГ<br>• Аялал жуулчлал эрхлэгчид<br>• Судлаачид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Орон нутгийн засаг захиргаа<br>• Түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах газар | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Иргэд, жуулчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Чулууны бичээсийг тайлах, унших, бүрэн сэргээгдсэн эсэхийг магадлах судлаач олох<br>• Ажлын зураг төсөв зохиогдсон байх<br>• Орон нутгийн хамгаалалтад авах үндэслэл боловсрогдсон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 1.8**<br>• Засвар үйлчилгээ– 1.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 0.5<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 0.3 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.6 | | 1.2 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** Санхүүжигдсэнээс хойш 3 сарын дотор | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Орон нутгийн хамгаалалтад авч үр дүнг тогтворжуулна |

| № 29 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т1: "Гэрээс гэрт жуулчлал" ажиллагаанд малчдын оролцоог өргөжүүлэх | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Аялал жуулчлалыг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хувиараа болон албан ёсны зохион байгуулалттайгаар хүрэлцэн ирэгч гадаад, дотоодын амрагчид, жуулчид, аялагчдыг сумандаа татах, ялангуяа малчдыг энэ арга хэмжээнд зохион байгуулалттай оролцуулах нь манай суманд аялал жуулчлалыг өргөжүүлэх, мал аж ахуйн бус үйл ажиллагаанаас малчдын олох орлогыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой асуудал мөн. Сумынхаа малчин өрх, хот айлуудаас тусгай шалгуураар сонголт хийж аялал жуулчлалын анхан шатны менежмент ба аялагч, жуулчин хүлээн авч үйлчлэх зохих бэлтгэл хангуулах арга барил эзэмшүүлэх, дадлагажуулах сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах зэрэг арга хэмжээг бие даасан төсөл хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. "Гэрээс гэрт жуулчлал" ажиллагаанд малчдын оролцоог өргөжүүлэх нь тэд өөрсдийн нөөц бололцоогоо хоршин ашиглах, үйл ажиллагаагаа сайжруулахын тулд хамтран ажиллахад чухал түлхэц өгнө.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Малчдыг сумын аялал жуулчлалын арга хэмжээнд татан оролцуулах боломж нэмэгдэх
- Суманд ирэх гадаад, дотоодын жуулчид, аялагч, амрагчдын тоо нэмэгдэнэ
- Аялал жуулчлалын дагалдах үйлчилгээг малчдын түвшинд хөгжүүлнэ

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Малчид, хот айл

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Малчид, хот айл
- Жуулчлалын бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Нутгийн гаралтай бизнесүүд
- Аялал жуулчлалын байгууллагууд
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Төсөлд хамрагдах өрх, хот айлын судалгаа хийгдсэн байх
- Сургалт, үзүүлэх сургууль явуулах жуулчлалын байгууллагатай холбоо тогтоосон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 35.0**
- Тоног төхөөрөмж – 20.0
- Тээвэр, холбоо, цахилгаан – 7.0
- Цалин, шимтгэл – 3.0
- Сургалт – 2.0
- Мэдээлэл, сурталчилгаа – 3.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 25.0 | | 10.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2007 онд бэлтгэл хангах, 2008 оноос эхлэх

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Үйл ажиллагаа явуулах малчин өрх, хот айлын түвшинд үр дүнг тогтворжуулна

| № 30 | **Төсөл:** ЗоЗ:ЗтЗ:Хө1:Т4: Жуулчдад зориулсан үйлчилгээний бүс тогтоох | **Хөтөлбөр:** ЗоЗ:ЗтЗ:Хө1: Аялал жуулчлалыг өргөжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Жуулчид, аялагчдад  зориулсан үйлчилгээг бүсчлэх,  байршлыг нэр зааж тогтоох чиглэлээр төсөл хэрэгжүүлэх нь зүйтэй гэж оролцогчид үзсэн болно. Байгаль–түүхийн дурсгалт ба үзэсгэлэнт газрыг түшиглүүлэхээс гадна дэд бүтэц, ялангуяа жуулчид, аялагчдын байнгын ба түр хэрэгцээнд тулгуурласан боловсон, эрүүл ахуйн шаардлагыг хангасан үйлчилгээний цэг, салбар бий болгох асуудлыг бие даасан бодлогын хэмжээнд зангидах байдлаар шийдвэрлэх боломжийг тогтооход төслийн үйл ажиллагааг чиглүүлнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Суманд ирж буй болон дайран өнгөрч байгаа аялагчид, жуулчдыг боловсон үйлчилгээгээр хангахад зориулсан үйлчилгээний цэг, салбар бий болгох чиглэлийг тогтооно<br>• Сумын иргэд, байгууллага, бизнес эрхлэгчдээс аялал жуулчлалын бизнесийн хүрээнд үзүүлэх үйлчилгээний төрөл, чанар, аюулгүй байдал дээшилнэ<br>• Өөрийн сумын нутаг дээр аялагчид, жуулчдыг татах, барих боломж нэмэгдэх, орлого олох боломж өргөжинө | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Иргэд |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Жуулчны байгууллага<br>• Бизнес эрхлэгчид | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Жуулчны байгууллага |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Аялал жуулчлалын үндэсний сүлжээтэй холбогдох боломж, сумандаа хэрэгжүүлэх арга хэмжээний талаар урьдчилсан судалгаа хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 2.7**<br>• Сургалт – 0.7<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 1.0<br>• Судалгаа, шинжилгээ – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | | 1.7 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 8 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа аялал жуулчлалын боловсон үйлчилгээний чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг тогтвортой ашиглана |

| № 31 | **Төсөл:** ЗоЗ:Зт4:Хө1:Т1: Хүнсний төрөлжсөн зах ажиллуулах боломжоор хангах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт4:Хө1: Худалдаа, ахуйн үйлчилгээг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Мах, сүү зэрэг амархан мууддаг өргөн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүнийг их төлөв жижиг лангуугаар энд тэнд борлуулж байгаа нь ариун цэвэр, аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаагийн дээр хяналт тавихад ихээхэн хүндрэл учрүүлж байна. Иймд орон нутгийн өмчид байгаа ашиглалтгүй барилгыг засаж тохижуулан хүнсний төрөлжсөн зах ажиллуулах боломж бүрдүүлснээр хүнсний аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, ялангуяа малчид, иргэдээс өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдаалах лангуу түрээсэлж ажиллах боломж сайжирна.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хүнсний аюулгүй байдлын хяналт, борлуулалт сайжрах<br>• Хүнсний захын нөхцөл сайжрах нэмэгдүүлэх<br>• Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх | • Сумын ЗДТГ<br>• Иргэд, малчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Хөрөнгө оруулагчид | **Боломжит хувь нэмэр оруулгчид:**<br>• Хандивлагчид<br>• Иргэд, малчид<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Хүнсний захын зориулалтаар засварлаж, тохижуулах барилгаа товлосон байх<br>• Барилгын засварын зураг төсөв хийгдсэн байх<br>• Шинэ захад борлуулах бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг баримжаалан тодорхойлсон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Санхүүгийн  эх үүсвэр дутагдах |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 35.0**<br>• Засвар тохижуулалт – 16.0<br>• Тоног төхөөрөмж – 9.0<br>• Цалин шимтгэл – 4.0<br>• Мэдээлэл, сурталчилгаа – 2.0<br>• Сургалт – 3.0<br>• Судалгаа – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | 5.0 | 25.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Нэг жил үйл ажиллагаа явуулсны дараа үр дүн тогтворжино |
|---|---|

| № 32 | **Төсөл:** ЗоЗ:Зт4:Хө1:Т2: Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах байраар хангах | **Хөтөлбөр:** ЗоЗ:Зт4:Хө1: Худалдаа, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвд байгаа ахуйн үйлчилгээ хүчин чадлын хувьд тааруу, тармаг байрласан, хэрэглэгчдийн эрэлт шаардлагыг тэр бүр хангадаггүй, ажиллагаа нь тогтмолжоогүй зэрэг нь төвлөрсөн байргүйтэй холбоотой гэсэн бизнес орчны судалгааны дүн гарсан билээ. Ахуйн үйлчилгээ аль болохоор төвлөрүүлж, чанаржуулах, үйлчилгээнд хяналт тавихад дөхөмтэй болгох зорилгоор гол нэр төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг хангахын тулд орон нутгийн өмчийн барилгыг ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалтаар засаж тохижуулахад төслийн үйл ажиллагааг чиглүүлнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Гол нэр төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдэх
- Үйлчлүүлэгчийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ төлөвших
- Үйлчилгээний чанар хүрэлцээ сайжирч, үнэ тогтворжих

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Иргэд

**Төслийг хэрэгжүүлэгчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийн зориулалтаар засварлах барилгатай байх
- Зураг төсөв, тооцоо хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн: сая. төг:**

**Бүгд – 18.0**
- Барилга, байшин – 10.0
- Засвар үйлчилгээ – 5.0
- Материалын зардал – 2.0
- Тоног төхөөрөмж – 1.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 6.0 | | 12.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Нэг жилийн дараа төвийн үйл ажиллагаа тогтворжино

| № 33 | **Төсөл:** Зо4.Зт1.Хө1.Т1: Цэцэрлэг–Заанхошуу (Ихтамир сумынтөв ) хүртэл 31 км хатуу хучилттай зам | **Хөтөлбөр:** Зо4.Зт1.Хө1: Дэд бүтэц сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хатуу дэд бүтэц, тухайлбал зам сайжруулах нь нэвтрэлтийн шуурхай байдлыг дээшлүүлэх, зорчигч, тээвэрчдийн тав тух, цагийг хэмнэх ихээхэн ач холбогдолтой. Аймгийн төв – Цэцэрлэг хотоос Цагаан даваанны арын замыг зассан нь олны талархлыг хүлээсэн чухал арга хэмжээ болсон юм. Түүнээс цааш үргэлжлэх замыг том жижиг машины, шавар ус тойрч явдаг гэх мэтээр нэр өгч олон салаа зам гарган Тайхар чулууны орчмын болон аялал жуулчлалын гол баазууд байрладаг хамгийн үзэсгэлэнтэй, хүний нүдэнд хамгийн түрүүнд тусдаг газрын хөрс, өнгө төрхийг сүрхий муутгаж байна. Одоогоор машин явах аргагүй шахам болтлоо дэржигнүүр үүсч, үерт автан эвдэрсэн замыг сэргээн засах нь олон талын ашиг өгөх юм.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Аймгийн төвийг Ихтамир сумын төвтэй холбосон сайжруулсан замтай болох<br>• Гол зам дагаж байрласан гуанз, түр амрах байр зэрэг сумын иргэдээс эрхэлж буй үйлчилгээний газруудаар үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэх<br>• Сумын төвийн орчмын үзэсгэлэнт газрын хөрсний эвдрэлийг бууруулах, хамгаалах | • Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Засгийн газар |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Зураг, төсөв хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 650.0**<br>• Материалын зардал – 500.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 40.0<br>• Цалин, шимтгэл – 110.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | 650.0 | |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа зам ашиглалт сайжирч үр дүнг тогтворжуулна |
|---|---|

| № 34 | **Төсөл:** Зо4:Зт1:Хө1:Т2: Борт багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбох | **Хөтөлбөр:** Зо4:Зт1:Хө1: Дэд бүтэц сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн гол сүлжээ дайран өнгөрч буй таатай боломжийг ашиглах, сумын бизнесийн хөгжлийн төвлөрөл (бүх бизнес сумын төвд төвлөрсөн)–ийг сааруулах, боломжтой үйлдвэрлэл, үйлчилгээг малчид, хөдөөгийн хүн амд ойртуулахын тулд зарим багийн төвийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай байна. Ийм арга хэмжээний нэг нь Борт багийн төвийг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбох явдал юм.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Багийн төвийн хөгжил, өнгө төрх сайжирна<br>• Багийн төвийг эрчим байнгын эрчим хүчний шугамд холбож дэд бүтцийн хангамжийг сайжруулна<br>• Зарим төрлийн бизнесийг багийн төвд байршуулж шинээр эхлэх, салбаруулах, үйлчилгээний нэгжүүд байгуулах боломж нэмэгдэнэ | **Зорилтот бүлэг:**<br>• Сумын ЗДТГ |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>· Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>· Шинээр шугам татах зураг төсөл хийгдсэн байх<br>· Багийн төдийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 10.0**<br>• Материалын зардал – 8.5<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 0.5<br>• Цалин, шимтгэл – 1.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | 5.0 | 5.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 8 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэнээр үр дүнг тогтвортой ашиглах бүх боломж бүрдэнэ |
|---|---|

| № 35 | **Төсөл:** Зо4.Зт2.Хө1.Т1: Сумын төвийн хөгж–лийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | **Хөтөлбөр:** Зо4.Зт2.Хө1: Сумын төвийн тохижилт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Боловсруулах ЖДҮ, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний нөхцлийг сайжруулах, зам талбай засварлаж тохижуулах, орон сууц шинээр барих, дэд бүтцийг сайжруулах болон тохижилтын олон чиглэлтэй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх учраас сумын төвийг хөгжүүлэх ерөнхий асуудлыг төлөвлөгөөжүүлэх шаардлагатай байна. Сумын төвийн хөгжлийн хэтийн чиглэлийг сумын ЭЗХ–ийн стратегид тусгасан хөгжлийн чиглэлтэй уялдуулах арга замыг тодорхойлох явдал төслийн үзэл баримтлал, гол чиглэл байх болно. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсноор сумын эдийн засаг–бизнесийн хөгжлийн эрх зүйн орчныг сайжруулахад чухал суурь баримт бичигтэй болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болно
- Сумын төвийн өнгө төрх сайжирч, хотжилт, тосгоны хэв маягт шилжих эхлэл тавигдана
- Үндэсний болон аймаг, бүс нутгийн хөгжлийн чиг баримжаа, төлөвлөгөөтэй сумын хөгжлийг нягт уялдуулах боломж бүрдэнэ

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Сумын төвийн оршин суугчид
- Байгууллага, аж ахуйн нэгжүүд

**Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Сумын төвийн оршин суугчид
- Байгууллага, аж ахуйн нэгжүүд

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Засгийн газар
- Хандивлагчид
- Мэргэжлийн байгууллагууд

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Сумын ЭЗХ–ийн стратегид тусгагдсан байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 5.6**
- Цалин, шимтгэл – 2.0
- Сургалт – 1.0
- Мэдээлэл, сурталчилгаа – 1.0
- Судалгаа, шинжилгээ – 1.6

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.6 | | 5.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссаны дараа тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг тогтвортой ашиглана

| № 36 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө2:Т2: Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, тохижилтийг хийх | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө2: Сумын төвийн тохижилт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын төвийн гол хэсэгт төр захиргааны ба төрийн үйлчилгээний албан байгууллага, соёлын төв, үйлчилгээний газрын барилга, орон сууц байршдаг боловч гудамж, талбай зориудын гэрэлтүүлэг байхгүй. Түүнчлэн гэр хорооллын гэрэлтүүлгийн асуудал үндсэндээ шийдвэрлэгдээгүй явж ирсэн гэж болно. Иймд сумын нүүр царайг илэрхийлэх гол талбай, төв замын дагуу гэрэлтүүлэг тавих, гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэх зэрэг тохижилтын асуудлыг нэг мөр шийдвэрлэх төсөл хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж сумын олон нийт үзсэн юм. Гэрэлтүүлгийг сайжруулах нь гэмт хэрэг, хууль бус үйлдлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтойн гадна иргэдийн сэтгэл ханамж, тав тухыг дээшлүүлэхэд чухал юм.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:** |
|---|---|
| • Сумын төвийн тохижилт, өнгө үзэмж сайжирна<br>• Гэр хорооллын нөхцөл сайжирна | • Сумын ЗДТГ<br>• Сумын төвийн оршин суугчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Иргэд, оршин суугчид<br>• Аж ахуйн нэгж, байгууллага<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Айл өрхүүд, байгууллага<br>• Хандивлагчид<br>• Иргэний нийгмийн байгууллага |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Төвлөрсөн эрчим хүчний сүлжээнд холбогдсон<br>• Ажиллах хүчний нөөцтэй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Нийтийн эзэмшлийн зүйлсийг хамгаалахгүй байх |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 9.7**<br>• Материалын зардал – 4.7<br>• Тоног төхөөрөмж – 3.0<br>• Цалин, шимтгэл – 2.0 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| | 2.0 | 7.7 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:** Сумын байгууллага, бизнес эрхлэгчид, иргэдийн оролцоотойгоор үр дүнг тогтвортой ашиглана |
|---|---|

| № 37 | **Төсөл:** Зо1:Зт1:Хө2:Т2: Дэмид жанжны нэрэмжит талбай байгуулах | **Хөтөлбөр:** Зо1:Зт1:Хө2: Сумын төвийн тохижилт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын ИТХ, ЗДТГ–ын урьд байрлах барилгажсан хэсгийн төвд Монгол улсын цэргийн нэрт зүтгэлтэн, тус сумын уугуул жанжин маршал Г. Дэмидийн дурсгалын гэрэлт баганыг 2000 онд сумын иргэд, сайн санаат хүмүүсийн хандив дэмжлэгээр байгуулсан юм. Тусгайлан зассан талбай байгуулаагүй, гэрэлтүүлгийн асуудлыг тохижуулаагүй учраас гадаад өнгө үзэмжийн хувьд ялгарах онцлог зүйл багатай, хүнд бахархал мэдрэмж төрүүлэх хэмжээнд тохижигдоогүй болно. Сумын иргэдийн тодорхой хэсэг нь жанжин Г.Дэмидийн хөшөөний орчмыг талбай болгон өргөтгөн тохижуулах хүсэлтийг сумын захиргаанд удаа дараа тавьсаар ирснийг харгалзан энэхүү төслийг стратегид тусгаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумын төвийн гол хэсгийн үзэмж сайжтрна
- Иргэдийн хүсэлт, эрэлтэд нийцсэн шинэ талбай байгуулагдана

**Зорилтот бүлэг:**
- Сумын төвийн оршин суугчид, иргэд
- Г.Дэмидийн төрөл төрөгсөд

**Төслийн хамтран хэрэгжүүлэгчид:**
- Сумын төвийн оршин суугчид
- Аж ахуйн нэгж байгууллага
- Сумын ЗДТГ

**Төсөлд хувь нэмэр оруулах боломжит оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Г.Дэмидийн ах дүү, төрөл төрөгсөд
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Талбай шинээр байгуулах газар бэлэн
- Иргэд дэмжлэг үзүүлэх чин эрмэлзэлтэй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:**

**Бүгд – 8.7**
- Засвар үйлчилгээ – 1.7
- Материалын зардал – 3.9
- Тоног төхөөрөмж – 1.3
- Цалин, шимтгэл – 2.0

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.2 | 3.0 | 3.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

**Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил

**Төслийн үр дүнгийн тогтворжилт:**
Шинэ талбайг тогтвортой ашиглах боломжтой

| № 38 | **Төсөл:** Зо4:Зт1:Хө1:Т4: Сумын төвийн хог хаягдлыг цэвэрлэх, боловсруулж устгах | **Хөтөлбөр:** Зо4:Зт1:Хө1: Сумын төвийн тохижилт |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Ихтамир сумын нийт хүн амын 33% нь сумын төвийн орон сууцны ба гэр хороололд оршин суудаг. Түүнээс гадна нэгдсэн халаалт, жижиг үйлдвэр зэрэг хог хаягдал ихээр гаргадаг байгууламжууд хэд хэд бий. Байгаль орчныг ихээр бохирдуулж, сумын төвийн үзэмж, оршин суугчдын эрүүл мэндэд таагүй нөлөөлж буй сумын төвийн ахуйн хог хаягдлын менежментийг сайжруулах явдал байнга яригддаг тулгамдсан асуудлын нэг болоод байна. Сумын төвийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах, бололцоотойг нь цуглуулан авч жижиг бизнесийн хэлбэрээр боловсруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх зүйтэй хэмээн олон нийтээс гаргасан саналыг үндэслэн энэхүү төслийг стратегид тусгалаа.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Сумын өнгө үзэмж сайжирна<br>• Ажиллах амьдрах эрүүл орчин бүрдэнэ. | • Сумын төвийн оршин суугчид<br>• Төв замаар дайрч өнгөрөх хүмүүс<br>• Жуулчид, аялагчид |
| **Төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Сумын төвийн оршин суугчид<br>• АА–н нэгж, байгууллагууд<br>• Сумын ЗДТГ | • Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Ажиллах хүч хүрэлцээтэй<br>• Ердийн хөсөг ашиглах боломжтой | • Хүмүүсийн идэвхи оролцоо сул байх<br>• Санхүүжилт дутагдах |
| **Шаардагдах санхүүжилтийн дүн, сая төг:** | **Бүгд – 9.7**<br>• Барилга байшин – 2.0<br>• Материалын зардал – 2.0<br>• Тоног төхөөрөмж – 2.0<br>• Тээвэр, холбоо, цахилгаан – 2.0<br>• Цалин, шимтгэл – 1.7 |

| Орон нутгийн хөрөнгө | Төсвийн хөрөнгө | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | | 8.7 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Санхүүжилт олгогдсоноос хойш 4 сар | **Төслийн үр дүнгийн тогтворжилт:**<br>Үр дүнг тогтвортой ашиглах хугацаа төсөл дууссанаас шууд эхлэнэ |
|---|---|